

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

/2009 оны үйл ажиллагааны үр дүн /

	Үзүүлэлт	үр дүнгийн үнэлгээ		
		Хувь	оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт /2009 онд хүрэх түвшин 40 хувь/	41.7	5.0
		2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /2009 онд хүрэх түвшин 40 хувь/	48.05	5.0
		3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	77.8	3.89
Үнэлгээний дундаж оноо 4.6				
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1. Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	81.25	4.1
		2. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	82.8	4.1
		3. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	94.4	4.7
		4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /2009 онд хүрэх түвшин 50 хувь/	43.7	4.3
Үнэлгээний дундаж оноо 4.3				
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	85.0	4.2
		2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	85.42	4.3
Үнэлгээний дундаж оноо 4.0				
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал	88.57	4.4
		2. Хүний нөөцийн ил тод байдал	85.0	4.3
		3. Төсөв санхүүгийн ил тод байдал	75.7	3.8
		4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	86.0	4.3
Үнэлгээний дундаж оноо 4.2				
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1. Эдийн засгийн нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	87.3	4.4
		2. Хэрэглэгчийн үнэлгээ	80.0	4.0
Үнэлгээний дундаж оноо 4.0				
Ерөнхий үнэлгээ		86.0	4.0	

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2009 оны үйл ажиллагааны үр дүн, цаашдын үйл ажиллагаанд анхаарах асуудлыг тодорхойлох зорилгоор хяналт шинжилгээ үнэлгээ хийв.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнд Хяналт шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 13-ны 11 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын “Тогтоол хэрэгжүүлэх асуудлаар чиглэл өгөх тухай” 135 дугаар албан тоотын хүрээнд хийсэн болно.

Нэг. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ**1.1 ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ**

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 75 үйл ажиллагааг 41.7 хувьтай хэрэгжүүлж эхлээд байна.

Энэ онд шинээр ажлын байр бий болгохдоо дунд давхарга буюу хөдөлмөр эрхлэх сонирхол бүхий иргэдийг дэмжих бодлого баримтлалаа. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл”-ийг Монгол шуудан, ХААН, Хас банкаар, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-ийг дэмжих зээлийг Тэгш дүүрэн хөтөлбөрөөр, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зээл”-ийг Жижиг дунд үйлдвэрийн сангаар дамжуулан олгожээ.

ЖДҮСангаас 64 иргэн, ХЭДС-ийн зээлээр байнгын ажлын 57 байр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зээлээр 34, жижиг зээлээр 52 иргэн зээл авч үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээгээр улирлын чанартай 90 ажлын байр бий болсон.

Аж ахуй нэгж байгууллага хувь хүмүүсийн хөрөнгөөр шинэ байнгын 150 ажлын байр тус тус бий болсон байна

ХХҮХ-т бүртгэлтэй 113 ажилгүйчүүд байснаас 1028 хүн шинээр бүртгэгдэж 52 хүн бусад шалтгаанаар хасагдаж 932 хүн сул чөлөөлөгдсөн ажлын байранд зуучлагдан хугацааны эцэст 157 ажилгүйчүүд болж ажилгүйдлийн түвшин 3.5 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 хувиар өссөн нь хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо өссөнтэй холбоотой юм.

Аймгийн МСҮТ, БСГ, Улаач чандмань, Футур сургалтын төвтэй гэрээ байгуулж 168 хүнийг мэргэжил олгох сургалтанд хамруулан эксковаторчин, гагнуурчин, автозасварчин, үсчин, тогооч, шатахуун түгээгч зэрэг мэргэжил олгож 1.7 сая төгрөг, Улаанбаатар хотын Мэдлэг, Оргилуун, Футур сургалтын төвөөс орон нутагт зохион байгуулсан тус сургалтанд 82 хүн хамруулан сургалтын ба хоол унааны зардалд нийт 5.1 сая төгрөг зарцуулсан

Аймгийн удирдах ажилтны жендерийн харьцаа нь дээд болон дунд шатны шийдвэр гаргах түвшинд тэнцүү байна. Харин гүйцэтгэх ажилтны хувьд эмэгтнийчүүд давамгайлж байна.

2009 онд Боловсролын хамран сургалтаар бага боловсролд хамрагдагсад 100 хувь, сургуулийн өмнөх боловсрол олголт өмнөх оноос 10,8 хувиар өсөж, суурь боловсрол олголт жилээс жилд ахисан үзүүлэлттэй байна.

Ерөнхий боловсролын сургуулийг шаардлагатай мэргэжлийн багшаар хангах бодлого баримталж ажилласны үр дүнд мэргэжилтэй багшийн хангалт 99,6 хувьд хүрлээ. Одоо багш нарыг чадваржуулахад анхаарч байна.

Ерөнхий боловсролын стандартын түвшин тогтоох шалгалтаар суурь боловсролын түвшин 69,5 , бүрэн дунд боловсролын түвшин 76,3 байгаа нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна

Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастаер төлөвлөгөө болон Говьсүмбэр аймгийн боловсролын салбарыг 2007-2010 онд хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөний дагуу 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжих ажлууд хийгдсэн.

Дэлхийн зөн олон улсын байгууллага, Боловсролын хөтөлбөрийн хүрээнд зүүн бүсийн аймгуудын сургуулийн сурагчдын дунд англи хэлний “ Хөгжилтэй математик “ бүсийн олимпиад, “Монгол бичиг “ –ийн аймгийн олимпиадыг зохион байгуулж нийт 104 багш, сурагчид оролцлоо.

“Зургаан настан, 1 дүгээр ангитай ажиллах сургалт”, “Боловсролын шинэчлэлд багшийн үүрэг “, Ерөнхий боловсролын 12 жилийн 7-р ангийн шилжилтийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй”, “12 жилийн сургуульд мөрдөх стандарт төлөвлөгөө хөтөлбөрийн талаар баримтлах бодлого”, зэрэг сургалтанд нийт 101 багш нар хамрагдаж сургалтын арга зүйд суралцлаа

БСШУЯ-ны захиалгаар “Golden Bridge “ төвийн хэрэгжүүлж байгаа “ Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх” төслийн хүрээнд аймгийн нийт гадаад хэлний багш нар онлайн болон вакуумжуулсан сургалт, 12 жилийн тогтолцоонд шилжихтэй холбоотой сургалтанд **69** багш хамрагдаж, улмаар шилжилтийн 7 дугаар ангийн хөтөлбөрийг боловсруулсан.

ЕБС-ийн хамран сургалт **100** хувь болж, стандарт хангалтын түвшин жил тутам өсч мэргэжлийн сургуульд элсэгчдийн тоо нэмэгдэж байна.

Эх нялхсын эрүүл мэндэд онцгой анхааран “Мянганы хөгжлийн тунхаглал”-д нийцүүлэн нялхсын эндэгдэл, эхийн эндэгдлийг бууруулах стратеги төлөвлөгөөний дагуу жирэмсэний хяналтыг эрт тогтоох, жирэмслэлтэй холбоотой эмгэгийн оношлогоог сайжруулах бодлого барьж 2005-2010 онд эхийн эндэгдлийг бууруулах аймгийн стратеги төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэний үр дүнд манай аймаг сүүлийн 3 жил эхийн эндэгдэлгүй аймаг болсон.

Хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулах зорилгоор “Халдварт бус өвчнийг бууруулах, хянах” хөтөлбөрийг аймгийн БТСХороотой хамтран хэрэгжүүлж байна.

Аж ахуйн нэгж байгууллагууд сар болгон тодорхой сэдвийн дор нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион явуулж байна.

Тус аймагт Чойрын эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэр технологийн парк байгуулах мастер төлөвлөгөөг “Мон Инженкон” ХХК боловсруулж, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг шаардлагатай мэдээллээр хангах бололцоог бүрдүүлэх зорилготой ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2007 оны 10 сарын 31-ний өдрийн А/267 тоот захирамжаар Баянтал сумын Чойрын эдийн засгийн чөлөөлт бүсийн 1300 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмших эрхийг олгож бүсийн захирагчийн ажлын албаны зориулалтаар улсын төсвөөс 156 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, Баянтал суманд 5 давхар байрны 1 орцыг иж бүрэн засварлаж, улсын комисс хүлээн авсан. Гэвч чөлөөт бүс үйлдвэр технологийн парк байгуулах асуудал тодорхой бус болоод байна.

ЖДҮ-ийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжилтийг зохион байгуулж байна. Энэ хүрээнд эсгий боловсруулах, төмс, хүнсний ногоо тариалах, оёдол модон эдлэл, төмөр хийц, ноос боловсруулах, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 64 төсөлд 737.6 сая төгрөгийн зээл олгох ажлыг эхлүүлээд байна. Одоогоор зээлдэгчдийн 80 гаруй хувь нь үйлдвэрлэлээ эхлээд байна. ЖДҮ эрхлэгчдэд зориулж “Бизнесеэ эхэл”, “Бизнесийн хөгжил” цуврал сургалтуудыг зохион байгуулж, аймгийн үйлдвэрлэл болон бизнес эрхлэгчдийн зөвлөгөөнийг хийж, 2010 оны “Бизнесийн шинэтгэлийн жил”-д хийх ажлын чиглэл, зорилгоо тодорхойллоо

Орон нутгийн түвшинд иргэдээ хүнсний аюугүй эрүүл ахуйн стандартад тохирсон бүтээгдэхүүнээр хангах зорилгоор хүн амын махны хэрэгцээг 100 %, төмс хүнсний ногооны 21 %-ийг дотоод үйлдвэрлэлээр хангаж байна. Эрчимжсэн аж ахуйн эхлэлийг тавьж Сүмбэр сумын “Тэвшийн ус” хоршоо “Сүмбэр айраг” хоршоо хүнсний болон малын тэжээлийн тариаланг эрхэлж байна. “Сүмбэр айраг” хоршоо нь малын тэжээлийн ургамал тариалах зорилгоор ХХААХҮЯамнаас 13.5 тн малын тэжээлийн үр авч 15 га газарт тариалж 61.2 тн ургац хураан авсан. Сүмбэр айраг хоршоо нь эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр усалгаатай тариалан эрхэлж, 60 га талбайтай болж 15 га газар тэжээлийн ургамал тариалж, сүүний чиглэлийн үхэр үржүүлэх бэлтгэл ажлаа хангаад байна. Аймгийн хэмжээнд мал аж ахуй, газар тариалангийн бүс нутгийг тогтоож, эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтаар 28 га газрыг иргэд аж ахуйн нэгжид эзэмшүүлээд байна. Шивээ-Овоогийн уурхайн ус шүүрүүлэх байгууламжийг түшиглэн 30

га-д тариалалалт хийх услалтын системийн зураг төслийг хийх талаар салбарын яамтай хамтран ажиллаж байна. Аймгийн МСҮТ-ийн дэргэд жимс, жимсгэний мод тариалах сургалтын талбай бий болгож, 0.3 га-д 400 ш суулгац суулгаж, жимс жимсгэний тариаланг эхлүүлэх алхам хийлээ.

“Каракуль” хонины удмын санг хамгаалах, тогтвортой өсөлтийг хангах чиглэлээр аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж байна. Одоогоо Сүмбэр каракуль үүлдрийн хонины тоо толгойг өсгөх зорилгоор 977 толгой каракуль хоньтой орон нутгийн “Цөм сүргийн үржлийн төв”-ийг байгуулан ажиллуулж байна. Цаашид Сүмбэр каракуль хонийг удам дамжуулан өсгөн үржүүлэх, тоо толгойг нь өсгөх, генфондыг сайжруулах зорилгоор үржил селекцийн ажлын үр дүнг сайжруулах, каракуль арьсны зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах зорилготой ажиллаж байна.

Манай аймаг нь дэд бүтцийн асуудал бүрэн шийдвэрлэгдсэн аймгийн нэг бөгөөд цаашид харилцаа холбоог орчин үеийн дэвшилтэт технологүүдэд түшиглэн улам боловсронгуй болгож хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Байгаль орчны салбарын хэмжээнд 2009 оныг “Байгаль хамгаалагчдыг чадавхижуулах” жил болгон зарлаж Засаг даргын 2009 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/25 тоот захирамжаар жилийн ажил зохион байгуулж төлөвлөгөө гарган ажиллаа.

Хог хаягдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч 15449 га нийтийн эдэлбэр газрын 11784.5 тн хог хаягдлыг, 2.51 га барилгын туурь хогтой талбайн 12617 тн хог хаягдлыг цэвэрлэж орон нутгаас 11.9 сая төгрөг зарцуулж мөн 13 га талбайд 4.0 сая төгрөгөөр 9262 мод бут тарьж 80 хувьтай ургуулаад байна.

Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 3,0 сая төгрөг зарцуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулж “Чойр оргил” хоршоог шалгаруулан Сүмбэр сумын “Гүн шанд”, “Өгөөмөрийн гол”-ын эхийн 0,35 га талбайг хашсан.

Төрийн албаны, ялангуяа ерөнхий менежерийн стратегийн төлөвлөлтийн чадамжийг сайжруулах зорилгоор Удирдлагын академиас л.Отгонтуяа багшийг урьж ирүүлж Ерөнхий менежерүүд, боловсролын удирдах ажилтнуудад бизнес төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт сургалт явуулсан. Байгууллагууд бизнес төлөвлөгөөнийхээ дагуу үйл ажиллагаагаа төлөвлөж тавьсан зорилтоо хэрэгжүүлэхэн ажиллаж хэвшээд байна. Төрийн албаны зөвлөлөөс мэргэжилтэн урьж ирүүлж сумдын ЗДТГ, ИТХ, зарим цэцэрлэгүүд бизнес төлөвлөгөөгөө хийлгэсэн.

Төрийн албаны гүйцэтгэлд үндэслэн удирдах чадавхийг бэхжүүлэхэд онцгой анхаарч “Удирдах ажилтнууд”-ын ажлыг бодитой дүгнэж, үр дүнд чиглэсэн үйл ажиллагааг нь дэмжих чиглэл барьж байна. Ерөнхий менежерүүдийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлсэн байдлыг

дүгнэдэг журам гаргаж, биет болон мөнгөн хөрөнгийн ашиглалт, хүний нөөцөө чадваржуулж хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг газар дээр нь үзэж нарийн дүгнэж байна.

Аймгийн Засаг даргатай 16 байгууллагын Ерөнхий менежер үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан.

Төрийн албаны бодлогын мэдээлэлд, дүн шинжилгээ, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг хөгжүүлэх зорилгоор ХШҮ-ний тасгийг байгуулж, тасгийн дарга, мэргэжилтнийг Өмнөговь аймаг, Удирдлагын академид зохион байгуулагдсан сургалтуудад хамруулж үйл ажиллагааг нь жигдрүүлээд байна.

Төрийн албаны удирдах албан тушаалтан, ялангуяа ерөнхий менежерийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах ажлын хүрээнд Төрийн албаны удирдах ажилтны болон төсвийн байгууллагын Ерөнхий менежерийн сул ажлын байрыг нийтэд нээлттэй зарлан сонгон шалгаруулалт явуулж хэвшлээ. Өнгөрсөн онд төрийн захиргааны албаны удирдах ажилтны 10, Ерөнхий менежерийн 5 ажлын байранд сонгон шалгаруулалт явуулж өндөр оноо авсан иргэний нэрийг томилох эрх бүхий этгээдэд санал болгож томилууллаа.

Дотоод шийдвэр нь ил тод, ажлын гүйцэтгэлд чиглэсэн суралцагч байгууллага хөгжүүлэхэд илүү анхаарч төрийн байгууллага, албан тушаалтныг төрийн үйлчилгээ үзүүлэх сэтгэлгээнд өөрчлөлт оруулахыг зорьж байна. Байгууллагын үйл ажиллагаа, санхүү, хүний нөөцийн асуудлыг нээлттэй байхад анхаарч гарч байгаа шийдвэрт хэлтсүүд, болон шийдвэрт холбогдогч талуудаас санал авч гаргаж байна.

Иргэдэд үйлчилгээг ойртуулж, ажлаа танилцуулах, үйлчилгээнийхээ дүрэм, журмыг ойлгуулах, тэдний санаа бодлыг сонсож, ажилдаа тусгах зорилгоор нээлттэй өдөрлөг, нэг цонхны үйлчилгээ, FM ярилцлага, хувиарын дагуу айл өрхөөр орох гэх мэт олон талт арга хэмжээг зохион байгуулж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хүний нөөцийн асуудал хэлэлцэж, төрийн байгууллага бүрийг суралцагч байгууллага байхаар шийдвэрлэсэн. Төрийн албаны тухай хуулийн дагуу байгууллагууд *Сургалт* хөтөлбөртэй болж ажлын байран дээр сургалтын олон хэлбэрийг ашиглаж байна.

Ажлын байран дээр Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хууль, Төрийн албаны стандарт болон төрийн албан хаагчийн ёс зүй зэрэг хүний нөөцийн удирдлагын чиглэлээр сургалтууд зохион байгуулсан.

АЗДТГазар өнгөрсөн онд Хүний нөөцийн удирдлагаар 6 удаа 159 төрийн албан хаагчид сургалт явуулсан байна

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх замаар төрийн албыг үе шаттайгаар цомхон чадварлаг болгож, зохистой хэмжээнд хүргэх ажлыг байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах ажлыг төлөвлөлтөөс нь

эхэлж, ажлуудыг уялдуулах арга хэмжээ авч байна. Сумдын ЗДТГ-ын орон тоог нэг бүрчлэн баталж өгч, аймаг, сумын ЗДТГ-ын ажлын хийдэгдэл, давхардалыг арилгасан.

Төрийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар жилд 450-500 хүн буюу насанд хүрсэн хүний 5 хүртэл хувиас санал асуулга авч нэгтгэж, дүнг ХЭГ-т тайлагнадаг. Энэ жил Судалгааны *Прогноз* төвөөр энэ судалгааг хийлгэсэн.

Төрийн албаны тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой түр ажиллаж байсан хүмүүсийг албан тушаалаас нь чөлөөлүүлж нөөцөд бүртгэлтэй иргэдээс сул ажлын байр гарсан тохиолдолд нөхөн томилж хэвшиж байна. Манай аймагт хууль бусаар түр томилогдон ажиллаж байгаа албан хаагч байхгүй байгаа.

Нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн төсөл боловсруулахдаа мэргэжлийн байгууллагуудын болон иргэд, олон нийтийн саналыг тусгах чиглэл баримталж ажилладаг. Бодлогын болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний шийдвэрийн төсөлд олон нийтээс санал авч 2 шийдвэр гаргасан.

Аймгийн Засаг даргын гаргасан 444 захирамжийг Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс болон бусад бүх хэлтсийн дарга нар хянаж, санал дүгнэлт өгч хэвшээд байна.

Сумдын Засаг дарга нарын 526 захирамжийг хянаж, зөрчилтэй 51 захирамжийг хуулийн дагуу өөрсдөөр нь засуулсан.

Засгийн газрын 8 дугаар тогтоолын дагуу Хууль зүй дотоод хэргийн яаманд хянуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн 2 захирамж байна.

Батлагдсан журмын дагуу www.legalinfo.mn –ээс 1250 хүн, 132 байгууллагад нийт 1382 удаа лавлагаа мэдээлэл өгч, гар сангаас 1610 хүн, 310 байгууллагад нийт 1910 удаа лавлагаа, мэдээлэл өгсөн. Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааг 161 удаа 250 сэдвээр зохион байгуулж, 5955 хүнийг хамруулсан.

Гэмт хэргийн улмаас бусдад учруулсан 115,3 сая төгрөгийн хохирлын 91,8 төгрөгийг нөхөн төлүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг иргэдэд ойр байлгах, гүйцэтгэх хуудас бүрт ажиллагаа хийж, хуулийн хугацаанд төлбөрийг барагдуулахыг зорьж ажилласнаар 2009 онд шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийг 71,2 хувьд, мөнгөн дүнгийн бодит биелэлтийг 61,3 хувьд хүргэж өнгөрсөн оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны бодит биелэлтийг 2,3 хувиар бууруулж, мөнгөн дүнгийн бодит биелэлт 0,4 хувиар өслөө.

Орон нутгийн түвшинд хүн амын амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх үүргийг мэргэжлийн байгууллагууд өөрийн эрх хэмжээ, чиг үүргийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль эрх зүй, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулан явуулах өрөөг тохижуулан үйл ажиллагааг тогтмолжуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн конвенцийг бүх сумдын Засаг даргын Тамгын газарт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонд хүргүүлэн ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд амьдрах ухааны сургалтуудыг зохион байгуулан 50 гаруй хүнийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны оёдолчин иргэд аймгийн МҮСТ-ийн 500 оюутны ажлын хувцсыг тогтмол оёж нийлүүлж байна.

Төрийн бус байгууллагуудыг төлөвшүүлэх, хамтын ажиллагааг сайжируулах зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн бус байгууллагуудтай ИТХ-аас 2 удаа, аймгийн Засаг даргаас 4 удаа уулзаж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, харилцан мэдээлэл солилцож, тэдний үйл ажиллагаанд 4.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Тендерийн болон бусад 7 ажлын хэсэгт ТББ-ын төлөөллийг оролцуулж ажилласаны үр дүнд бага оврын автобусны үйлчилгээг орон нутагт нэвтрүүлж, таксины үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалтанд оруулсан.

Орон нутагт явагдах хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг орон нутгийн бизнес эрхэлдэг байгууллагуудаар гүйцэтгүүлэх аймгийн Засаг даргын 2009 оны 9 сарын 14-нд А/315 тоот захирамж гаргасан. Энэ шийдвэрийн үр дүнд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 500 оюутны ажлын хувцсыг аймгийн оёдолчид, Үдийн цай хөтөлбөрийг аймгийн компани, албан хэргийн материалыг Бизнес дэмжих компани, барилгын засвар үйлчилгээг орон нутгийн компаниуд хийж гүйцэтгээд байна.

Иргэний баримт бичгийг цахимжуулж иргэний үнэмлэхэнд хувь хүний талаархи шаардлагатай мэдээ мэдээллийг агуулсан нууцлал бүхий цахимжуулсан иргэний үнэмлэхийг улсын хэмжээнд шинээр олгож эхлэхтэй холбогдуулан аймгийн хэмжээнд бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Солбилцол, зураг зүйд тулгуурласан Хаягжилтын системийг бий болгох замаар эд хөрөнгийн болон иргэний бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах” гэсэн заалт оруулж хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн 3 төрлийн бүртгэлийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах мэдээллийн санд баяжилтуудыг хийж, мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох хүрээнд сумдад явуулж буй бүртгэлийн үйл ажиллагааг нэг мөр болгон жигдрүүлэх иргэд, байгууллага, албан тушаалтанд үнэн зөв бодитой бүрэн мэдээллээр хангах үүднээс бүртгэлийн нэгдсэн программтай болгох шаардлагатай байна.

1.2. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2008-2012 онд хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймаг орон нутагт хамааралтай 153 үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байна.

НЭГ. ХҮН АМ НИЙГМИЙН ЗОХИСТОЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ

Зорилт: Гэр бүлийг дэмжин тэтгэх, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай орлоготой байх нөхцөл бүрдүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулна.

Хүний хөгжлийн хүчин зүйл, чадавхийг дэмжихэд шаардагдах эдийн засаг, нийгмийн орчныг бүрдүүлэх замаар нэн ядуу болон ядуу өрхийг ядуурлаас гаргах, бага орлоготой өрхийг ядууралд орохоос урьдчилан сэргийлэх бодлого барин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 73 өрхийг сонгон эдгээр өрхүүдийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх үйлчилгээнд хамруулан амьжиргаанд нь дэмжлэг үзүүлж, үүнээс 23 өрхийг Олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд хамруулан хөдөлмөр эрхлэх төслийг дэмжин 2500.0 төгрөгийн тусламж олгон өрхийн аж ахуй эрхлүүлж байна.

Мөн 59 өрхийн гишүүдийг нийтийг хамарсан ажилд хамруулан түр ажлын байраар хангаж 15 өрхийн гишүүдийг ажлын байранд зуучилж байнгын ажлын байртай болгосон ба 40 өрхийн гишүүдийг сургалтанд хамруулан мэргэжил олгосон, 8 өрхийг банкны жижиг зээлд хамруулсан, 33 өрхийн гишүүдийг асаргааны сургалтанд хамруулах зэрэг ажлуудыг зохион байгуулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон нийгмийн халамжийн үйлчилгээнүүдийг үзүүлсэн байна.

Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж 383 ажлын байр шинээр бий болсон ба үүний 293 нь байнгын ажлын байр байна. Шинэ ажлын байр бий болгоход 747413.0 мянган төгрөгийн зээл олгогдсон байна. Үүнд:-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн байнгын ажлын байр 57 бий болж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зээлээр 34, жижиг зээлээр 52 иргэн зээл авч үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байна.

Тайлант хугацааны эхэнд 113 ажилгүйчүүд байснаас 1028 хүн шинээр бүртгэгдэж 52 хүн бусад шалтгаанаар хасагдаж 932 хүн сул чөлөөлөгдсөн ажлын байранд зуучлагдан хугацааны эцэст 157 ажилгүйчүүд буюу ажилгүйдлийн түвшин 3.5 боллоо. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 хувиар өссөн нь хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо өссөн явдалтай холбоотой.

Тогтвортой амьжиргаа төсөл орон нутагт ядуурлыг бууруулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Олон нийтийн санаачилга сан бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд боловсрол, эрүүл мэнд, дэд бүтцийн чиглэлээр 69.4 сая төгрөгийн өртөгтэй 16 төслийг хэрэгжүүллээ.

Аймгийн хэмжээнд нийт 479 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжинд хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гарын авлага, дохионы хэлний толь, модон шоогоор хангасан.

Харъяалалгүй ахмад настны тоо жилээс жилд буурч байна. 14 ахмад настан гэр орон сууцаар хангагдсан байна. Ахмадууд Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд бүрэн хамрагдсан.

Сар бүр ахмадууд цуглардаг өдөртэй болж, ахмад үеийнхний авъяасыг залуу үед өвлүүлэх ажил хийгдэж байна. Албан бус секторт 30 гаруй, албан секторт 20, Хдөө аж ахуйн салбарт 173 өндөр настан ажиллаж ахмадын хөдөлмөр эрхлэлт 26.1 хувьтай байна

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг жигд сайжруулж нэр төрлийг нэмэгдүүлэх, иргэд, хамт олны идэвхитэй оролцоонд тулгуурлан хүн амыг эрүүл байлгах, орчин үеийн дэвшилтэт оношлогоо, эмчилгээний аргыг эрчимтэй нэвтрүүлэн эрүүлжүүлэх замаар дундаж наслалтыг уртасгах, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, зорилтыг хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдвал зохих хүн амын 97 хувь нь хамрагдаж аймгийн төвийн хүн амын 98 хувь нь өрхийн эмнэлэгт харъяалагдан үйлчлүүлдэг боллоо.

Төрөхийн хүндрэл, эхийн эндэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулсан төрөхийн өмнөх байрны үйл ажиллагаа тогтмолжиж жилдээ амарвал зохих хөдөөгийн эхчүүдийг 100 хувь хамруулснаар 2007-2009 онд эхийн эндэгдэлгүй ажилласан нь тус аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын томоохон амжилтын нэг юм.

0-1 насны 8 хүүхэд эндсэн ба 1000 амьд төрөлтөнд 22.2 промилль процент болж өмнөх оныхоос 4.8 промилль процентоор буурсан боловч аймаг улсын дундажаас дээгүүр байна. Энэ онд 9 нэрийн 149 халдварт өвчин бүртгэгдэж 10000 хүн амд 105.4 ногдож аймаг улсын дундажаас доогуур байгаа ба өмнөх оны мөн үеэс 173 тохиолдлоор буурлаа.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага үүсгэн байгуулах санаачлагыг дэмжин ажилласнаар одоогийн байдлаар шүдний эмнэлэг 1, эмийн худалдаа 5, Уламжлалт эмчилгээний чиглэлээр 1 эмнэлэг ажиллаж байна.

Нэгдсэн эмнэлгийн стандарт 85 хувь, сумдын эмнэлгийн стандарт 90 хувь, өрхийн эмнэлгийн стандарт 85 хувийн хэрэгжилттэй байна.

Эрүүл мэндийн байгууллагууд “Магадлан итгэмжлэл”-д бүрэн хамрагдаж хангалттай сайн үнэлгээ авсан.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийг тусад нь бие дааж үйл ажиллагаагаа эрхлэх бүрэн боломжоор хангасан ба яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдсэн. А

хүрээний H1N1 Томуугийн вирусийн халдвараар урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайн зохион байгуулж өвчилсөн тохиолдлыг дор бүр нь илрүүлэн эмчилсэнээр нас баралт гаргалгүй ажилласан.

Хүн амын өвчлөл,нас баралтыг бууруулах зорилгоор “Халдварт бус өвчнийг бууруулах,хянах”хөтөлбөрийг аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран хэрэгжүүлж байна. Засгийн газрын “Нийтийн биеийн тамир,спортын талаар авах арга хэмжээний тухай” 2009 оны 5-р тогтоолын дагуу аймгийн засаг даргын А/57 тоот захирамжийг гарган аж ахуйн нэгж байгууллагууд сар болгон тодорхой сэдвийн дор нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион явуулж байна.аймгийн хэмжээнд “Биеийн тамир-Эрүүл мэнд” уриан дор зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө болон хариуцан ажиллах байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг даргын А/109 захирамжаар байгуулан ажиллуулж байна

Жилийн хүн амын цэвэр өсөлт 2.3 хувь,дундаж наслалт 69 байна.

Аймгийн хэмжээнд Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 75 хувь, бага боловсролын хамран сургалт 100 хувь, суурь боловсролын хамран сургалт 98 хувьтай , Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт өмнөх оныхоос 10,8 хувиар ахисан байна.

2009 онд Соёл, урлагийн байгууллагуудаас үйлчилгээ хүртсэн үйлчилүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 20681 –д хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2287 үзэгчээр өслөө.

2008-2009 оны хичээлийн жилд 9-10 ангийг 523 хүүхэд төгсөн суурь боловсролыг 245, бүрэн дунд боловсролыг 278 хүүхэд эзэмшиж, их дээд , сургуульд элсэн суралцлаа.

Боловсролын байгууллагын материаллаг бааз бэхжиж багш сурагчдын сурч хөдөлмөрлөх таатай орчин бүрдсэн.

Аймгийн бүх сургуулиуд мэргэжилтэй багш нараар үндсэндээ хангагдаж мэргэжилтэй багшийн хангалтын түвшин 99,6 хүрлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт 100 хувь болж, стандарт хангалтын түвшин жил тутам өсч мэргэжлийн сургуульд элсэгчдийн тоо нэмэгдэж байна.

ХОЁР. ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТ

Зорилт: Эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшинг улам бататган, үйлдвэржилтийн бодлогыг тууштай дэмжиж, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, тээвэр, холбоо, нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээг сайжруулан, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгоно.

Монгол Улсын Засгийн газраас 2009 оныг үйлдвэржүүлэх жил болгон аймаг орон нутгийн эдийн хөгжлийг дээшлүүлэх зорилгоор аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санд 782.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 45-р тогтоолоор төсөл шалгаруулах комисс байгуулан 142 төсөл хүлээн авч 94 төслийг дэмжин харилцагч Хас банкинд хүргүүлсэн.

Хас банк төслүүдийг судлан худалдаа үйлчилгээний 20, ахуй үйлчилгээний 12, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 15, хөнгөн үйлдвэрлэлийн 7, барилгын материалын 4, хүнсний үйлдвэрлэлийн 5, эм биобэлдмэлийн 1, нийт 64 төсөлд 727.6 сая төгрөгийн зээл олголоо.

Төсөл хэрэгжүүлж байгаа нийт зээлдэгчийн 90 орчим хувь нь зориулалтаар, үр ашигтай зарцуулж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр зээл авсан “Сүмбэр айраг” хоршоо төмс хүнсний ногоо тариалж, 200 тонны багтаамжтай стандарт хангасан зоорь ашиглалтад оруулсан бол “Сүмбэр хонь” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 280 хонь худалдан авч зохиомол хээлтүүлэг хийж “Каракуль” хонины үүлдэр угсааг сайжруулж тоо толгойг өсгөх үйл ажиллагаа явуулж байна.

Нийтийн ахуй үйлчилгээний чиглэлээр “Хими цэвэрлэгээ, халуун ус, саун”, “Хивс цэвэрлэгээ”, “Гэрэл зураг”, “Үсчин гоо сайхан” “Оёдлын үйлдвэрлэл” зэрэг, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр “Модон эдлэл”, “Дугуй засвар”, “Гэр ахуйн тавилга”, “Эсгий үйлдвэрлэл” зэрэг төслүүд амжилттай сайн хэрэгжиж байна.

2009 онд зээлийн эх үүсвэр, харилцагч банкны сонголт оройтож шийдэгдсэн, зээл хүсэгч иргэдийн төсөл бичих ойлголт тааруу, аж ахуй нэгж иргэдийн чадвар сул, мэргэжлийн ажиллах хүчин дутагдалтай, 20.0 сая төгрөгнөөс дээш зээлийг төвдөө шийдэх болсон зэрэг шалтгаанаар зээлийн олголт удааширсанаас 54.9 сая төгрөг буцсан.

Засгийн газраас дэвшүүлсэн үйлдвэржүүлэх бодлогын хүрээнд орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл нэмэгдэж, иргэдийн орон нутагтаа ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэж, ажилгүйдэл, ядуурал зохих хэмжээгээр буурч, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт өсч байгаа нь харагдаж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Аж ахуйн нэгжүүдийг дэмжих, ажлын байр бий болгох зорилгоор аймгийн Засаг даргын 2009 оны А/315 тоот захирамжаар “Хөрөнгө оруулалтын тендер”- ийг орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдэд олгосон.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 53.5 сая төгрөгийн ажлыг Баянтал сумын “Талын илч” ОНӨҮГ, “Илчлэг-шивээ” ОНӨҮГ, “НБА” ХХК, “Лакидент” ХХК, “Боржигин хүч” ХХК-ууд, Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 107.3 сая төгрөгийн ажлыг “Лакидент” ХХК, “Сүмбэр гүн” ХХК, “Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн төв, Говь-гоё хийц ХХК –ууд, Үдийн цай хөтөлбөрийн 83.0 сая төгрөгийн ажлыг “ОЖС” ХХК, “ХЛЕ” ХХК, “Гэээгт” ХХК, “Говь-гео”

ХК, Төмөр замын худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний “Чойр” төв зэрэг орон нутгийн компаниуд гүйцэтгэсэн.

Шивээ-Овоо ХК нь 2009 онд 1719.1 мянган м³ хөрс хуулалт хийж , 1403.2 мянган тонн нүүрс гаргаж, 16167.8 сая төгрөгийн нүүрс борлуулж 15121.0 сая төгрөгийн зардал гаргаж 1.081 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Говь гео ХХК нь 2009 онд геологи хайгуулын салбарт 9357 га газарт эрэл зураглал, болон уул өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгэн, 1945.7 сая төгрөгийн зарлага гаргаж, 1603.4 сая төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд Улсын төсөвт 281.4 сая төгрөг төвлөрүүлж, аймагт 72.9 сая төгрөгийн татвар төлсөн.

Чойр өртөө 4508 воган буулгалт хийж, 2930 тн ачаа, суудлын воган өдөрт 2 удаа явж 119.290 хүн тээвэрлэж 26.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аймгийн хэмжээнд Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд, Эрдэм транс ХХК, Мандах нарны зам ХХК-ны том оврын 6 автобус өдөрт 2 удаа , “Их Боржигин ” ХХК-ны 30 такси өдөр бүр , сум хооронд “Бодь зам” ХХК-ний 5 микро автобус өдөр бүр, хот дотор “Сүмбэр хүлэг” ХХК-ний 42 такси өдөр бүр, “” ХХК-ний бага оврын автобус өдөр бүр тус тус үйл ажиллагаа явуулж иргэдийн ая тухтай байдлыг ханган, чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилж байна.

Аймгийн хэмжээнд Аймгийн холбоо, Төмөр замын дохиолол холбооны 4-р ангийн салбар, Мобиком , Скайтель, Юнитель, Жи Мобиал зэрэг үүрэн телефоны 4 оператор үйл ажиллагаагаа явуулж байна.

МЦХолбоо ХК-ний аймгийн 3 салбараар дамжуулан телефон утасны 457, КаТв-ийн 1140 , ADSL-ийн интернетийн 70 хэрэглэгчтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Төмөр замын дохиолол холбооны 4 дүгээр ангийн салбар нь телефон утасны 334, КаТв-ийн 83, интернетийн 42 хэрэглэгчтэй үйл ажиллагаагаа явуулж 117.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Мобиком , Скайтель, Юнитель, Жи Мобайль зэрэг хөдөлгөөнт холбооны 4 оператор үйл ажиллагаагаа явуулж 12905 хэрэглэгчтэй болоод байна.

Аймгийн хэмжээнд холбоо харилцааны үйл ажиллагаа иргэдэд олон сувгаар, өндөр түвшинд, шуурхай хүрч байна.

Нийтийн ахуй үйлчилгээг дэмжих бодлого барьж ажилласнаар аймгийн ахуйн үйлчилгээний төвийн байрыг аймаг хөгжүүлэх сангаас 17.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж худалдаа, үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний цогцолбор төв болгож 10 төрлийн үйлчилгээ үзүүлэх 23 ажлын байр бий болголоо.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны санхүүгийн дэмжлэгээр 2 хоршоо, ЖДҮ-ийг дэмжих зээлийн хүрээнд хөдөө аж ахуйн чиглэлээр 15 төсөл, “Тогтвортой амжиргаал” төслийн хөрөнгө, УИХ-ын гишүүний хөрөнгө оруулалт зэрэг хөрөнгөөр Баянтал суманд ноос угаах үйлдвэр, 3 суманд 24 малчны бүлэг байгуулагдаж бэлчээр хаших, булаг шандны эхийг хашиж хамгаалах, сүү сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэжээлийн

ургамал, төмс хүнсний ногоо тариалах, зоорийн аж ахуй эрхлэх, малын үүлдэр угсааг сайжруулж эрлийзжүүлэх зэрэг мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүллээ.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдийг дэмжих ажилласанаар Мөнгөний урсгалыг гадагш гаргахгүй орон нутгийн бизнес эрхлэгчийг дэмжсэнээр, Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар төлөлт урьд оныхоос 53.8 сая төгрөгөөр нэмэгдсэн.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭНЦВЭРТ ХАРЬЦААГ ХАНГАХ ЗОРИЛТ

Зорилт: Экосистемийн тэнцвэрт байдлыг хангахуйц байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх цогц бодлогыг хэрэгжүүлэн хөгжлийн тогтвортой орчныг бий болгох, түүнд түшиглэсэн аялал жуулчлалын цогц бодлого хэрэгжүүлнэ.

“Чойрын Богд” ууланд нутагшсан аргаль хонины идэш хоолонд зориулж биотехникийн арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 1546000 төгрөгийн 320 боодол өвс тавьж өгсөн байна.

10-р сард биотехнологийн хүрээлэн, БОАЖЯ-тай хамтран аргаль хонины тооллого явуулахад 150 гаруй аргаль хонь тоологдож 2007 онтой харьцуулахад 80 тоо толгойгоор өссөн дүн гарлаа.

Шивээ-Овоо” ХК-ний 1.5 га талбайд тоорой, сухай, балгана, хайлаас, хармаг биологийн нөхөн сэргээлт хийсэн.

Тайлант онд дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж “Нутгийн хайрхан”, “Чандмань Эрдэнийн Эрэлд”, “Эрүүл амралт” сэдэвт аялалуудыг зохион байгуулж 60 гаруй иргэдийг хамрууллаа.

Улаанбаатар хотноо зохиогдох “Mongolia ITF2009” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймаг орон нутгийн аялал жуулчлалын бодлогыг сурталчилж оролцсон.

Аймгийн Музей, Мэргэжлийн хяналтын газартай хамтран орон нутгийн булш хиргисүүрийн тооллого явуулж 18 хэсгийн 100 гаруй булш хиргисүүр байгааг тогтоож баримтжуулсан.

ДӨРӨВ. ЭРХ ЗҮЙТ ТӨРИЙГ ТӨЛӨВШҮҮЛЖ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ЗОРИЛТ

Зорилт: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэхийн хамт иргэний нийгэм, төрийн байгууллагын түншлэл, тогтвортой үйл ажиллагаа, ил тод байдал, төрийн албаны ур чадвар, хариуцлагын тогтолцоог өндөржүүлж, эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төслийн хүрээнд “Эрх зүйн туслалцааны төв”-ийг байгуулснаар 2009 онд 560 хүнд үйлчилгээ үзүүлснээс эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нийт 18 хэрэгт 20 хүнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах үндсэн нөхцлийг бүрдүүлж ажиллалаа.

Эрх зүйн сургалт сурталчилгааны ажилтан 48 иргэн 14 байгууллагад анхан шатны зөвлөлгөө, мэдээллээр хангасан.

“12 сарын 10-ны өдөр Архидалтын эсрэг хамтдаа зөвлөгөөнийг зохион байгуулж хууль хяналтын байгууллагуудын төлөөлөл, архины хамааралтай байнга эрүүлжүүлэгддэг иргэд, архи согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл, хуулийн байгууллагуудийн төлөөлөл, төрийн бус байгууллагуудаас 100 гаруй хүн оролцсон.

Чойр дахь хорих 425 дугаар ангийн хоригдож байгаа ялтнуудыг нийгэмшүүлэх чиглэлээр: Монгол Ви Ти Нет төрийн бус байгууллагатай хамтран 2009.03.20-нд "Алсын хараа ба зорилго" сэдвээр сургалт, Герман улсын Алдаж гэндэгсдэд туслах Шайдевег нийгэмлэгтэй хамтран 2009.06.08-2009.06.10-ны хооронд нөхөрсөг уулзалт тэмцээн тус тус зохион явуулсан. Ялтны сайн дурын байгууллагыг “Урлаг, Спорт”, “Танин мэдэхүй”, “Эрүүл мэнд” гэсэн бүлгүүдэд хуваан үйл ажиллагааг нь дэмжин хамтран ажиллаж байна.

Халх голын түүхт 70 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд 2009.06.10-нд Халх голын дайнд оролцож явсан ахмад дайчдыг урьж уулзалт ярилцлага зохион байгуулсан.

Бизнес эрхлэгч, иргэд, төрийн бус байгууллага, залуучууд, өндөр настанд төрөөс үзүүлэх үйлчилгээг шуурхай болгох талаар санаачлагатай ажиллаж тэдэнтэй уулзах уулзалтуудыг зохион байгуулж санал хүсэлтийг сонсож, боломжтой бүх дэмжлэгийг үзүүлж байна. Төрийн байгууллагыг иргэд үйлчилгээ авах гэж ирэхийг хүлээх биш, тэдэнд тосч үйлчлэх талаар олон талт арга хэмжээ авч Нээлттэй өдөрлөг, нэг цонхны үйлчилгээ, айл өрхөөр орох, иргэдийг хүлээн авах өрөөтэй болж аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын дарга, хэлтэс, албадын дарга нар хуваарийн дагуу ажиллаж иргэдийг хүлээн авч, тэдний санал хүсэлтийг хүлээн захирамжийн дагуу шийдвэрлэж хэвшээд байна.

Нутгийн захиргааны бүх байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад ажлын байрны тодорхойлолтоо шинэчилж, ажил үүргийн хуваарь шалгуур үзүүлэлтээ тодорхой болгох талаар сургалт зохион байгуулснаар бүтээгдэхүүн нийлүүлэлт болон үр дүнгийн гэрээг Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын сайдуудтай байгуулсан гэрээтэй уялдууллаа.

Байгууллага бүр өөрчлөгдөн хөгжиж байгаа орчин нөхцөлд нийцсэн байнгын шинэ соёл төлөвшүүлэхэд анхаарч төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгаа хөтөлбөрөө шинэчлэн энэ оноос мөрдөн ажиллаж байна.

“Байгууллагын соёл, иргэд төрийн үйлчилгээг хүргэх” талаар нэг байгууллагад үзүүлэх сургууль зохион байгуулна.

Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулах саналыг төрийн захиргааны зөвлөлд хүргүүлсэн.

“Байгууллагуудын дотоод журам”- д төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх асуудлууд оруулж, төрийн албан хаагчийн тангараг, ёс дүрмийг ил тод байрлуулаад байна.

Засгийн Газрын Хэрэг эрхлэх газраас Өмнөговь аймагт зохион байгуулсан Хяналт шилжилгээний үнэлгээний ажилтнуудад зориулсан бүсчилсэн сургалт, Улаанбаатар хотод зохион байгуулсан “Хяналт шинжилгээ үнэлгээний тасгийн дарга нарт зориулсан сургалт”- ад аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний тасгийн дарга, мэргэжилтэн нар тус тус хамрагдав.

Аймгийн Засаг даргатай байгуулсан Ерөнхий менежерүүдийн үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан сумдын Засаг дарга нарын гэрээний биелэлтэд Хяналт шинжилгээ үнэлгээ хийж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

2009 онд явагдсан Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр төрийн албаны зохион байгуулалтаар 95 оноо буюу *А* үнэлгээ авсан.

1.2. ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ:

Аймгийн хэмжээнд **66** үндэсний хөтөлбөрийн **313** арга хэмжээг хяналтанд авч хэрэгжүүлснээс хэрэгжилт **4.23** хувьтай байна.

2009 онд “Монголын уламжлалт бий, биелгээ”, “Осол гэмтлээс сэргийлэх”, “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Хүнсний баталгаат байдал”, “Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр” зэрэг хөтөлбөрүүдийг шинээр хяналтанд авсан.

“Бүх нийтийн экологийн боловсрол”, “Үхрийн арьсны гууртах өвчинтэй тэмцэх”, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”, “Агропарк” зэрэг 13 хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дууссан тул хяналтаас хасав.

Мөн аймаг орон нутагт хэрэгжих боломжгүй “Шингэрүүлсэн шатдаг хий”, “Агаарыг хамгаалах”, “Монгол орны гео мэдээлэлийн сан”, “Монгол улсын шинжлэх ухаан технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх”, “Озоны үе давхаргыг хамгаалах” зэрэг 11 хөтөлбөрийг хасч хэрэгжилтийг тооцлоо.

Хөтөлбөрүүдийн хэрэгжилт удааширч байгаа болон тасарч байгаа нь санхүүжилт ирдэггүй, бага байдгаас шалтгаалж байна.

Эрүүл мэндийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг агентлагуудын төсөвт хөтөлбөрүүдийн санхүүжилтийг суулгаж өгдөг боловч энэ нь багцаараа байдаг болохоор нэг хөтөлбөрт оногдох хэмжээ бага хүртээмж муу байна. Цаашид хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд салбарын уялдаа холбоог сайжруулж улсын төсвөөс төсөл хөтөлбөрт олгох санхүүжилтийг сайжруулах, орон нутгийн удирдлагын хүрээнд идэвх санаачилгыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Хөтөлбөрүүдийг салбараар нь авч үзвэл:

Хууль зүй дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж байгаа 6 хөтөлбөрийн 27 заалтыг хяналтад авч 84.1 хувьтай хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт авилгатай тэмцэх, ил тод байдал төрийн үйлчилгээний талаар тусган тодорхой ажлуудыг зохион байгуулж байна.

Тендер, хөрөнгө оруулалтын бүхий л үйл ажиллагааг нээлттэй байлгах үүднээс Өдрийн сонин, Зууны мэдээ, Говьсүмбэрийн мэдээ зэрэг сонин, нээлттэй хаалганы өдөрлөг, нээлттэй самбараар мэдээлж байна. Аливаа авилга, хээл хахууль гаргахгүй байх үүднээс 7 ажлын хэсэг, тендерийн үнэлгээний комисст иргэд, ТББ-ын төлөөлөлийг оруулсан.

Авилгийг төрүүлэгч, өдөөгч хүчин зүйл бий болгохгүй байхад анхаарч илүү хяналттай ажилласны үр дүнд ямар нэг гомдол, хууль бус үйлдэл, үйл ажиллагаа гараагүй байна.

Аймгийн ИТХ, Цагдаагийн хэлтэс, Хууль зүйн хэлтэс, архидалт мансуурлын эсрэг ассиацац, хуулийн байгууллагууд, зарим ТББ-тэй хамтран "Архидалтын эсрэг хамтдаа" зөвлөгөөнийг зохион байгуулж 2010 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтран боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих дэд хөтөлбөрийг АИТХ-р батлуулан 2009 онд 2 сая төгрөгийг зарцуулсан. Сар бүрийн 25, 4-р сарын 7, 6-р сарын 1, 9-р сарын 1-ны өдрүүдэд архи худалдаалахыг хориглосон аймгийн Засаг даргын захирамжийг мөрдөн ажиллаж байна.

Хууль зүйн хэлтсээс "Эрдэнэсийн гайхамшиг" FM-107 радиотой хамтран архидалтын эсрэг "Эрүүл аж төрөхүй" гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд "Хууль ба хайр", "Хүсэл мөрөөдөл", "Шашин", "Эрүүл мэнд" гэсэн чиглэлээр радио цуврал нэвтрүүлгийг явуулж наркологийн танхимыг 4 сая төгрөгөөр тохижуулж архины хамааралтай 55 иргэнийг хяналтанд авч хорт зуршлаас нь салгах талаар хамтарч ажиллахаар болсон.

Хүн худалдаалах ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр, холбогдох мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд түгээх зорилгоор мэдээллийн самбар ажиллуулж, энэ хөтөлбөрөөр гарын авлага бэлтгэн иргэд, олон нийтэд тараасан.

Цаашид ЕБС-ийн эрх зүй, эрүүл мэнд, түүх, нийгмийн ухааны хичээлүүдэд уг сэдвийг илүү өргөн цар хүрээтэй оруулах шаардлагатай байна.

Эрх зүйн албан бус сургалтын хүрээнд 180 төрлийн сэдвээр 57 удаа зохион байгуулж, нийт 3469 гаруй иргэн хамрагдаж, 67 хүнд эрх зүйн анхны шатны зөвлөгөө өгч ажилласан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Засаг даргын нөөц сангаас 1.7 сая төгрөгийг зарцуулж өндөр хүчин чадалтай компьютер, принтер бусад хэрэгсэлээр хангагдаж, аймгийн архив болон байгууллагын архивын хадгаламжийн сангийн өрөөнд галын дохиолол хамгаалалтыг суурилуулж хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулсан.

Хууль эрх зүйн хүрээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн хувьд санхүүжилтийг тодорхой болгож өгөх шаардлагатай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж байгаа 13 хөтөлбөрийн 39 заалтыг хяналтанд авч 82.8 хувьтай хэрэгжүүлж байна.

Энэ онд гадаргын усны тооллогыг явуулж 5 гол, 2 рашаан, 6 булаг, 11 цооног, 7 нуур тойром, 1 баянбүрд, 272 худаг уст цэгийг тогтоосон.

Цэвэр орчинд амьдарцгаая аяны хүрээнд хатуу хучилттай авто замын 2 талыг хамарсан 500 га талбайн гялгар уут, хог хаягдлыг цэвэрлэх ажлыг аж ахуйн нэгж, байгууллагуудын 923 ажилчдыг оролцуулан цэвэрлэж, 27 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт хүргэлээ. Хатуу хучилттай замын хажуу карьерийн дагуу 2 га талбайг хамарсан барилгын хог хаягдлыг түрж тэгшлэн эрүүлжүүлсэн.

Сүмбэр сумын 2-р багийн гэр хорооллын арын Чойр, Малчин, Шивээ, Өгөөмөрийн эгнээний хуралдсан 2000 тн элсийг зайлуулсан.

Аймгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар орон нутгаас “Бүх нийтээр мод тарих хөдөлгөөн”-ийг өрнүүлж аймгийн хэмжээнд нийт 3182 ширхэг мод бут тариалж 74 ААН, байгууллага, 120 өрх, 350 гаруй иргэн идэвхитэй оролцсон.

Чойрын богд ууланд нутагшсан аргаль хонины идэш хоолонд зориулж биотехникийн арга хэмжээ авах ажлыг 4 удаа зохион байгуулж 320 боодол өвс тавьж өгч 1.5 төгрөг зарцуулсан байна. 10-р сард биотехникийн хүрээлэн, БОАЖЯ-тай хамтран аргаль хонины тооллого явуулахад 150 гаруй аргаль хонь тоологдож 2007 онтой харьцуулахад 80 толгойгоор өссөн.

Орон нутгийн тусгай хамгаалалттай, түүх соёлын дурсгалт газрыг хамарсан аялал жуулчлалын маршрутыг боловсруулж дотоодын аялагчдын авах нөхцлийг бүрдүүлж 3 удаагийн аялалаар 40 гаруй хүнийг хамруулж аялуулсан.

Ус цаг уур орчны шинжилгээний албаны дэргэд “Сүмбэр бороо-1” /хурын шим төвийн салбар/ экспедицийг байгуулж цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулж эхэлсэн.

20 удаа 43 пуужин харвасанаар 2008 оны 06 сард 23 мм, 7 сард 7.4 мм тунадас орж байсан бол 2009 оны 6 сард 12.9 см, 7 сард 168.1 см болж хур тунадас орсон байна. Чийг нэмэгдэж, ургамлын гарц сайжирснаар өмнөх онуудад ажиглагдаж байсан шороон шуургатай өдрийн тоо багассан үзүүлэлт гарсан. Цаашид байгаль орчны чиглэлийн хөтөлбөрүүдэд санхүүжилтийг сайжруулах /санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгох/, зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, яамд агентлагын ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж байгаа 10 хөтөлбөрийн заалтыг хяналтанд авч 75.8 хувьтай хэрэгжүүлж байна.

2009-2010 оны хичээлийн жилд чадварлаг мэргэжлийн залуу багш нараар хангахын тулд 16 багш, бусад аймаг, сум, сургуулиас 7 багш шилжин ирж ажиллаж байна. Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулснаар Үндэсний сургагч багш-1, "Стандартын дагуу хөтөлбөр боловсруулах арга зүй" сэдэвт сургалтаар 26 багш, "Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх" сургалтанд Англи хэлний бүх багш нар хамрагдав.

Зайны сургалт хөтөлбөрийн хүрээнд сумд өөрийн төсвийн 1 хувийг зайны сургалтанд зарцуулж байна. Багш нарын ур чадварыг дээшлүүлэх үүднээс төвлөрсөн сургалт, сэдэвт нэгж хичээлийн уралдааныг зохион байгуулж, гэрийн болон явуулын хэлбэрээр сургалт хийж нийт 20 хүн хамрагдсан. Хөтөлбөрийн үр дүнд орон нутагт зайны сургалтын тогтолцоо бүрдэж тодорхой зөвлөл ажиллаж тодорхой үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

2008-2009 оны хичээлийн жилд аймгийн хэмжээгээр бичиг үсгийн сургалтанд хамрагдсан 13 суралцагчаас 10 нь бичиг үсэг тайлагдаж 3 суралцагч нь бага мэдэгчээс түвшин ахисан байна. Бага боловсролыг 12 хүүхэд, суурь боловсролыг 15 иргэн эзэмшиж 6 нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд үргэлжлүүлэн сурч байна. Хүн амын суурь судалгааг гаргаж 7-49 насны бичиг үсгийн боловсролгүй 64, үүнээс 7-15 насны 12, 16-49 насны 20 иргэн сургалтанд хамрагдан, 22 нь бичиг үсгийн боловсролтой болжээ.

Зүүн бүсийн аймгуудын Англи хэлний анхдугаар тэмцээнийг Дэлхийн зөн ОУБ-ын ивээл дор зохион байгуулан явууллаа. Олимпиадад Дорноговь, Дундговь, Хэнтий аймгуудаас нийт 100 гаруй хүүхэд, багш нар оролцлоо. Англи хэлний сургалтын чанар 2008 оныхоос 2.69 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

"Монгол бичгийн сайхан бичигтэн" уралдаанд 200 гаруй хүүхэд хамрагдаж, Гавъяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит монгол бичгийн олимпиадыг 5-11 анги, бага ангийн багш, мэргэжлийн багш, иргэд гэсэн ангилалаар зохион байгуулж, нийт 83 багш сурагч иргэд оролцсон.

Боржигин уртын дууны бүртгэлийг Боржигин сумын соёлын төвүүдтэй хамтран ажиллаж судалгааг авч ахмад уртын дуучдын дууг бичлэг хийж бүртгэл мэдээллийн санд бүртгээд байна. Мөн МҮОНТ-ийн "Соёл-эрдэнэ" редакцтай хамтран бүрэн хэмжээний нэвтрүүлэг бэлтгэж урын

сангаа баяжуулсан. Хоёр уран бүтээлчийг Үндэсний дуу бүжгийн чуулгын болон Соёл урлагын их сургуулийн хөөмийн 14 хоногийн сургалтанд хамруулсан, СУИС-аас хөөмийн багшийг урилгаар авчирч чуулгын уран бүтээлчдэд 7 хоног сургалт явуулсан.

Орон нутагт бий, биелгээний дэд хөтөлбөрийг боловсруулан Баруун Монголын бий, биелгээ, зан заншил, урианхай захчин, баяд ардын бий биелгээ зэргийг судалж, МҮОНТ-ийн бичлэгт “Бэсрэг биелгээ”, “Бид биечид”, “Торнууд сэвгэр”, “Биелэх хүслэн”, “Захчин биелгээ”, “Ховог урианхай” зэрэг бүжгүүдийг бичүүлж, аймаг орон нутгийн томоохон арга хэмжээнд бий биелгээний номерийг тогтмол оруулж байна. Энэ онд СТА. Төсгөөгийн дэглэлт “Хос түрлэг”, СТА О.Цэрэнжаргалын “Бид биечид”, Э.Алтанзулын “Ховог урианхай”, МУУГЗ Чимэдцэрэнгийн “Биелэх хүслэн”, МУСТА Нарангэрэлийн “Захчин биелгээ” зэрэг бүжгээр баяжуулсан.

Хамгаалах, сэргээн засварлах түүх, соёлын дурсгалт газруудын судалгааг гарган Зүүн Чойрын хийдийн туурин дахь илдний зурагтай хадны зураг, Баянтал сумын төв дэх онгоцны хөшөөг тус тус сэргээн засварласан. Соёлын өвийн төвтэй хамтран улсын тооллого хийгдэж нийт 150 орчим үл хөдлөх дурсгал бүртгэгдсэнээс: Тахилын онгон-3, Дөрвөлжин булш-15, тахилын байгууламж-17, дугуй булш-13, зэл чулуу-2, 40 гаруй булш, 50 орчим хиргисүүрийг тоолж, солбилцол тогтоон зургаар баримтжуулан бүртгэлжүүлж, Цагдаад болон Тагнуулын газарт CD-д буулгаж албан тоотоор хүргүүлсэн.

Боловсрол, соёлын салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн хувьд санхүүг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих зорилтуудын шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч яам аймгийн удирдлага, агентлагтай ажлын уялдаа холбоог сайжруулах, хэрэгжүүлэгчдийн хариуцлагыг өндөржүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй байна.

Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж байгаа 7 хөтөлбөрийн 32 заалтыг хяналтанд авч 87.5 хувьтай хэрэгжүүлж байна.

Амны хөндийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, сургалт сурталчилгааны ажил тогтмолжсон.

Иод дутлын эмгэгтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд иоджуулсан давсыг хоол хүнсэнд хэрэглэх ач холбогдлын талаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийтийн хоолны газрын тогооч, ажилчид, сумдад тус бүр 1 удаа, сургуулийн сурагчид 110, нийтийн хоолны газрын тогооч 16, хүнсний дэлгүүрийн худалдагч 10 нийт 136 хүнд сургалт хийсэн. Мөн ЕБС-ийн 7-12 настай хүүхдүүдэд бахлуурын урьдчилан сэргийлэх үзлэгт 184 хүүхэд хамрагдсанаас бахлуур өвчин илрээгүй.

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн шинэчилсэн судалгааг сум, баг өрхөөр гаргасан. Нийт 4066 /Сүмбэр-2969, Шивээговь-848, Баянтал-249/ нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд байна. 2009 онд 162 эх амаржсанаас эхийн эндэгдэл гараагүй.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагууд хог хаягдлаа ЭМС, БОС-ын 2002 оны 249/201 тоот тушаалын дагуу ангилан ялгалт, хадгалалт хийх, устгах, өөрийн байгууллагын эзэмшил газрын хашаанд жижиг зуух болон бохирын цооног ашиглан хог хаягдлаа устгаж байна.

Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төсөв санхүү дутмаг байгаагаас хөтөлбөрийг өргөн хүрээтэй явуулах, хэрэгжилтийг зохион байгуулахад хүндрэл учруулж байна. Иймээс цаашид

хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлж тухайн зорилтууд бүр дээр хамаарах шалгуур үзүүлэлт, түвшинг тогтоож өгөх хэрэгтэй. Мөн талуудын уялдаа холбоог сайжруулах, санхүүжилтийг зөв зохистой нарийн хуваарилах.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж байгаа 13 хөтөлбөрийн 53 заалтыг хяналтанд авч 92.3 хувьтай хэрэгжүүлж байна.

Аймгийн хэмжээнд сүүний чиглэлийн үхэр 39, махны чиглэлийн хонь 5342 каракуль арьсны чиглэлийн 697 хонь байна. Нийт малд цэвэр, эрлийз, арвин ашиг шимт мал 6.8 хувийг эзэлж байна. Нутгийн хонины 30-45% өндөр ашиг шимт мах-өөхний чиглэлийн ууцан сүүлт Үзэмчин, Барга, Баянцагаан хониор сайжирсан. Ямааг ноолуурын чиглэлийн Баяндэлгэр ямаагаар сайжруулснаар нийт ямааны 60 гаруй % нь улаан болж ноолуурын гарц 0.410 гр-д хүрсэн.

Малыг эрүүлжүүлэх талаар анхаарч халдваргүйжүүлэлт, ариутгалд хамруулж, малын гаралтай түүхий эдийн тээвэрлэлт, малын шилжилт хөдөлгөөнд хяналт хийснээр шинээр халдварт, паразиттах өвчин гараагүй байна.

"Үхэр, хонь, ямааны бруцеллёз" өвчинтэй тэмцэх төслийн хүрээнд аймгийн дэд хөтөлбөр батлагдах үед мал сүрэгт бруцеллёз өвчний халдварлал 1.0-1.2 хувь, харин 1000 хүн амд 24.1 байсан бол хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд малынх 0.2-0.4%, хүнийх 17% болж буурсан.

Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Үдийн цайг чанаржуулъя" сэдэвт сургалтыг 1 удаа зохион байгуулж 42 иргэн, аж ахуй нэгж, Зохистой хоололтын талаарх сургалтыг өрхийн эмнэлгүүд иргэдэд зориулан хийсэн ба 103 иргэнийг тус тус хамруулсан.

Ногоон хувьсгал хөтөлбөрийн хүрээнд энэ онд тус хөтөлбөрт 15 аж ахуйн нэгж, 23 иргэн хамрагдаж 22.67 га-д тариалалт хийснээр 79.24 тн төмс, 21.5 тн хүнсний ногоо нийт 100.74 тн-ыг хураан авлаа. Нийт хураан авсан төмс хүнсний ногооны 30.16 тн-ыг өөрийн хэрэгцээнд 30.0 тн-ыг үрэнд 36.58 тн-ыг орон нутгийн зах зээлд борлуулснаар өрхийн нэмэгдсэн орлого дунджаар 351.3 мян төгрөгт хүрсэн. Аймгийн хэмжээнд 1557 м2 талбай бүхий 21 хүлэмжид лооль, хэмх, чинжүү, хаш зэрэг ургамал тариалж сумдын төвийн иргэдийн хэрэгцээнд 13.06 тн нарийн ногоо нийлүүлээ. Тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг ААН, иргэд өөрсдийн хүчээр 3 худаг шинээр гаргаж 5 худаг сэргээн засварлаад байна.

ХХААХҮЯ-наас байршуулсан 557.0 сая төгрөг, Орон нутгийн төсвөөс оруулах 45.0 сая төгрөг, гэрээ хийсэн арилжааны банк 30% буюу 167.0 сая төгрөг төвлөрүүлж 782.5 сая төгрөгийн сан бүрдүүлсэн бөгөөд аймгийн дэд комисс нь нийт 11 удаа хуралдаж 142 төсөл хэлэлцсэнээс 94 төсөл дэмжигдэж зээл олгуулахаар харилцагч Хас банкинд хүргүүлсэн. Хас банкнаас 64 ААНэгж, иргэдэд 737.65 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Зам тээвэр барилга хот байгуулалтын яамнаас хэрэгжүүлж байгаа 3 хөтөлбөрийн 15 заалтыг хяналтанд авч 71.3 хувьтай хэрэгжүүлж байна.

Чойр хотын ерөнхий төлөвлөгөөг 2005 онд аймгийн ИТХ-аар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан газар болон жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Энэ онд 80 айлын орон сууц, угсармал 109 айлын орон сууцны барилгыг засварлан ашиглалтанд оруулсан.

Баянтал сумын гадна ИШС-ний энхий ээлжийн ажлыг орон нутгийн төсвийн 250.6 сая төгрөгөөр хийж 150 айлын орон сууц, цэцэрлэг сургууль, дотуур байр, чөлөөт бүсийн оффисийн байр зэрэг объектуудыг шугам сүлжээнд холбогдох нөхцлийг бүрэн хангасан. Ариун цэврийн байгууламжийг сайжруулах талаар шат дараалсан арга хэмжээг авч байна. Энэ онд Баянтал сумын цэцэрлэг, сургуулийн барилгыг БСШУЯ-ны захиалгаар Дэлхийн банкны буцалтгүй тусламжийн 261.4 сая төгрөгийн хөрөнгөөр засварлаж ашиглалтанд оруулснаар тус сумын цэцэрлэг сургууль бохир усны нэгдсэн шугамд холбогдоод байна. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлыг хийх хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гаргах хэрэгтэй гэж үзэж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж байгаа 5 хөтөлбөрийн 32 заалтыг хяналтанд авч 89.7 хувьтай хэрэгжүүлж байна.

Хүчирхийллийн тухай сургалт семинарийг “Хуульч эмэгтэйчүүдийн” байгууллагатай хамтран нийт 12 удаа давхардсан тоогоор 3600 гаруй хүнд яриа таниулга хийсэн ба нээлттэй хаалганы өдрөөр хүний эрхийн үндэсний комиссын ажилтнуудыг урьж удирдах ажилтнуудад сургалт хийсэн. Шинээр гэрлэгсэд өсвөр үеийнхэн, залуучуудын дунд жендер, гэр бүлийн боловсрол олгох сургалтуудыг сургалтанд хамрагдсан хүмүүсээр хийлгэж эхлээд байна.

ХААН, ХАС, Монгол шуудан банкаар дамжуулан ХЭДС-ийн зээл, ХБИ-г дэмжих зээл, ЖДҮ-чдийг дэмжих зээл болон улсын төсөв, хувь хүний хөрөнгөөр 383 ажлын байр шинээр бий болсон ба үүний 293 нь байнгын ажлын байр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих талаар олон талт бодлого явуулж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөг тэмцээн зөвлөгөөнд 200 гаруй иргэдийг хамруулсан. Шинээр мэргэжил эзэмшүүлэх болон ур чадвар чиг баримжааны сургалтанд 30 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэний хамруулав. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй 11 иргэнийг байнгын, 70 гаруй иргэнийг нийтийг хамарсан ажилд хамруулан зуучиллаа. Байнгын ажиллагаа шаардлагатай Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асарч байгаа 34 иргэнд 10529.9 мянган төгрөг, байнгын асаргаа шаардлагатай Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа 21 иргэнд 7704.0 мянган төгрөг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа 29 иргэнд 9256.2 мянган төгрөг тус тус олгосон байна. Мөн 28 төрлийн үйлчилгээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан 28308.4 мянган төгрөгний үйлчилгээ хөнгөлөлт хүргэв.

АДРА ОУБ-ын мэргэжилтэн, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн сайн дурын зөвлөгч доктор Ж.Эрдэнэтуяаг урьж “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэлбэр” сэдэвт сургалт зохион байгуулж, архи хэтрүүлэн хэрэглэж гэр орондоо айдас түгшүүр төрүүлдэг 30 иргэн, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгч 30 хүнд, мөн ХХҮ хэлтэсийн сум хариуцсан нийгмийн

ажилтнууд, сургуулийн нийгмийн ажилтнуудыг хамруулан 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Нийгмийн халамжийн хүрээнд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн хувьд санхүүжилт сайн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт гарч эхэлснээс хойш хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэдийн тоо нэмэгдсэн үзүүлэлт гарч байна. Цаашид ажлын байрыг аль болох нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа 4 хөтөлбөрийн 16 зүйл заалтыг хяналтанд авч 92.5 хувьтай хэрэгжүүлж байна.

Нэг цонхны үйлчилгээний байрыг засварлан ашиглалтад оруулж ажиллах мэргэжилтнүүдийг сургалтанд бүрэн хамруулж ажилд оруулан ажлын таван өдөр 10⁰⁰-16⁰⁰ цагийн хооронд 9 төрлийн үйлчилгээ үзүүлэн хэвийн үйл ажиллагаагаа явуулж хэвшсэн. Энэ хугацаанд “Нэг цонхны үйлчилгээ”-ээр сард дунджаар 5189 иргэн, нийт 31135 гаран иргэн үйлчлүүлсэн байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн хувьд нэг цэгийн үйлчилгээг байгуулснаар иргэдэд ойрхон нэг дороос олон цогц үйлчилгээг хүртэх болсон ба иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх боломжийг олгож байгаагаараа давуу талтай юм.

Төрийн албаны мэдлэг боловсрол хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх тал дээр ахиц гарч байна. Цаашид сургалтын материаллаг баазын хангалтыг сайжруулах, сургалтын чанарыг дээшлүүлэх, шаталсан сургалтын хэлбэрт шилжүүлэх.

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд багийн материаллаг баазыг бэхжүүлэх, санхүүгийн нөөц бололцоог нэмэгдүүлэх, багт ажиллах боловсон хүчнийг нөөцийг бүрдүүлэх, багийн Засаг даргыг чадавхижуулах зэрэгт анхаарч ажиллаж байна.

Бусад 5 хөтөлбөрийн 51 зүйл заалтыг хяналтанд авч хэрэгжүүлж биелэлт нь 81.4 хувьтай хэрэгжсэн байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэгтэй хамтран 0-5 насны хүүхдийн өсөлт хөгжилтийн судалгааг гаргах хамтарсан ажлын төлөвлөгөөг гарган, 6-18 насны хүүхдийн 1-10 ангийн хүүхдүүдийн өсөлт хөгжлийн судалгааг гаргав. Судалгаанд 900 гаруй хүүхэд хамрагдлаа. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, ард иргэдэд сурталчлах зорилгоор “Боржигин нутаг FM-102.5”-ээр 47 цагийн мэдээ мэдээллийг хүүхэд багачуудад хүргэж ажилласан.

Залуучуудад шинээр мэргэжил ба чадвар олгох сургалтанд 281 хүнийг хамруулан мэргэжил олгосон. Мэргэжлийн баримжаа олгох болон зөвлөгөө өгөх үйлчилгээнд нийт 1020 хүнд зөвлөгөө өгөх үйлчилгээнд, хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэд, малчдад “Бизнесээ эхэл-хөгжүүл” төсөл хөтөлбөрийн сургалтанд 51 хүнийг хамруулан иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж өгсөн. Ажилгүй 41 залууг сул чөлөөлөгдсөн ажлын байранд зуучилсан бөгөөд эдгээр иргэдийг ажлын байраар хангасан 20 байгууллагын ажил олгогчийг дэмжин ХЭДС-с 24.274 сая төгрөгөөр урамшуулсан.

Хүүхдэд залууст чиглэсэн хөтөлбөрүүдийн хүрээнд шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, хөтөлбөрт оролцогч талуудын уялдаа холбоог сайржуулах, санхүүгийн асуудлыг асуудлыг шийдвэрлэх

Орон сууцны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн санг хугацаанд нь бий болгосон цөөхөн аймгуудын тоонд манай аймаг орсон. Судалгаа шинжилгээний ажлын хүрээнд Статистикийн эмхтгэлийг 2000-2008 оны байдлаар Монгол-Англи хэл дээр, аймгийн Засаг даргын дэмжлэгээр хэвлүүлэн гаргаж, хэрэглэгчдэд тараасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр 2007, 2008 онуудад орон нутагт 2 удаагийн сургалтаар 46 албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтанд хамруулан сертификат олгож төвийн сургалтанд 10 хүнийг хамруулж 2 хүнийг сургагч багшаар бэлтгэсэн. Орон нутагтаа дотоодын сургалт зохион байгуулж аймгийн НДХ-ийн ажилчдыг хамруулсан. Үүний үр дүнд аливаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын мэдлэг оролцоо дээшилж будилангүй явагдах нөхцөл бүрдэнэ.

Хоёр. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

2.1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2008 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол улсын эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд аймгийн Засаг дарга түүний Тамгын газарт нэн хамааралтай таван зорилтын 8 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж 81.25 хувьтай хэрэгжүүллээ.

2009 онд аймгийн хүн амын махны хэрэгцээг бүрэн, төмс хүнсний ногооны хэрэгцээний 21 хувийг дотоодын үйлдвэрлэлээр орон нутагтаа бэлтгэн хангалаа. малчдын хувьдаа бэлтгэсэн 234 тн махыг аймаг, сумын дотоодын зах зээлд борлуулснаар орон нутагт махны үнийн хөөрөгдөлгүй тогтвортой байх нөхцлийг бүрдүүлсэн.

“Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэргэжлийн хяналтын газраар жил бүр хяналт үнэлгээ хийлгэн ажиллаж байна. ЖДҮ-ийг дэмжих сангийн зээлээр сүү нийлүүлэх, сүүн бүтээгдэхүүн

үйлдвэрлэх чиглэлээр 4 аж ахуйн нэгж, иргэнд 55.6 сая төгрөгийн зээл олгож үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Энэ жил хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээний 45 хувийг орон нутагтаа бэлтгэсэн. Аймгийн хэмжээнд 6 иргэн, нэг аж ахуйн нэгж, гахай шувууны аж ахуй эрхэлж 98 гахай, 89 тахиа өсгөн үржүүлж байна.

Сумдын газар зохион байгуулалтын 2009 оны төлөвлөгөөнд иргэн бүрт олгох газрын хэмжээ байршлыг тогтоож, төлөвлөгөөны дагуу иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд өссөн дүнгээр 1864 иргэнд 339.45 га газрыг өмчлүүлээд байна.

Газрын дуудлага худалдааг 23 удаа нээлттэй зарлан явуулж 48813 м² газрыг 19 иргэн 4 аж ахуйн нэгжид худалдаж 136.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна.

2009 онд ойжуулалтын ажлын хүрээнд 10 га талбайд ойжуулалтын ажлыг гүйцэтгэх 6080 суулгацыг ургууллаа. Намрын тооллогоор 76 хувьтай тоологдсон. Мөн “Мод тарьж ургуулсан иргэнийг урамшуулах” журмыг Сүмбэр суманд хэрэгжүүлж эхлээд байна.

Аймгийн хэмжээнд ургаж буй модны тооллого явуулахад Шивээговь сум 4 төрлийн 655 мод, Баянтал сум 3 төрлийн 401 мод, Сүмбэр сум 9 төрлийн 2767, Чойр эко парк төслийн 28224 мод, нийт 32057 мод аймгийн хэмжээнд ургаж байна.

Уул уурхай, хүнд машин механизм, барилгын чиглэлээр оюутан бэлтгэх Мэргэжлийн Сургалт үйлдвэрлэлийн төв 2008-2009 оны хичээлийн жилд 450 оюутан элсүүлэн сургасан бол 2009-2010 оны хичээлийн жилд БСШУЯ-наас 650 хүүхдийн хяналтын тоо батлуулан элсэлт аван сургаж байна.

Мэргэжлийн Сургалт үйлдвэрлэлийн төвийн багш ажилчдын цалин, оюутны цалин, хоолны зардлыг төрөөс санхүүжүүлэн дэмжиж байна

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ҮР ДҮН:

Аймгийн Засаг даргын Тамгын газраас хууль тогтоомж, шийдвэрийг иргэд олон нийтэд тогтмол сурталчилан зүйл заалт бүрээр нь хяналтанд авч биелэлтийг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийн явц байдлын мэдээг улирал бүр гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2009 онд Засгийн газрын 72 тогтоолын 99, 21 хуралдааны тэмдэглэлийн 29, Ерөнхий сайдын захирамжийн 1 зүйл заалт нийт 129 зүйл заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс 100 хувь хэрэгжсэн 65, 90 хувьтай 31, 70 хувьтай 8, 50 хувьтай 10, 30 хувьтай 9, 10 хувьтай 6 заалт 82,8 хувьтай хэрэгжсэн байна.

Засгийн газрын тогтоол 82.0, Ерөнхий сайдын захирамж 100.0, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 84.8 хувьтай тус тус хэрэгжсэн.

Удааширалтай хэрэгжиж байгаа тогтоол шийдвэрүүд хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй холбоотой хэдий ч хэрэгжүүлэх талаар Засаг даргын зөвлөлийн хурлаас үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжилтийг ханган ажилласан зарим тогтоол, шийдвэрээс:

2005 оны 06 сарын 22-ны өдрийн “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” хөтөлбөр батлах тухай 138-р тогтоолын дагуу “Нэг суурин -нэг бүтээгдэхүүн” дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн брэнд бараа, үйлчилгээг бий болгох зорилгоор сум, аймаг, бүсийн хэмжээнд үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шилдгээр шалгарсан иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, үйлдвэрлэлийг тогтмолжуулах, өргөжүүлэх бодлого барьж байна. Энэ чиглэлээр аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 63 иргэн, аж ахуйн нэгжид 727.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэв.

Аймгийн брэнд бүтээгдэхүүн болох Сүмбэр каракуль хонь, Шивээ-Овоогийн нүүрсийг газар зүйн заалтаар бүртгүүлж баталгаажуулахаар Оюуны өмчийн газарт мэдүүлэг гаргасан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Мерси Кор олон улсын байгууллага хамтран “Говьсүмбэр-2009” үзэсгэлэн худалдааг 9-р сард зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд орон нутгийн 84 бизнес эрхлэгч, малчид бараа бүтээгдэхүүнээрээ оролцож 58.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үзэсгэлэн худалдааны шилдэг бүтээгдэхүүнийг 7 номинациар шалгаруулж, шагнал урамшуулалд 1.9 сая төгрөг зарцуулав. Өмнөх жилүүдтэй харьцуулахад орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ 10 орчим хувиар өссөн, үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэдийн тоо өссөн, хэрэглэгчдийн ойлголт хандлага өөрчлөгдөж орон нутгийнхаа үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг авах сонирхол нь нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж хэвшсэн ба хөтөлбөр хэрэгжсэний үр дүнд аливаа үйл ажиллагаа явуулахад тогтвортой үр дүнтэй, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлж байна.

Төр иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг өргөжүүлэх зорилготой “Түншлэл 2009” зөвлөлгөөнийг Мерси Кор ОУ-ын хөтөлбөрийн газартай хамтран зохион байгуулсан. Түншлэлийн хүрээнд Аймгийн Төр-иргэний, нийгэм-бизнесийн байгууллагын түншлэл анхдугаар зөвлөгөөн, “Аймгийн иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийн үнэлгээ”, “Төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу”, “Түншлэл ба олон нийтийн оролцоо”, “Орон нутагт олон талт түншлэлийг хөгжүүлэх”, “Төрийн бараа ажил үйлчилгээг нээлттэй ил тод, өрсөлдөөнтэй болгох арга замууд”, “Төрийн зарим чиг үүргийг ИНБ-ууд, бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх боломжууд”, ИНБ-уудад зориулсан “Иргэдийн хэрэгцээнд тулгуурласан төслийн санал боловсруулах” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, “Цэвэр сайхан орчин”, “Хог” төсөл хэрэгжүүлэв.

Багануур дүүргийн төрийн байгууллагуудад төсвөө нээлттэй болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж амжилттай хэрэгжүүлсэн “Шилэн түрийвч” төслийн үйл ажиллагаатай танилцаж, Аймгийн ИТХурлын дарга төрийн бус байгууллагынхантай 2 удаа уулзалт ярилцага зохион байгуулж, мэдээлэл солилцлоо. Төрийн байгууллага, ТББ, иргэдийн харилцааг өргөжүүлэх, нэмэгдүүлэх зорилгоор 2010 оны “Нутгийн хөгжилд таны оролцоо”-ны жил болгон зарлаж, ТББ, хувийн хэвшилтэй хамтран 3 талт түншлэлийн гэрээ байгуулахаар төлөвлөж байна.

2009 оны 01 сарын 07-ны өдрийн “Нийтийн биеийн тамир спортын талаар авах зарим арга хэмжээний тухай 5-р тогтоолын дагуу аймгийн Засаг даргын А/57 дугаар захирамж гарган холбогдох агентлагуудад сар бүр нэрэмжит нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж явуулсан. “Өвлийн спортыг дэмжих” сарын арга хэмжээнд нийт 24 байгууллагын 458, “Монголын тамирчдын баяр, олимпын хөдөлгөөнийг дэмжих” сарын арга хэмжээнд 3 насны ангилалд 24 байгууллагын 480 иргэн, явган аялалын тэмцээнд 16 байгууллагын 120 хүн тус тус оролцсон олон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

“Монголын уламжлалт бий, биелгээ” хөтөлбөр батлах тухай 10 тоот тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. Орон нутагт бий, биелгээний дэд хөтөлбөрийг боловсруулан Баруун Монголын бий, биелгээ, зан заншил, урианхай захчин, баяд ардын бий биелгээ зэргийг судалж, МҮОНТ-ийн бичлэгт “Бэсрэг биелгээ”, “Бид биечид”, “Торнууд сэвгэр”, “Биелэх хүслэн”, “Захчин биелгээ”, “Ховог урианхай” зэрэг бүжгүүдийг бичүүлж, аймаг орон нутгийн томоохон арга хэмжээнд бий биелгээний номерийг тогтмол оруулж байна. Боржигин чуулгын бүжигчдэд ардын бүжгийн дасгалын хичээл бий, биелгээний хөдөлгөөнийг эзэмшүүлэх анхан шатны сургалт явуулж байна. Улирал бүр уран бүтээлчдийн мэргэжлийн шалгалтанд бүжигчдээс бий биелгээ бүжгийн хөдөлгөөнөөр шалгалт авч байна. Энэ онд СТА. Төгсөөгийн дэглэлт “Хос түрлэг”, СТА О.Цэрэнжаргалын “Бид биечид”, Э.Алтанзулын “Ховог урианхай”, МУУГЗ Чимэдцэрэнгийн “Биелэх хүслэн”, МУСТА Нарангэрэлийн “Захчин биелгээ” зэрэг бүжгээр урын сангаа баяжуулсан.

2009 оны Томуугийн А хүрээний H1N1 вирусын халдварын талаар /2009 оны 333, 343, 356/ тогтоолуудын хүрээнд аймгийн хэмжээнд бэлэн байдалд шилжүүлж гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож холбоо зарлаж мэдээллийг аж ауй нэгж байгууллага, ард иргэдэд хүргэх, урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг шуурхай авч Онцгой комисс, гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүнийг үүрэгт ажилд нь оруулж мэдээллийн хэргэгслийг байнгын бэлэн байдалд шилжүүлэн ажилласан. Орон нутгийн 36 байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг үзэж шалган тодотгол хийж орон тооны бус штабын бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг шалган холбоо зарлан мэдээллийн техник хэрэгслэлийн байдлыг тогтмол хангуулан, халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ сэрэмжлүүлгийг аймгийн хэвлэл мэдээллээр байнга мэдээлж байсан.

Удааширалтай хэрэгжиж байгаа тогтоол, шийдвэрүүд:

1. Барилга, дэд бүтцийн салбарт авах зарим арга хэмжээний тухай 2007 оны 10 сарын 31-ны өдрийн 282-р тогтоол. Манай аймагт одоогоор сейсмологи бичил зураглал хийгдээгүй бөгөөд төсөв санхүүгийн асуудал шийдэгдэх хүртэл хийгдэх боломжгүй.

2. Шинээр баригдах барилга байгууламж, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсөв, техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын явцын тухай 2008 оны 11 сарын 25-ны өдрийн 71-р тогтоол. Аймгийн 2 дугаар сургуулийн спорт заалны барилга угсралтын ажлыг 80.0 сая төгрөгөөр гүйцэтгэж дууссан. 100 хүүхдийн цэцэрлэг-яслийн цогцолборын барилга угсралтын ажлын дуусгалтын тооцоог гаргаж экспертизээр батлуулснаар гүйцэтгээгүй 216.0 сая төгрөгт нэмэлт гэрээ байгуулан Дэлхийн зөн ОУБ-ын 40.0 мянган ам.долларын санхүүжилтээр барилгын ажлыг үргэлжлүүлж байна.

Төсвийн зардлыг хэмнэх тухай 2008 оны 128-р тогтоолын дагуу аймгийн хэмжээнд шингэрүүлсэн шатдаг хийн түлшний станц байхгүйн улмаас нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшинд шилжүүлэх боломжгүй учир энэ тогтоолыг хасах саналтай байна.

Өмчлөх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай 2009 оны 05 сарын 14-ны өдрийн 142-р тогтоол. Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан 2009 оны төлөвлөгөөний дагуу иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд өссөн дүнгээр 1655 иргэнд 306.45 га газрыг өмчлүүлээд байна. Газар өмчлүүлэх ажил 12.4 хувьтай байна. Иргэдэд газар өмчлөн авахын ач холбогдолыг тайлбарлан таниулж байгаа боловч иргэд энэ асуудал дээр төдийлөн идэвхитэй хандахгүй байгаа нь газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулахад хүндрэл учруулж байна.

“Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах” хөтөлбөр батлах тухай 2009 оны 05 сарын 27-ны 157-р тогтоолын хэрэгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэр, мэргэжлийн боловсон хүчний хангалтгүй байдлаас болж удааширч байна.

Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сүүлийн жилүүдээр харуулбал:

		2003 ОН	2004 ОН	2005 ОН	2006 ОН	<u>2007</u> <u>ОН</u>	<u>2008</u>	<u>2009</u>	
Хяналтад авсан тогтоол, шийдвэрийн нийт тоо		125	116	73	80	95	64	94	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		183	143	94	123	147	93	129	
Үүнээс	Биелэсэн /100%/	89	93	52	67		32	65	
	Хэрэгжих шатанд	94	50	43	56		59	64	
	Үүний дотор	90 %	51	16	5		13	21	31
		70 %	10	12	12		15	17	8
		50 %	6	11	16		16	8	10
30 %		16	8	7		3	6	9	

		10 %	11	2	3		9	7	6
		0							
	Хугацаа болоогүй								
	Тасарсан			1					
	Үүнээс	Зохион байгуулалтаас		1					
		Хөрөнгийн эх үүсвэр дутагдсанаас							
БИЕЛЭЛТИЙН ДҮН /хувь/			82,8 хувь	86,6 хувь	80.1 хувь	80.5 хувь	85.9 хувь	78,7 хувь	82.8 хувь

2.3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДТАЙ БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ:

Зорилт: 2008онд Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн заалт бүрийг хэрэгжүүлж хэвшүүлэх.

Монгол улсын Ерөнхий сайд аймгийн Засаг даргатай байгуулсан 9 заалт бүхий батламжийн биелэлт 94.4 хувьтай хэрэгжиж байна.

Батламжаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгосон эрх үүргийнхээ хүрээнд ажиллав.

Энэхүү батламжийг хэрэгжүүлэх хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд сумд, байгууллагуудын онцлогт тохируулж Сумдын Засаг дарга нартай “Батламж”, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, ерөнхий менежерүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулж, ажлын үр дүн, төрийн албан хаагчийн стандартын хэрэгжилт, ёс зүйн асуудал, өмчлөгчийн эрхийг нарийн дүгнэж, хариуцлага тооцон ажиллаж байна.

Төр засгийн төлөөлөгчийн хувьд үйл ажиллагаандаа Монгол Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Улсын Их хурал Засгийн газрын шийдвэр, заавар, журмыг удирдлага болгон ажиллаж, бүрэн эрхийнхээ хүрээнд 444 захирамж гаргасан.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн Засаг даргын удирдах шуурхай зөвлөгөөний дэг, журмыг шинэчлэн баталж оролцогсодын хариуцлагыг тодорхой болгон төрийн үйлчилгээг шуурхай хүнд сурталгүй болгоход анхаарч ажиллалаа. Сумдын ЗДТГ, байгууллагууд үйлчилгээний чиглэл, хариуцах эзэн, дүрэм журмаа ойлгомжтой хэлбэрээр ил тавьж гарын авлага бэлтгэн иргэдэд хүргэж байна. Төр, засаг, орон нутгийн бодлого шийдвэрийг иргэдэд хүргэх ажлын хүрээнд “Говьсүмбэрийн мэдээ” сонинг 8 нүүрээр 14 хоног тутам гаргаж, Иргэдтэй ажиллах нээлттэй өдөрлөгийг сумдад 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 6641 иргэнд үйлчилгээ үзүүлж, “Нэг цонхны үйлчилгээ”-г нээн ажлын 5 өдөр ажиллуулж сард дунджаар 3921 иргэн, нийт 42089 иргэнд үйлчилсэн байна. Иргэдийг

хүлээн авах байраар 33 иргэн ирж санал хүсэлтээ гаргаснаас 4 асуудлыг бусад байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлж 29-г өөрсдөө шийдвэрлэсэн байна. Аймгийн Засаг даргын Тамгын газраас 9 удаа 91 айл өрхөөр орж амьдрал ахуйтай нь танилцаж тэдний санаа бодлыг сонсон байна.

Төрийн болон үйлчилгээний 20 гаруй байгууллага хуваарийн дагуу Пүрэв гариг бүр FM радиогийн ярилцлага хийж 70-аад иргэний санаа бодлыг сонсож, тавьсан хүсэлтийг судалж зохих арга хэмжээ авч хэвшлээ.

2009 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлого 1603.9 сая төгрөг буюу 118.7 хувиар биелж, төсвийн зарлагын гүйцэтгэл 1541.9 сая төгрөг буюу 98.5 хувьтай ба нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 311.8 сая төгрөгт хүрч төсөв хэмнэлттэй зарцуулагдсан. Орон нутгийн төсвийн зарлагын 92.3 хувийг орон нутгийн татварын болон бусад орлогоор санхүүжүүлэв. Орон нутгийн төсвийн авлага 69.2 хувиар буурч 8.3 сая, өглөг 26.4 хувиар 0.4 сая болсон бол улсын төвлөрсөн төсвийн хувьд авлага 1.7 дахин буюу 15.7 сая төгрөг, өглөг 5 дахин буюу 8.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлтэй, нийт авлагын 87.6 хувийг БСШУСайдын багц, нийт өглөгийн 81.1 хувийг ЭМСайдын багц /цалин, түлш халаалтын тооцоо/ эзэлж байна. Үүний шалтгаан нь тодотголоор төсвийг үндэслэлгүй хийсэнтэй холбоотой. Улсын төвлөрсөн төсвийн зарлагын гүйцэтгэл 4898.6 сая төгрөг буюу 96.6 хувьтай байна. Улсын төвлөрсөн төсөвт татварын орлогыг нэр төрлөөр нь 1083.8 сая төгрөг буюу 108.3 хувиар, УНДЕГ-ын санд төвлөрүүлэх орлогыг 39.9 сая төгрөг буюу 133.8 хувиар давуулан төвлөрүүлсэн.

. Аймгийн хөгжлийн бодлогын тулгуур болсон нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах зорилгоор “Иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай байх” нөхцлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд 44 үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Боловсролын байгууллагад 88.6 сая хөрөнгө оруулалт хийгдэж, Баянтал сумын 4-р сургуулийн хичээлийн байр болон дотуур байр, цэцэрлэгийг засварлан шинэ байранд оруулсан. Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан. Цэцэрлэгийн хамран сургалт 69.8 хувь Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 83.5 хувь, Ерөнхий боловсролын хамран сургалт 98 хувьтай байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийг стандартын дагуу засварлан тохижуулахад 30 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийлээ. Аймгийн хэмжээнд эхийн эндэгдэл гараагүй. Халдварт өвчний тохиолдол өмнөх оноос 131-ээр буурлаа..

Иргэдийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд хамруулах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслүүдийг дэмжин ажиллаж байна

Засгийн газраас гаргасан 94 тогтоол шийдвэрийг хяналтад авч биелэлтийг улирал тутам мэдээлж байна.

Батламжийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж Засгийн газарт тайлагнаж байна.

2.4.АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үзэл санааг тулгуур үндэслэл болгож, орон нутгийнхаа нөөц боломж, онцлогыг харгалзан 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулан жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжилд тусган хэрэгжүүлж ирэв. 6 зорилтын 97 арга хэмжээн 43.7 хувьтай хэрэгжүүлж байна.

1.ТӨРИЙН УДИРДЛАГА, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Иргэн төрийн албанд орох адил тэгш боломж, төрийн албыг мэргэшсэн чадвартай албан хаагчдаар бэхжүүлэх:

“Төрийн албаны тухай” хуульд өөрчлөлт орсонтой холбоотой төрийн захиргааны албанд түр томилогдон ажиллаж байсан албан хаагчдыг ажлаас нь чөлөөлүүлж, сул орон тоог журмын дагуу нийтэд зарлан сонгон шалгаруулж төрийн албанд томилох ажлыг журмын дагуу зохион байгуулж байна. Мэргэшлийн шалгалтад орж нөөцөд бүртгэгдээгүй иргэн төрийн захиргааны албанд түр томилогдон ажиллах явдал гараагүй. Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зарыг орон нутгийн болон төвийн хэвлэлүүдэд нээлттэй тавьж байна. Төрийн албаны мэргэшлийн шалгалт, удирдах албаны сонгон шалгаруулалтын талаар маргаан, зөрчил гараагүй.

Төрийн албан хаагчийг чадваржуулах:

Төрийн байгууллагууд *Сургалт* хөтөлбөртэй болж ажлын байран дээрх сургалтыг тогтмолжуулж төрийн байгууллагуудын захиалгын дагуу “Төрийн албаны шинэчлэл”, “Гүйцэтгэлийн удирдлага”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” зэрэг сэдвээр 296 , Удирдлагын академид урт, богино хугацааны төлөвлөгөөт сургалтад 16, Хөтөлбөр төслийн газруудтай хамтран зохион байгуулсан *Төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу* сургалтад 28, *Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэл* сургалтад 47 нийт 136 албан хаагчдыг хамруулсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар албан хаагчдаа тогтвортой ажиллуулах зорилгоор ажлын үр дүнг харгалзан 5 жил тутамд урамшуулал олгодог.

Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын хариуцлагын дээшлүүлэх:

Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар аймаг сум, багийн Засаг дарга, түүний ажлын албаныхан, зарим агентлагт сургалт зохион байгуулж

Мөн аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай Батламж байгуулж, түүнийг хэрэгжүүлэх арга зүй, анхаарах асуудлын талаар семинар зохион байгуулж, гарын авлага бэлтгэж өгөв.

Төрийн албаны салбар зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн талаар 3 гомдол ирснийг “Маргаан хянан шийдвэрлэх комисс” томилон, шалгуулж гарсан шийдвэрийг маргалдагч талуудад хүргүүлэн биелэлтийг хангууллаа. Төрийн албаны төв зөвлөлд очсон 3 иргэний гомдлыг шалган тодруулж санал дүгнэлтээ хүргүүлсэн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчин ажилласан 1 Сумын Засаг дарга, 1 албан хаагчийг хуулийн дагуу арга хэмжээ авч ажлаас халсан.

Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг өргөжүүлэх:

Төр иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг өргөжүүлэх зорилготой “ Мерси Кор” олон улсын хөтөлбөрийн газартай хамтран “Түншлэл 2009” зөвлөгөөн, “Аймгийн иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийн үнэлгээ”, “Төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу”, “Түншлэл ба олон нийтийн оролцоо”, “Орон нутагт олон талт түншлэлийг хөгжүүлэх”, “Төрийн бараа ажил үйлчилгээг нээлттэй ил тод, өрсөлдөөнтэй болгох арга замууд, төрийн зарим чиг үүргийг Иргэний нийгмийн байгууллагууд, бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх боломжууд сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас санаачлан “Хот хоорондын такси үйлчилгээнд явдаг жолооч нар”, “Биенес эрхлэгчид”, Ахмадууд, Залуучууд, Төрийн бус байгууллагуудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, тэдний санал бодол, төрийн зүгээс ямар бэрхшээл тулгарч байгаа талаар сонсож, төрийн үйлчилгээний талаар тодорхой мэдээлэл өгч харилцан хамтран ажиллахаар зөвлөмжүүд гаргаад байна. Мөн хот доторх үйлчилгээнд явдаг “такси үйлчилгээ”-ний үнэ тарифын талаар иргэдийн гаргасан гомдлыг хүлээн авч, аймгийн удирдлагууд таксины үйлчилгээ эрхлэгч нартай уулзалт хийж зөвшилцсөний үндсэнд 1 хүнээс 1 удаагийн үйлчилгээний үнэнд 700 төгрөг авдаг байсныг 500 төгрөг болгон буулгалаа.

Төрийн анхан шатны үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх:

Төрийн анхан шатны үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх “Баг” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, сум бүрийг жишиг багтай болгохоор төсөл боловсруулахаар сум, багуудаас санал авч байна.

“Баг” хөтөлбөрийн хүрээнд багуудын ажиллах нөхцлийг сайжруулах үүднээс хөдөөгийн 6 багийг унаажуулж, компьютер, техник хэрэгслээр ханган албан тасалгааг тохижууллаа.

Багийн Засаг дарга нарт “Засгийн газар болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт 2 хоногийн сургалт, багийн Засаг дарга нарын дотоод ажилтай танилцаж, зөвлөгөө өгөх ажлуудыг зохион байгуулж хэвшээд байна. Багуудын хэсгийн ахлагч нар, багийн сахиулуудын урамшуулалыг 2010 оноос нэмэгдүүлж олгохоор шийдвэрлэж хамгийн олон хүн амтай Сүмбэр сумын 3 багийг нийгмийн ажилтантай болголоо.

Сум, багийн өдөрлөгийг тогтмолжуулж төрийн байгууллагууд төр засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомж, аймаг орон нутгаас авч хэрэгжүүж байгаа арга хэмжээг танилцуулж иргэдийн тавьсан санал хүсэлтийн барагдуулалтыг дараагийн өдөрлөг дээр тайлагнаж хэвшсэн.

Хөдөөгийн багуудын Засаг дарга нарыг бензин, шатахуунаар хангаж, 20-30 хоногт айл өрхөөрөө орж байхаар төлөвлөж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байна.

Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй шуурхай явуулах:

Төрийн албыг чирэгдэлгүй шуурхай хүнд сурталгүй байхад анхаарч, ажлын ачаалал давхардлыг шат бүрээр судалж хэлтсүүдийн ажил үүргийг ил тод болгосон. Нийтээр дагаж мөрдөхөөр гарах шийдвэрийн төслийг эрх ашиг нь хөндөгдөж буй талд танилцуулж, тэдний санал бодлыг авч хэвшсэн. Төрийн байгууллагууд иргэдэд нээлттэй байж шуурхай үйлчилдэг болгох зорилгоор албан хаагч бүрээр төрийн үйлчилгээний чиглэл, танилцуулга, иргэдэд үзүүлэх үйлчилгээний журмыг товч бичиж ил тод тавьж иргэдийн санал гомдлыг хүлээн авах, зөвөлгөө өгөх байр санал хүсэлтийн хайрцаг, утас ажиллуулж байна.

Төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага бүр иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах нээлттэй утас, санал хүсэлтийн хайрцаг, дэвтэр ажиллуулан, мөн "Нэг цонхны үйлчилгээ", "Иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөг", FM радиогоор иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байна. Тайлант онд 11350 санал, өргөдөл, гомдол ирснээс өргөдөл, хүсэлт 11197 буюу 98.7 хувь, гомдол 153 буюу 1.3 хувийг эзэлж байна.

Ирсэн өргөдөл гомдлын 11118 буюу 97.9 хувийг өөрдсдөө шийдвэрлэж, 189 буюу 1.9 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлсэн байна.

Нийт өргөдөл, гомдлын 113-ыг амаар, 1-ыг цахим сүлжээгээр 11100-г бичгээр хүлээн авсан байна.

Агентлагуудад дээд газраас буюу аймгийн Засаг даргаас шилжүүлсэн 74 өргөдөл, гомдлын 65 нь шийдвэрлэгдэж, хугацаа болоогүй 9 өргөдөл, хүсэлт байна.

Сумд байгууллагууд үйлчилгээний чиглэл, хариуцах эзэн, дүрэм журмаа иргэдэд ойлгомжтой хэлбэрээр ил тавьж гарын авлага бэлтгэн иргэдэд хүргэж байна

Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг бүртгэж баталгаажуулах

2009 онд ЭХӨЭТХолбоотой бусад эрхийн 1328 мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд 100% шийдвэрлэж, 16.529.966 төгрөгийн бүртгэлийн хураамж, 201.877 төгрөгийн тэмдэгтийн хураамж, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны 18.803.000 төгрөгийн татварын орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

ЭХЭБ-н Архиваас олгосон лавлагаа, мэдээлэл, хуулбарын үйлчилгээний хураамжид 1693000 төгрөг, ИБ-ын архивын лавалгааны орлого 1993000 төгрөгийн үйлчилгээний орлого төсөвт оруулсан байна.

Иргэний бүртгэлийн чиглэлээр

Иргэний үнэмлэхээ сунгуулах, дахин болон шинээр авах хүсэлт гаргасан 867 иргэнд үнэмлэх олгосон байна.

Иргэний үнэмлэх олголтыг хөнгөн шуурхай болгоход анхаарч, иргэдэд зөвлөгөө мэдээллийг тухай бүр өгч, ялангуяа иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн иргэдийн холбогдох баримтыг бүрэн бүрдүүлж, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27-р зүйлд заасны дагуу арга хэмжээ авах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө болон сумдад зохиосон “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр ногдуулах торгуулийн хэмжээг бууруулах зэргээр уян хатан ажилласнаар иргэд үнэмлэхээ гээгдүүлдэг явдал өнгөрсөн оны мөн үеийнхээс 27 хувиар буурсан байна.

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн үйлчилгээг нийт 759 иргэнд үзүүлсний дотор төрсний бүртгэл 357, гэрлэсний бүртгэл 165, гэрлэлт сэргээсний бүртгэл 1, гэрлэлт цуцласны бүртгэл 11, хүүхэд үрчилсний бүртгэл 17, эцэг тогтоосны бүртгэл 60, овог, эцэг/эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 66, нас барсны бүртгэл 82-ыг тус тус бүртгэсэн байна.

Иргэдийн бичиг баримтын хадгалалт, хамгаалалтын байдлыг тогтоох зорилгоор оршин суугаа хаягаар 8 удаа, албан байгууллагаар 3 удаа үзлэг, шалгалт явуулж, үүнд давхардсан тоогоор 4061 өрх, 61 байгууллага, 14519 иргэн хамрагдаж, иргэний үнэмлэхтэй холбоотой 205, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн чиглэлээр 93, шилжилт хөдөлгөөний чиглэлээр 546, нийт 844 зөрчил илрүүлж, тэдгээрийн 71.2 хувь буюу 601 зөрчлийг арилгаад байна.

Хуулийн этгээдийн бүртгэл

Үйл ажиллагаа явуулж байгаа 101 аж ахуй нэгж, 50 төсөвт байгууллагын хувийн хэрэг материал, Хуулийн этгээдийн бүртгэлийн дэвтэр 9, бусад гэрчилгээ гарын авлага, тэмдэгийн хамт хүлээн авсан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр Улсын бүртгэлийн ажиллагаа болон шинээр хуулийн этгээд байгуулахад холбогдох бичиг баримт бүрдүүлэх талаар гарын авлага, зөвлөмж, гарган сурталчиллаа.

19 ХХК, 2 хоршоо, 2 төсөвт байгууллага, 1 шашны байгууллага бүртгүүлэх материал хүлээн авч хуулийн хугацаанд улсын бүртгэлд бүртгэсэн.

Иргэний баримт бичгийн зөрчил гаргасан 187 иргэнд 1664000 төгрөгийн торгууль шийтгэвэр ноогдуулсан байна.

Хууль эрх зүйн хүрээнд

1.Хууль тогтоомжийн системчилэл, мэдээллийн ажлын талаар:

Батлагдсан журмын дагуу www.legalinfo.mn –ээс 1250 хүн, 132 байгууллагад нийт 1382 удаа лавлагаа мэдээлэл өгч, гар сангаас 1610 хүн, 310 байгууллагад нийт 1910 удаа лавлагаа, мэдээлэл өгсөн. Мөн www.legalinfo.mn эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс шинээр гарч буй хууль эрх зүйн шаардлагатай мэдээллээ авч хэвшин, бусад төрийн албан хаагчдад ашиглах талаар зөвлөж ажиллалаа. Шинээр гарсан хууль тогтоомжийн мэдээллийг орон нутагтаа сурталчилан, нийтэд нээлттэйгээр самбарт байрлуулан иргэд байгууллагад мэдээлдэг.


Бүх шатны Засаг дарга нар “Төрийн мэдээлэл”, “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийг захиалан албан ажлын хэрэгцээнд ашиглаж байна.

2. Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар:

Аймгийн Засаг даргаас гаргах эрх зүйн актыг эрх зүйн үндэслэлтэй, алдаагүй гаргах зорилгоор 444 захирамжинд виз олгосон бөгөөд энэ онд нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан нийтлэг хэм хэмжээ тогтоосон захирамж гараагүй байна. Аймгийн Засаг даргын захирамжаар 3 журам батлуулан мөрдүүлж байна.

Сумдын Засаг даргын нарын гаргасан 526 захирамжийг хянаж, зөрчилтэй 51 захирамжийг засуулсан.

Нийт захирамжийн зөрчил ихэссэн нь “2009 онд сумдын Засаг дарга нар шинээр томилогдсон, Сумдын захирамжийн төсөл боловсруулдаг албан хаагчид янз бүрийн шалтгаанаар солигдсон Хуулийн өөрчлөлтүүдийг албан хаагчид судлаагүй зэрэгтэй холбоотой. Энэ байдалд дүгнэлт хийж, 2010 онд анхаарч ажиллахаар төлөвлөөд байна.



3. Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

Нутаг дэвсгэрийн хүрээнд эрх зүйн сургалт сурталчилгааг зохион явуулахдаа хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, бүх нийтэд эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, мэдлэгийг нь дээшлүүлэх, албан бус сургалтын тогтолцоог бий болгох зорилтуудыг тавин ажиллаж байна.


Иргэдэд зориулсан эрх зүйн албан бус сургалтыг судалгаанд, байгууллага аж ахуй нэгжид зориулсан

сургалтыг ирүүлсэн санал, хүсэлт, хэрэгцээнд үндэслэн улирал, сараар төлөвлөн, “Иргэдийн эрх зүйн


хөтөч” номоор, Уралдаан тэмцээн, ярилцлага, уулзалт, хэлбэрээр зохион байгуулж байна.

Сургалтуудын **үр дүнд** иргэд хуулиар олгогдсон эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх, өөрсдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалахад хууль эрх зүйн тодорхой мэдлэг хэрэгтэйг ойлгож улмаар иргэдийн эрх зүйн боловсролын түвшинд тодорхой хэмжээний ахиц гарсан

Эрх зүйн албан бус сургалтыг 41 удаа, 110 сэдвээр зохион байгуулж нийт 2140 хүн хамрагдсан байна.



Сумдын сургалтыг нэгтгэвэл:



Судалгаа:

- ▶ Эрх зүйн албан бус сургалтын эрэлт, хэрэгцээ шаардлага иргэдийн дунд ямар байгааг мэдэх зорилгоор суманд зохион байгуулдаг “Нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр 6 асуулт бүхий санал асуулгын хуудсаар
- ▶ Зарим сургалтын дараа сэтгэл ханамжийн судалгаа /аялах хайрцагын үнэлгээ, сургалтын чанар, хүртээмж/

№	Асуулт	Дүн
1	Таны нас, хүйс	Судалгаанд хамрагдагсдын 60% буюу 30 нь эрэгтэй, 40% буюу 20 нь эмэгтэй байснаас насны хувьд 20% буюу 10 нь 17-25 хүртэл, 42% буюу 21 нь 25-36 хүртэл, 32% буюу 16 нь 37-49 хүртэл, 6% буюу 3 нь 50-иас дээш насны хүмүүс байсан
2	Боловсрол	46% буюу 23 нь дээд, 36% буюу 18 нь бүрэн дунд, 12% буюу 6 нь бүрэн бус дунд, 6% буюу 3 нь бага боловсролтой хүмүүс байлаа.
3	Ажил эрхлэлт	72% буюу 36 нь ажил эрхэлдэг, 28% буюу 14 нь ажил эрхэлдэггүй хүмүүс байлаа.
4	Та өөрийнхөө хууль, эрх зүйн мэдлэгийг хэр зэрэг гэж боддог вэ?	16% буюу 8 нь боломжийн, 64% буюу 32 нь дунд зэрэг, 18 % буюу 9 нь хангалтгүй, 2% буюу 1 хүн мэдэхгүй гэсэн сонголтыг дугуйлсан байна.
5	Та хууль, эрх зүйн чиглэлээр мэдлэгээ дээшлүүлэх нь зөв гэж үздэг үү?	100% буюу 50 хүн тийм гэж хариулсан байна. Энэ нь иргэдийн зүгээс хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх сонирхол идэвхтэй байгаа нь ажиглагдаж байна.
6	Та ямар хууль, эрх зүйн чиглэлээр мэдээлэл авахыг хүсч байна?	бүх чиглэлээр 3, хөдөлмөрийн эрх зүйгээр хамгийн олон буюу 15, Хүний эрхээр 3, Тэтгэвэр, тэтгэмжийн талаар 2, Бизнесийн эрх зүйгээр 2, Газрын тухай хуулиар 2, иргэний эрх зүйгээр 5. Гэр бүлийн хуулиар 1, Эрүүгийн хуулиар 3, Иргэний хэрэг Шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар 1, Төрийн албаны тухай

		хуулиар 1, олон улсын эрх зүйгээр 1, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар 1, боловсролын тухай хуулиар 1, Үндсэн хуулиар 1 сургалт авах талаар бичсэн байлаа.
--	--	--

Өөрсдийн боловсруулсан болон Хууль зүй дотоод хэргийн яам, “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төслийн газараас гаргасан болон бусад материал, гарын авлагуудыг байгууллагууд дээр зохион байгуулсан сургалтандаа ашиглаж, Нээлттэй өдөрлөг болон, багийн өдөрлөгүүдэд оролцсон 1500 гаруй иргэнд тараасан байна.

Төрийн албан хаагчид, орон нутгийн хэлтэс, агентлагуудад зохион байгуулах сургалтын тодорхой давтамжтай зохион байгуулж, сургалтаа дүгнэн АХА”, “Оргил цэг,” “Дэвжээ” гэх мэт тэмцээн уралдаан зохион байгуулсан. Тухайлбал: 500 гаруй оюутантай Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан багш, ажилчдын дунд “**Сайн уу муу юу**” уралдаан тэмцээнийг, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын дунд **Оргил цэг** тэмцээнийг тус тус зохион байгуулсан.

Эрх зүйн албан бус сургалтуудын ач холбогдол, үр дүн, алдаа дутагдлыг дүгнэх зорилгоор сургалтанд хамрагдагсдаас сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэн ажилдаа ашиглаж хэвшээд байна. “Хуульч хүн бүр хууль сурталчлагч” гэдэг үүднээс орон нутгийн хуульчид буюу Шүүх, Цагдаа, Прокурорын байгууллагад ажилладаг төрийн албан хаагчдыг сургалтад өргөнөөр хамруулахыг зорьдог. Ингэснээр хүмүүст хууль эрх зүйн талаархи зөвлөгөөг давхар, өргөн хүрээнд түгээх боломжтой .

“Эрднэсийн гайхамшиг” 107 радиотой хамтран “**Архидалтын эсрэг**” “**Эрүүл аж төрөхүй**” сэдвийн хүрээнд “Эрүүл аж төрөхүй гэж юу вэ” , “Чөлөөт цаг”, “Хууль ба Хайр”, “Шашин” , “Чойр хөгжил” зэрэг 1 цагийн радио цуврал нэвтрүүлгийг хийж иргэдэд хүргэж эхлээд байгаа нь шинэлэг үр дүнтэй ажил болсон.

Дээрх радио нэвтрүүлгүүдийг зохион байгуулахад богино хэмжээний радио шторк олноор бэлтгэн өдөр бүр тодорхой давтамжтайгаар цацаж байна.

Хууль зүйн хэлтсээс улирал бүр эмхэтгэн гаргадаг **Мэдээлэл** сэтгүүлээ шинэ тутам гарч буй хууль эрх зүйн мэдээлэл, хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа, бусад мэдээллийг сурталчилж 4 дугаар гаргаж 500 гаруйг иргэдэд тараасан.

“Аялах хайрцаг”-ыг сумдад хариуцаж буй ажилтнуудад 12 удаа эрх зүйн мэдээлэл бүхий 30 гаруй төрлийн 3000 гаруй гарын авлага, тараах материалаар хангаж ажилласанаар “Аялах хайрцаг ”-ны мэдээ тайлан тогтмолжиж, хөдөөгийн 5 багаар нийт 10 удаа, 300 гаруй айлаар аялаж 2500 орчим хүнд мэдээлэл өгсөн байна.

Хөдөөгийн малчид “Аялах хайрцаг”-ны талаар сэтгэл ханамжтай байгаагаар санал хүсэлтийн дэвтэрээр илэрхийлсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 9-11 дүгээр ангийн сурагчдын дунд “Архидалтын эсрэг хамтдаа”, “Хууль бидний амьдралд” сэдэвт зохион бичлэгийн уралдаан зохион байгуулж шилдэг зохион бичлэгийг Говьсүмбэрийн мэдээ сонинд нийтлэсэн.

Сумдын нотариатын үүрэг гүйцэтгэгчийн ажлын тайланг улирал бүр хүлээн авч тухай бүр хянан ажиллаж байгаа бөгөөд нотариатын үүрэг гүйцэтгэгчийн үйлдэлтэй холбогдуулан гарсан гомдол мэдээлэл байхгүй байна. Харин аймгийн төвд ажилладаг 1 нотариатчийн хууль зөрчсөн үйлдэл, үйл ажиллагаанд удаа дараа гомдол гарч иргэдийг чирэгдүүлдэг болсныг нотариатчдын танхим, Хууль зүйн дотоод хэргийн яаманд уламжилсан боловч дорвитой арга хэмжээ аваагүй байна.

Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 8500 гаруй хүнд нотариатын үйлчилгээ үзүүлсэн байна.

Орон нутагт шударга ёс, ил тод, нээлттэй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг Хууль зүйн хэлтсийн даргаар ахлуулан аймгийн Засаг даргын А/390 захирамжаар байгуулан төлөвлөгөө 250 гаруй иргэдийн судалгаанд үндэслэн боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулсан.

Нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд :

Нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргэтэй тэмцэх хүрээнд Цагдаагийн хэлтсийг өдөр тутмын удирдлагаар хангаж нэгдсэн болон хэсэгчилсэн 27 арга хэмжээ зохион байгуулж ажилласнаар гэмт хэргийн илрүүлэлтийн хувь Өмнөх онд 16,1 хувь байсан бол 53,3 хувь болсон. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт, урьдчилан сэргийлэх талаар баримталж буй бодлого, аймгийн эрүү хэв журмын нөхцөл байдал сэдвээр аймгийн ИТХ-ын ГХУСА33, Цагдаагийн хэлтэс, Боловсрол, соёлын газартай хамтран 14 байгууллага, ЕБС-ийн ахлах ангийн 360 гаруй сурагчдад зохион байгуулсан. “Эрднэсийн гайхамшиг” 107 радиотой хамтран **Архидалтын эсрэг “Эрүүл аж төрөхүй”** сэдэвт цогц цуврал радио нэвтрүүлгийг өдөр бүр тодорхой цагт, төлөвлөгөөтэй зохион байгуулсан нь шинэлэг үр дүнтэй ажил болж байна. Замын цагдаагийн зохицуулагчийн орон тоог нэмэгдүүлснээр 24 цагийн байнгын ажиллагаатай постыг ажиллуулж, постын орчмын гэрэлтүүлэг, автомат хаалт, хажуугийн зогсоол барихад 5,8 сая төгрөг, замын тэмдэгжүүлэлтэнд 5 сая төгрөг зарцуулж ажилласнаар зам тээврийн гэмт хэрэг өмнөх оноос 27,3 хувь буурсан. 2 сард “Сайн малчдын зөвлөгөөн” зохион байгуулж, малчидтай хамтран ажиллах талаар уриалга гарган, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх санд 2.4 сая төгрөгний хандив цуглуулж, алдуул малын нэгдсэн сантай

болж эхлээд байна. Аймгийн Засаг даргын захирамжаар Архидан согтуурахтай тэмцэх чиглэлийг батлан хэрэгжүүлж, “Архидалтын эсрэг хамтдаа” зөвлөгөөнийг хууль хяналтын байгууллага, Архидалт мансуурлын эсрэг ассоциацитай хамтран зохион байгуулж, архинд хамаарлатай иргэд, төрийн бус байгууллага, архи худалдан борлуулдаг цэг салбарын ажилтнууд зэрэг 100 гаруй хүн хамрагдаж, 500000 төгрөг зарцуулсан. Аймгийн Наркологийн танхимыг 4,0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжөөр ханган тохижуулж_ үйл ажиллагааг нь тогтмолжуулан архи байнга хэрэглэдэг 55 хүнтэй наркологич нийгмийн ажилтны хамт биечлэн уулзаж, хууль эрх зүйн зөвлөгөө өгч амьдрал ахуй орчин, архи хэтрүүлэн хэрэглэж буй шалтгаан нөхцлийг нь судлан хорт зуршлаас нь ангижруулах талаар хамтран тэмцэх ажлыг эхлүүлээд байна.

Архивын үйлчилгээний талаар

Аймгийн архив нь 50 сан хөмрөг үүсгэгчийн 4328 хадгаламжийн нэгж , 70 гэрэл зураг, дүрс бичлэгийн 4 баримт хадгалагдаж байна.

Татварын хэлтэс, улсын бүртгэлийн хэлтэс, мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагууд архивын баримтыг хадгалах өрөөтэй болж 4 байгууллагын архивын байранд галын дохиол хамгаалалын системийг суурилуулж, аймгийн архивын тасагт шаардлагатай техник хэрэгсэл тоног төхөөрөмжийг шинэчлэхэд зориулж 1750000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас зарцуулан тоног төхөөрөмжөөр хангаж цахилгаан дулааны шугамыг шинэчлэн засварлаж хадгалалт хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүллээ.

Аймгийн хэмжээнд 14 удаа сургалт зохион байгуулж 200 гаруй ажилтныг хамруулав.

42 байгууллагад хяналт шалгалт явуулж 30 байгууллагад сэдэвчилсэн, 8 байгууллагад иж бүрэн шалгалт, 4 байгууллагад давтан шалгалтыг хийсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2009 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Улсын үзлэг явуулахтухай” 37 дугаар захирамжийн дагуу архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг сайн хангаж үзлэгээр 92.1 хувьтай дүгнэгдлээ.

2. НИЙГМИЙН БОДЛОГЫН ТАЛААР

2.1 Боловсролын салбарт

Хөрөнгө оруулалт, спортын талаар:

“Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл “ хөтөлбөрийн хүрээнд Баянтал сумын 4-р сургуулийн дотуур байрыг ашиглагдахгүй байсан барилгын нэг орцны их засварын ажлыг 261.4 сая төгрөгийн хөрөнгөөр 60 хүүхдийн шинэ дотуур байрыг ашиглалтад орууллаа. Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн их

засварт 12.6 сая, Сүмбэр сумын 2-р сургуулийн Спорт заалны засварт 80,5 сая, 1-р сургуулийн сантехникийн засварт 50,0 сая г, Баянтал сумын 4-р сургуулийн шинэ байрны тавилгад 6,3 сая, 4-р цэцэрлэгт 8,9 сая Боловсрол, Соёлын газарын засварт 35,2 сая, Шивээговь сумын 3 дугаар сургуульд хөгжмийн зэмсэгт 91,1 сая төгрөг, Хүүхэд бүрт сурах бичгээр хангахад 99,4 сая төгрөгийг тус тус зарцуулж, Боловсролын салбарт 552,87 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

“Монгол Улсыг хөгжүүлэе сан”-аас 77,1 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, нийт **1493** хүүхэд үдийн цай хөтөлбөрт хамрагдсан.

Төвийн бүсийн Багш нарын спортын наадмыг аймагтаа зохион байгуулж 5 аймгийн 200 гаруй тамирчид оролцсон. Үйл ажиллагаанд Аймгийн Засаг дарга **1,5** сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Сургалтын стандартыг хангах талаар :

2009-2010 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 4 сургуульд 167 багш /мэргэжлийн зэрэгтэй 61 багш / ажиллаж, 2894 сурагч суралцаж, нэг багшид дунжаар 17,3 сурагч ногдож, бүлэг дүүргэлт дунджаар 29,2 байна. 3 дотуур байранд 80 хүүхэд амьдарч байна

7 цэцэрлэгийн 38 бүлэгт 1015 хүүхэд, сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтанд 16 хүүхэд хамрагдаж, 32 багш ажиллаж байна.

Цэцэрлэгийн хамран сургалт 69.8 хувь Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 83.5 хувь, Ерөнхий боловсролын хамран сургалт 98 хувьтай байна.

“Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” болон “Аймгийн боловсролын салбарыг 2007-2010 онд хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөө”-ний дагуу 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжих, багшийн ажлыг төлөвлөж, үнэлэх ажлууд хийгдсэн.

“**6** настай хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын арга зүй” сэдэвт бүсчилсэн сургалтыг зохион байгуулж, **6** настай хүүхэдтэй ажиллах 44 багш хамрагдлаа.

Боловсролын хөтөлбөрийн хүрээнд Зүүн бүсийн аймгуудын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Англи хэл”-ний бүсийн олимпиад, Сургуулийн өмнөх насны хүүхэд, багшийн дунд “ Хөгжилтэй математик “ аймгийн олимпиад, Монгол улсын гавъяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит “Монгол бичиг “ –ийн олимпиадыг тус тус зохион байгууллаа.

2009-2010 оны хичээлийн жил Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд **8** мэргэжлээр **567** оюутан суралцаж байна. 2010 онд төгсөх **335** оюутныг “ Оюу-Толгой”, “Monnis”, “ МАК ” ХКопаниуд ажиллуулах санал ирүүлсэн. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал **90.0** хувьтай байна

Багш нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх талаар:

“ Боловсролын шинэчлэлд багшийн үүрэг “, “Ерөнхий боловсролын 12 жилийн 7-р ангийн шилжилтийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй”, “ 12 жилийн сургуульд мөрдөх стандарт төлөвлөгөө хөтөлбөрийн талаар баримтлах бодлого”, “Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын тухай”, “Хичээлийн шинэ жилийн зорилтын тухай “ зэрэг сургалтанд сургууль, цэцэрлэгийн 75 багшийг хамрууллаа.

БСШУЯам, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй FTI “ Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл “ төсөл хөтөлбөрийн хүрээнд бага ангийн багш нарт, МУБИС-ийн МХСС-ийн захирал Ц.Өнөрбаян Ph.D , багш А.Цог-Очир Ph.D нарыг урж, аймгийн нийт монгол хэлний багш нарт “Стандартын дагуу хөтөлбөр боловсруулах арга зүй“ сэдэвт сургалт, БСШУЯ-ны захиалгаар “ Golden Bridge “ төвийн хэрэгжүүлж байгаа “ Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх“ төслийн хүрээнд аймгийн нийт гадаад хэлний багш нар он-лайн болон вакумжуулсан сургалтанд тус тус хамрагдсан.

Соёл урлагийн бодлогын хүрээнд :

Соёл, урлагийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, дээд боловсролтой мэргэжлийн боловсон хүчнээр ханган, Боржигин чуулгын удирдлага болон уран бүтээлчдийн менежментийг сайжруулан, шинэ зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж, мэргэжлийн урлагийн байгууллагуудтай хамтран ажилласан.

Боржигин чуулгын тайз засал, уран бүтээлчдийн хувцас, тоног төхөөрөмжөөр хангахад 7.9 сая төгрөг зарцууллаа.

“ Бодончар сэцэн “ дуулалт жүжиг “ Аймшигт анчин Пандухайн паян “ хүүхдийн дуулалт жүжиг зэрэг шинэ уран бүтээл туурвиж, “ Боржигины багачууд “, “ Яргуй “хүүхдийн урлагийн наадам, “Репийн хаан “, “ Монголжингоо “ , Хаврын баяр”, “ Цэнгээнт бүжиг “ “ Бяцхан мисс- Мистер “ , “ Эх орны сэдэвт дууны уралдаан “, “ Уртын дууны уралдаан “ зэрэг уламжлалт 12 арга хэмжээ зохион байгуулсан.

Дорноговь аймгийн “ Саран хөхөө “, Дундговь аймгийн “ Төв халхын дуулалт театр “ , Хэнтий аймгийн “Хан Хэнтий” чуулгатай хамтран уран бүтээлийн туршлага солилцох уулзалт, тоглолт, Дорноговь аймгийн 4 сум, Хэнтий аймгийн 4 сум , Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт байрлах хилийн дугаар ангийн заставууд, Төв аймгийн Эрдэнэ зэрэг сумдад 31 аялан тоглолт, орон нутагтаа 21 урлагийн арга хэмжээ зохион байгуулсан.

Чуулгын үйл ажиллагаа, уран бүтээлийн тоглолтыг МҮОНТ-ийн соёл, урлагийн редакци, “Говьсүмбэр мэдээ ” сонин, MN-25, ТҮ-5 телевизүүдээр сурталчилсан.

Уран бүтээлчдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, уран бүтээлчдийн урын санг баяжуулах, тэдний идэвхийг өрнүүлэх үүднээс “Мэргэжлийн болон онол, ерөнхий

мэдлэгийн шалгалт"- ыг 4 удаа авч, “Шинэ жил – Шинэ санаа” уран бүтээлийн уралдаан, “Метерном – 2009 “ зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.

Гадаад харилцааг хөгжүүлэх зорилгоор БНАСАУ-д болсон Олон улсын “Хаврын баяр” урлагийн наадам, БНХАУ-д болсон Олон улсын бүжгийн уралдаан, ОХУ-ын Горны- Алтай мужийн Барнаул хотод болсон Олон улсын фестивалдуудад чуулгын удирдлага болон уран бүтээлчид оролцож, Буриад улсын Дорнод Сибирийн Хөгжмийн академитай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Сумдын соёлын төвийг тус бүр 5 орон тоотой болгож, байрны засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлд 3 сая төгрөг зарцуулж, соёл урлагийн арга хэмжээг хөдөөгийн иргэдэд хүргэх боломжийг бүрдүүлж ажиллалаа

Аймгийн Нийтийн номын сангийн фондыг 5.1 сая төгрөгийн 492, Баянтал сумын соёлын төвийн номын сангийн фондыг 10230, Шивээговь сумын соёлын төвийн номын сангийн фондыг 5627 номоор тус тус баяжууллаа.

Аймгийн музейн фондыг иргэдийн гар дээр хадгалагдаж байсан 107, шинээр 29 үзмэр худалдан авч фондоо баяжуулснаар 641 үзмэрийн сантай болоод байна.

“Говьсүмбэр өв соёл-2009” үзэсгэлэнг зохион байгуулж иргэдийн гар дээрх 245 түүх, соёлын дурсгалт зүйлийг дэлгэн тавьж “Боржигин”-ы түүх, соёлыг сурталчиллаа.

“Өв соёл- байгаль орчин” сарын аян, “Ардын билэг авъяас”, “Уран бүсгүй” зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

“Боловсрол, соёлын иж бүрэн үйлчилгээг хөдөөгийн малчдад хүргэх нь” төслийн хүрээнд хөдөөгийн багуудын өдөрлөгөөр үзэсгэлэн гаргаж хөдөөгийн иргэдээс түүх, соёлын дурсгалт эд өлгийн зүйлийн судалгаа авсан. Соёлын өвийн төвийн хээрийн шинжилгээний багтай хамтран 150 орчим булш, хиргисүүр тоолж зургаар баримтжуулан, солбилцолыг тогтоон бүртгэлжүүллээ.

Төрийн бус байгууллага, Хүүхэд Залуучуудын хүрээнд:

2009 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэст төрийн бус байгууллага хоёр шинээр бүртгүүлж, албан ёсны бүртгэлтэй нийт 18 иргэний нийгмийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Мерси-Кор Олон Улсын байгууллагаас 8 сэдвээр сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 45 төрийн бус байгууллага, 30 гаруй төрийн байгууллагын 230 хүн хамрагдсан.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагатай аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга, засаг даргын Тамгын газрын дарга нар нийт 7 удаагийн уулзалт ярилцлага зохион байгууллаа. Уулзалтын үр дүнд бага оврын автобусны үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх, таксины үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалтанд оруулав.

Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагуудын түншлэлийн гурвалсан гэрээг байгуулав. Гэрээнд тусгагдсаны дагуу төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажлуудыг орон нутгийн бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх, сонгон шалгаруулалтанд болон төсөл боловсруулах, тендер шалгаруулах хороонд оролцуулах ажлыг эхлүүлээд байна.

Аймгийн хэмжээнд 921 ахмад бүртгэгдсэн нь өмнөх оноос 43 ахмадаар нэмэгдлээ. Говийн бүсийн ахмадын байгууллагын идэвхитэн сонгуультаны туршлага солилцох зөвлөгөөнийг зохион байгуулж 4 аймгийн 80 гаруй өндөр настанг оролцуулж аймгийн Засаг дарга нөөцөөсөө 1.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

“ Ахмадаа хүндэтгэж залуусаа хөгжүүлэе “ урлаг, спортын арга хэмжээ, Халх голын 70-н жилийн ойг тохиолдуулан Орос-Монголын ахмад дайчдын уулзалтыг зохион байгуулсан.

Дайнд оролцсон 41 ахмад дайчны нэрсийг тодруулж, дайчдын фото зураг бүхий ахмадын буланг аймгийн музейд байгуулсан.

Ахмад настны нийгмийн хамгааллын хуулийн хүрээнд цагаан сар, ахмадын өдөр бусад тэмдэглэлт өдрүүдээр нийт ахмадуудад хүндэтгэл үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 802 ахмад настныг хамруулж 27.3 сая төгрөгийг зарцуулсан.

Аймгийн Залуучуудын холбоо аймгийн “Шилдэг залуучууд “ шалгаруулах уламжлалт үйл ажиллагааг зохион байгуулж шилдэг залуучуудыг Бээжин хотод аялуулж байна.

Гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй хүүхдийн талаарх судалгааг гарган ИТХ-ын төлөөлөгчдөд даалган өгч гэмт хэргээс ангид байлгах арга хэмжээг авч ажилласан. 2009 онд хүүхдийн гэмт хэрэг 5 гарч урьд оноос 62.5 хувиар буурсан байна.

Дарамт, хүчирхийлэл, эцэг, эх нь үл хайхрах байдалд өртсөн 6 хүүхэд байгаагын 2 хүүхдийн ар гэрийнхэнтэй уулзаж халамжийн **24.0** мянган төгрөгийн тэтгэмжинд, 1 хүүхдийг 2-р ангид, 1 хүүхдийг Дэлхийн зөн ОУБ-ын төсөл болон албан бус сургалтанд хамруулсан.

Нэн ядуу 20 хүүхдийн судалгааг гарган Дэлхийн зөн ОУБ-ын төсөлд хүргүүлж хүүхэд бүрийг **100** долларын өртөг бүхий тусламжинд хамруулсан.

Аймгийн Утга зохиолын нэгдэл “Боржигдой мэргэн“, “Найргийн зөн “ яруу найргийн наадмыг зохион байгуулж тэргүүлсэн яруу найрагчдыг “ Уяхан замбуутив ", “ Ноён хутагт

Данзанравжаагийн мэлмий гийсэн 205 жилийн ой “ яруу найргийн наадам, “ Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө” зэрэг яруу найргийн наадмуудад оролцууллаа. Эдгээр арга хэмжээнд аймгийн Засаг дарга нөөц сангаасаа 500,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

2.3 Эрүүл мэндийн талаар.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг жигд сайжруулж нэр төрлийг нэмэгдүүлэх, иргэд, хамт олны идэвхитэй оролцоонд тулгуурлан хүн амыг эрүүл байлгах, орчин үеийн дэвшилтэт оношлогоо, эмчилгээний аргыг эрчимтэй нэвтрүүлэн эрүүлжүүлэх замаар дундажнаслалтыг уртасгах, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдвал зохих хүн амын 97 хувь нь хамрагдаж аймгийн төвийн хүн амын 98 хувь нь өрхийн эмнэлэгт харьяалагдан үйлчлүүлж байна.

Эх нялхсын эрүүл мэндэд онцгой анхааран “Мянганы хөгжлийн тунхаглал”-д нийцүүлэн нялхсын эндэгдэл, эхийн эндэгдлийг бууруулах стратеги төлөвлөгөөний дагуу жирэмсэний хяналтыг эрт тогтоох, жирэмслэлтэй холбоотой эмгэгийн оношлогоог сайжруулах бодлого барьж 2005-2010 онд эхийн эндэгдлийг бууруулах аймгийн стратеги төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. Төрөхийн хүндрэл, эхийн эндэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулсан Төрөхийн өмнөх байрны үйл ажиллагаа тогтмолжиж амаржвал зохих хөдөөгийн эхчүүдийг 100 хувь хамруулж байна.

Эдгээр бодлогын үр дүнд сүүлийн 3 жилд эхийн эндэгдэлгүй ажилласан нь тус аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын томоохон амжилтын нэг юм.

2009 онд аймгийн хэмжээнд 97482 иргэнд эмнэлэгийн үзлэгт хамруулсан байна.

361 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 57 эхээр нэмэгдсэн.

0-1 насны 8 хүүхэд эндсэн ба 1000 амьд төрөлтөнд 22.2 промилль процент болж өмнөх оныхоос 4.8 промилль процентоор буурсан боловч аймаг улсын дундажаас дээгүүр байна. 9 нэрийн 149 халдварт өвчин бүртгэгдэж 10000 хүн амд 105.4 ноогдож аймаг улсын дундажаас доогуур байгаа ба өмнөх оны мөн үеэс 173 тохиолдлоор буурсан байна.

0-5 насны хүүхдийн дархлаажуулалт 99 хувьд хүрсэний үр дүнд тарилгатай халдварт өвчин гараагүй байна. 2005 оноос Тавт вакциныг нэвтрүүлсэн ба тарилгын хүндрэл бүртгэгдээгүй.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага үүсгэн байгуулах санаачлагыг дэмжин ажилласанаар одоогийн байдлаар шүдний эмнэлэг 1, эмийн худалдаа 5, Уламжлалт эмчилгээний чиглэлээр 1 эмнэлэг ажиллаж байна.

Нэгдсэн эмнэлгийн стандарт 85 хувь, сумдын эмнэлгийн стандарт 90 хувь, өрхийн эмнэлгийн стандарт 85 хувийн хэрэгжилттэй байна.

Эрүүл мэндийн яамны 40 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлгийн мэс засал, төрөх тасаг, Шивээговь сумын эмнэлгийн дээврийн засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Эмнэлэг эмийн сангийн хооронд үүссэн өр авлага байхгүй.

Сум эмнэлгүүд их эмчээр бүрэн хангагдсан. Тогтвортой амьжиргаа төслийн Олон нийтийн санаачилгын сангаас Баянтал сумын эмнэлэгт 4 сая төгрөгийн өртөг бүхий Физик эмчилгээний багаж тоног төхөөрөмж, аймгийн нэгдсэн эмнэлгийн Нүдний тасагт 5.1 сая төгрөгийн өртөг бүхий нүдний өвчнийг оношлох багаж төхөөрөмжүүдийг авч суурилуулсан. Ингэснээр орон нутагт халдварт бус өвчний гаралтыг бууруулах, нүдний өвчний оношлогоо эмчилгээнд ахиц гарч байна.

Мөн Италийн төрийн бус байгууллага АЙФО, Европын холбоо хамтран санхүүжүүлэн хэрэгжүүлж буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-эд энгийн ортопедийн хэрэгслийг орон нутагтаа хийж өгч байх зорилгоор Эрүүл мэндийн газарт 4 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын тоног төхөөрөмж, Нийгмийн эрүүл мэндийн төв 2 сая гаруй төгрөгийн өртөг бүхий Ортопедийн цехийг тус тус байгуулсан. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-ийг нийгэм хамт олонд нь сэргээн засах Сэргээн засалч эмч 4, Сэргээн засалтын сувилагч 4-ийг тус тус бэлтгэсэн.

Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудын дунд “Эрүүл мэндийг дэмжигч хамт олон шалгаруулах болзол журам”-ыг боловсруулан дүгнэж хэвшээд байна. Байгууллагууд дээр нийгмийн эрүүл мэндийн сайн дурын ажилтнуудыг бэлтгэн өгч ажиллуулж байна.

Эрүүл мэндийн байгууллагууд Магадлан итгэмжлэлд бүрэн хамрагдаж хангалттай сайн үнэлгээ авсан.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийг тусад нь бие дааж үйл ажиллагаагаа эрхлэх бүрэн боломжоор хангасан ба яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдсэн. А хүрээний H1N1 Томуугийн вирусийн халдвараар урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааг сайн зохион байгуулж өвчилсөн тохиолдлыг дор бүр нь илрүүлэн эмчилсэнээр нас баралт гаргалгүй ажилласан.

Орон нутгийн уламжлал, онцлог, хүүхэд залуусын сонирхол бүрдсэн, материаллаг бааз, боловсон хүчний нөөц, ирээдүйн хөгжлийн чиг хандлага зэргийг харгалзан түлхүү хөгжүүлэх спортын төрлөөр бокс, волейбол, чөлөөт бөх, талбайн теннис, жүдо бөх зэрэг төрлүүдийг сонгон хөгжүүлэх бодлого барин ажиллаж байна. Эдгээр спортын төрлүүдийн багш дасгалжуулагчдын

мэдлэг мэргэшил, заах арга ур чадварыг дээшлүүлэх зорилгоор БТСУХороо, МҮОХ, спортын хороодоос зохион байгуулж буй сургалтанд хамруулсан..

Монгол Улсын Гавъяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит 2009 оны улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа 2009-09-09-13-ны хооронд зохион байгуулж явуулсан. Энэ тэмцээнд 44 багийн 408 тамирчин оролцлоо.

Бүс улсын чанартай 28 спортын 10 төрлөөр оролцож 45 медаль авсан ба спортын мастер 3, дэд мастер 12,1-р зэргийн тамирчин 24 шинээр төрсөн байна. Бали аралд болсон элсний волейболын Азийн тоглолтонд А.Намуун оролцож, боксын тамирчин Мөнхбаатар оюутны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль, Э.Эрдэнэхүү монгол туургатан хүүхдийн спортын наадмаас хүрэл медаль хүртэж Турк улсад зохиогдох шатрын тэмцээнд Э.Түвшинтөгс оролцлоо.

Хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулах зорилгоор “Халдварт бус өвчнийг бууруулах, хянах” хөтөлбөрийг аймгийн БТСХороотой хамтран хэрэгжүүлж байна.

МУЗГ-ын “Нийтийн биеийн тамир, спортын талаар авах арга хэмжээний тухай” 2009 оны 5-р тогтоолын дагуу Аймгийн засаг даргын А/57 тоот захирамжийг гарган аж ахуйн нэгж байгууллагууд сар болгон тодорхой сэдвийн дор нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион явуулж байна.

Аймгийн хэмжээнд “Биеийн тамир-Эрүүл мэнд” уриан дор зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө болон хариуцан ажиллах байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг АЗД-ын А/109 захирамжаар байгуулан ажиллуулсан. Үүний үр дүнд жил ирэх тусам хүн амын өвчлөл нас баралт буурах үзүүлэлттэй гарч жилийн хүн амын цэвэр өсөлт 2.3 хувь,дундаж наслалт 69 байна. Нийтийн биеийн тамирын талаар 38 арга хэмжээг 12 төрлөөр зохион явуулж давхардсан тоогоор 11500 хүн хамрагдлаа.12 байгууллагын 185 хүн спортын заал танхимыг гэрээгээр ашиглан байгууллага хамт олноороо хичээллэж байна.

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангуудад 2551.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 2698.7 сая төгрөгийг төвлөрүүлэн төлөвлөгөөг 105.8 хувиар биелүүлсэн үүнийг сан тус бүрээр харуулбал:

Нийгмийн даатгалын сангуудын нэр	орлого		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь

Тэтгэвэрийн даатгал	1623.5	1592.9	98.1
Тэтгэмжийн даатгал	116.2	136.1	117.1
Эрүүл мэндийн даатгал	521.7	617.7	118.4
ҮОМШӨ даатгал	174.5	187.5	107.4
Ажилгүйдлийн даатгал	115.4	164.6	142.6
Нийт дүн	2551.3	2698.7	105.8

Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 1568 хүнд 1908.0 сая төгрөгийн тэтгэвэр, 1263 хүнд 318.4 сая төгрөгийн тэтгэмж, эмнэлгийн тусламж үйлчилгээг 9367 хүнд 317.7 сая төгрөг, хөнгөлөлттэй эмийн үйлчилгээг 5982 хүнд 17.3 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмж 217 хүнд 147.1 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэмж 23 хүнд 1.7 сая төгрөг, шинээр өндөр насны тэтгэвэр 86 хүнд 11.1 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 19 хүнд 1.6 төгрөгийн санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олголоо.

УНДЕГ-ын төв санд 118.1 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 158.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн. / ЭМД-ийн санд 100.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 31.0 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалийн санд 27.0 сая төгрөг/

Аймгийн нийгмийн даатгалд хамрагсадын хүрээ өнгөрсөн оноос ажил олгогч 8, заавал даатгуулагч 81, сайн дурын даатгуулагч 82, багийн засаг дарга нартай гэрээ байгуулан ажилласаны үр дүнд эрүүл мэндийн даатгалд 264 малчин, ЭМД-ын төрөөс хариуцдаг даатгуулагчдын тоо 1297, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдээс даатгуулагчийн тоо 1648 хүнээр тус тус нэмэгдэж, 34.8 сая төгрөгийг төсөвт оруулсан.

УНДЕГ-аас ирүүсэн удирдамжийн дагуу ажилгүйдлийн тэтгэмж, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны тэтгэмжийн бодолт олголтыг шалгаж 389.9 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, акт тавин 264.6 мянган төгрөгийг барагдуулсан. Мөн ажил олгогч 8 байгууллагыг шалгаж 355.8 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлэн 100 хувь барагдуулсан.

Эрүүл мэндийн даатгалыг төрөөс хариуцдаг иргэдийн төсөвт өгөх өглөгийн хэмжээг бууулах арга хэмжээ авч ажилласнаар өглөг оны эхэнд 2909.3 мянган төгрөг байсныг 117.2 мянган төгрөг болж буурсан.

2009 онд Нийгмийн даатгалын хэлтэст бүртгэлтэй ажил олгогч байгууллагын тоог, аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн бүртгэлтэй тулган шаглаж өмчийн хэлбэрээр шинэчлэн бүртгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн халамж үйлчилгээ:

Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй бодлого явуулж нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгийг хамруулан үйлчилгээг шуурхай хүртээмжтэй болгон ажигүйдэл,ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд ХААН, ХАС, Монгол Шуудан банкаар дамжуулан ХЭДС-ийн зээл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зээл, жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зээл болон улсын төсөв, хувь хүний хөрөнгөөр 383 ажлын байр шинээр бий болсон ба үүний 293 нь байнгын ажлын байр байна. 143 ажлын шинээр байр бий болгоход 747.4 сая төгрөгийн зээл олгогдсон байна.

Тайлант хугацааны эхэнд 113 ажилгүйчүүд байснаас 1028 хүн шинээр бүртгэгдэж 52 хүн бусад шалтгаанаар хасагдаж 932 хүн сул чөлөөлөгдсөн ажлын байранд зуучлагдан хугацааны эцэст 157 ажилгүйчүүд буюу ажилгүйдлийн түвшин 3.5 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 хувиар өссөн нь хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо өссөн, хүн амын хөдөлмөр эрхлэх сонирхол нэмэгдэж Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажигүйчүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Аймгийн МСҮТ, БСГ, Улаач чандмань, Футур сургалтын төвтэй гэрээ 168 хүнийг мэргэжил олгох сургалтанд хамруулан Эксковаторчин, гагнуурчин, автозасварчин, үсчин, тогооч, шатахуун түгээгч зэрэг мэргэжил олголоо. Энэхүү үйлчилгээнд 17.8 сая төгрөг зарцуулсан байна. Аж ахуй эрхлэх сургалтыг Улаанбаатар хотын “Мэдлэг”, “Оргилуун”, “Футур” сургалтын төвтэйгэрээ хийж орон нутагт зохион байгуулсан тус сургалтанд 82 хүн хамруулан сургалтын ба хоол унааны зардалд нийт 5.1 сая төгрөг зарцуулсан. Албан бус сектор,малчдад зориулсан бизнесээ эхэл,хөгжүүл төслийн шатчилсан сургалтанд 51 хүн хамруулан 4.2 сая төгрөг зарцуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй 58 иргэнд 8.1 сая төгрөгийн түлээ нүүрсний үнэ, 133 иргэнд протез, ортопед, тэргэнцэр худалдаж авах үнэ 10.9 сая төгрөг, 802 өндөр настанд 47.4 сая төгрөгийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлсэн.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх үйлчилгээнд 73 өрхийг хамруулан амьжиргаанд нь дэмжлэг үзүүлж 23 өрхөд 2.5 сая төгрөгийн тусламж олгон “Хоол цай хийж зарах”, “Дугуй нөхөх”, “Гар утас засварлах”, “Шүрэн эдлэл хийх”, “Гахай үржүүлэх”, “Оёдол хийх”, “Ногоо тарих” зэрэг өрхийн аж ахуй эрхлүүлж байна. Мөн 59 өрхийн гишүүдийг нийтийг хамарсан ажилд хамруулан түр ажлын байраар хангаж 15 өрхийн гишүүдийг ажлын байранд зуучилж байнгын ажлын байртай болгосон ба 40 өрхийн гишүүдийг сургалтанд хамруулан мэргэжил олгож, 8 өрхийг банкны жижиг зээлд хамруулж, 33 өрхийн гишүүдийг асаргааны сургалтанд хамруулах зэрэг ажлуудыг зохион байгуулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон нийгмийн халамжийн үйлчилгээнүүдийг үзүүлсэн байна

Нэн ядуу болон ядуу өрхийг ядуурлаас гаргах, бага орлоготой өрхийг ядууралд орохоос урьдчилан сэргийлэхэд “Тогтвортой амьжиргаа II” төсөл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

“Тогтвортой амьжиргаа II” төслийн “Олон нийтийн санаачилга сан бүрэлдэхүүн хэсэг”-ийн хүрээнд 16 төслийг 69.4 сая төгрөг, Бэлчээрийн мал аж ахуй эрсдлийн удирдлага бүрэлдэхүүн хэсэг”-ийн хүрээнд малчдын сайн дурын 23 бүлэгт 67.1 сая төгрөг, Сүмбэр суманд өвс тэжээлийн 3 агуулахын барилгыг засварлах төсөлд 23.2 сая төгрөг, нийт 90.3 сая төгрөгийн санхүүжилт хийж төслүүд хэрэгжих шатандаа байна. Хэрэгжиж байгаа төслүүдийн нийт хөрөнгө оруулалтын 5-17.6 хувийг иргэд, олон нийтийн хандиваар 5-12 хувийг орон нутгийн байгууллага төсвөөс, 85-90 хувийг “Тогтвортой амьжиргаа II” төслөөс санхүүжүүлж байна.

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

Төсөвт тавих хяналтыг сайжруулж, зүй бусаар зардал хэтрүүлэхгүй байх.

Татварын бааз суурийг өргөтгөж, Санхүүгийн ажилтнуудийн ёс зүй хариуцлага, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын сахилгыг сайжруулж, урсгал зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэн, эдгээрт тавих хяналтыг чангатгах зорилт тавиад ажиллаж байна.

2009 онд татвар төлөгчийн тоо 535-аар нэмэгдсэн.

Өмнөх онд “Аж ахуй нэгжийн орлогын албан татвар”-ын тайлан ирүүлэгч аж ахуйн нэгжүүдийн 29.3 хувь “х”, 30.5 хувь нь алдагдалтай тайлан ирүүлж байсан бол 2009 онд татвар төлөгчийн ажлын байранд ажлын зураг авалт хийж татварын нэг өдрийн дундаж орлого, зардлыг тодорхойлон гаргаж, харилцах дансны хуулгыг харилцагч банкнаас гаргуулан авах зэрэг арга хэмжээ авч ажилласнаар “х” тайлан гаргалтыг 12 хувиар, алдагдалтай тайлан гаргалтыг 12.5 хувиар тус тус бууруулж татварын бааз суурийг өргөтгөлөө.

Засаг даргын нэрэмжит зөвлөн туслах шалгалтыг төвлөрсөн төсвийн 18 байгууллагад хийж 2,8 сая төгрөгийн акт тавьж, ажлын хариуцлага алдсан нягтлан бодогч, эд хариуцагч 3 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд тавьж шийдүүлсэн.

Төсөвт байгууллагуудын урт болон дунд хугацааны мастер төлөвлөгөө, бусад бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлж ажилласнаар урсгал зардал өмнөх оноос 3.7 хувиар буурч аймаг орон нутгийн төсвийн нийт зарлагын 92.3 хувийг өөрөө санхүүжүүлж, 7.7 хувийг улсын төсвөөс санхүүжүүллээ.

Улсын болон орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг 2505.0 сая төгрөг буюу 115 хувиар давуулан биелүүллээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 195.7 сая төгрөгөөр 15 нэр бүхий ажлыг хийж , ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллалаа.

Манай аймагт арилжааны 5 банк /ХААН, Хас, Монгол шуудан, Хадгаламж, Кредит/ үйл ажиллагаа явуулж байна.

“ХААН” банк орон нутагт 4 салбараар үйл ажиллагаагаа явуулж, сүүлийн үеийн дэвшилтэт үйлчилгээг нэвтрүүлэн 11 төрлийн бүтээгдэхүүнээр иргэд, аж ахуй нэгжид үйлчилж, зээлийн хүүг бууруулан ажиллаж байна. Энэ онд 3 аж ахуй нэгжид 133.8 сая төгрөг, 2474 иргэнд 3318.3 сая төгрөг, 175 малчинд 228.5 сая төгрөгийн зээл олгож зээлийн эргэн төлөлт 82 хувьтай байна.

Банкны шинэ байр ашиглалтанд оруулж, төмөр замын вокзалд 24 цагийн АТМ ажиллуулж байна

“Хас” банк нь орон нутагт 2 салбараар үйл ажиллагаагаа явуулж 14 төрлийн бүтээгдэхүүнээр иргэд, аж ахуй нэгжид үйлчилж, 13 аж ахуй нэгжид 190.2 сая төгрөг, 1488 иргэнд 2739.7 сая төгрөг, 19 малчинд 23.3 сая төгрөгийн зээл олгож, зээлийн эргэн төлөлт 98.3 хувьтай байна.

“Монгол шуудан” 4 салбараар 11 төрлийн бүтээгдэхүүний үйлчилгээ үзүүлж, 2438 иргэнд 2576.6 сая төгрөг, 70 малчинд 143.7 сая төгрөгийн зээл олгож, зээлийн эргэн төлөлт 78.0 хувьтай байна.

Кредит банк 3 төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлж 18 иргэнд 31.0 сая төгрөгийн зээл олгож, зээлийн эргэн төлөлт 57.1 хувьтай.

Хадгаламж банк нь 8 төрлийн бүтээгдэхүүнээр иргэд, аж ахуй нэгжид үйлчилж, 125 иргэнд 425.5 сая төгрөгийн зээл олгож, зээлийн эргэн төлөлт 42.5 хувьтай байна.

“Монгол даатгал”-ын орон нутаг дахь салбар 8 төрлийн даатгалын үйлчилгээг 1042 даатгуулагчид үзүүлж, 59 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 293 даатгуулагчид 21.1 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон.

Орон нутагт **гүнийн гаалийн салбар** байгуулагдсанаар 21 аж ахуй нэгж “Хайлуур жонш”, “Нүүрс”-ийг экспортолж, 2 аж ахуй нэгж нефьт импортолж, 18.4 сая ам долларын бараа эргэлт хийж, улсын төсөвт 3.7 тэрбум төгрөгийн татвар, 42.5 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлсэн.

4. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

Жижиг дунд үйлдвэрлэл

Аймгийн ИТХ-ын 20 дугаар тогтоолоор “Жижиг дунд үйлдвэр” дэд хөтөлбөр батлуулж, 45 дугаар тогтоолоор ЖДҮ-ийн сангийн зээл олгох дэд комисс, хяналтын зөвлөл байгуулан 782.5 сая төгрөгийн зээл олгох ажлыг зохион байгууллаа.

ЖДҮ эрхлэгчдэд “Үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн” хийж, төсөл бичих хөдөлгөөн өрнүүлж 142 төсөлд арга зүйн зөвлөгөө өгч 64 төсөлд 727.6 сая төгрөгийн зээл олгосноос ХХАА-н салбарт 20, ахуйн үйлчилгээний салбарт 12, хөнгөн үйлдвэр барилгын салбарт 10, худалдаа үйлчилгээний чиглэлд 19 төсөл хэрэгжиж байна.

ЖДҮ-ийн сангийн зээл олгосноор 20 гаруй үйлдвэр, цех, үйлчилгээний газрын үйл ажиллагаа шинээр эхэлж, 30 гаруй иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа сэргээж өргөтгөсний үр дүнд 100 гаруй ажлын байр буй боллоо.

Ажлын байрны эрэлт хэрэгцээний шаардлагаар Мэргэжил сургалт үйлдвэрийн төвд 500 гаруй оюутан суралцуулж, Халамж үйлчилгээний байгууллагын хөрөнгөөр 170 хүнд шинээр мэргэжил олгох болон ур чадварын сургалт хийлээ.

Орон нутгийн өмчит “Ус-Ду” компани болон “BNZ” фото студи гаалийн татварын хөнгөлөлт эдэлж хими цэвэрлэгээний болон өндөр хүчин чадалтай фото студийн тоног төхөөрөмж гадаадаас авч үйл ажиллагаа явуулж эхэллээ.

ЖДҮ-ийн сангийн зээлдэгчид “Нэг суурин–нэг бүтээгдэхүүн”, “Ногоон хувьсгал II”, “Малын чанар” хөтөлбөрийн хүрээнд аймагт зохион байгуулагдсан “Шилдэг мал, шилдэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаанд оролцож иргэн Баянмөнхийн байгуулсан “Эсгийний жижиг үйлдвэр”-ийн бүтээгдэхүүн, “Сүмбэр зоо” ХХК-ний хуц ухна, “Говьзүмбэр” ХХК-ний “Гэрийн модон эдлэл” тэргүүн байр эзэллээ.

Аймгийн брендээр “Сүмбэр” хонь, Шивээ-овоогийн хүрэн нүүрс бүртгэгдэж улс, бүсийн чанартай үзэсгэлэн худалдаанд “Сүмбэр” хониор оролцож тусгай шагнал хүртэж оролцлоо.

Малын арьс, шир, ноос ноолуур авч зах зээлд борлуулдаг цэгүүдийг ЖДҮ-ийг дэмжих сангийн зээлд хамруулж тэр чиглэлийн үйлдвэрлэл эрхлэх зарим нөхцлийг бүрдүүлж байна.

Энэ чиглэлийн жижиг дунд үйлдвэр байгуулах зорилгоор ЖДҮ-ийн сангаас 3 иргэн, аж ахуйн нэгжид 18.9 сая төг-н зээл олгож үйл ажиллагаа нь эхэлсний зэрэгцээ Баянтал суманд УИХ-ын гишүүний хөрөнгө оруулалтаар ноос угаах үйлдвэрийн барилга баригдаж байна

Барилгын материал үйлдвэрлэх 4 аж ахуй нэгжид зээл олгон дэмжиж ажилласнаар жилдээ 12000 м² замын хавтан, 24000 үнсэн блок үйлдвэрлэх хүчин чадал бүхий үнсэн блокны үйлдвэр, вакум цонхны үйлдвэрүүд байгуулагдан үйл ажиллагаа явуулж, аймгийн иргэдийнхээ хэрэгцээг хангаад зогсохгүй аймагт хийгдэж байгаа зарим хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэж байна.

Хөдөө аж ахуй

2009 онд аймгийн хэмжээнд 168.723 мал тоологдсон нь өмнөх оноос 1.2 хувиар буурч, 56.380 төл бойжуулж өмнөх оноос 0.3 хувиар өссөн байна.

Мал амьтны 23 нэрийн халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтанд 118.2 мян мал хамрагдаж дархлаажуулснаар шинээр мал амьтны өвчлөл гараагүй тайван байна.

Гоц халдварт цэцэг өвчний вакциныг бүх хонинд /69 мян тун/, адууны томуугийн вакциныг 3000 адуунд хийж дархлаажуулснаар өвчлөл гараагүй болно.

“Малын эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд вакцины тарилганд бүх мал нэг удаа, паразиттах өвчнөөс хамгаалах арга хэмжээнд 197.6 мал буюу 1.1 дахин хамрагдаж хонины цэцэг, адууны томуу зэрэг гоц болон ужиг халдварт өвчнөөс хамгаалж дархлаажуулах ажлыг зохион байгуулсаны гадна

малаас хүнд халдварладаг ямын шинжилгээнд нийт адууны 30 хувийг, үхрийн сүрьеэгийн шинжилгээнд нийт үхрийн 60 хувийг, бруцеллёз өвчний шинжилгээнд буур, хуц, ухна, эм хонь, ямааны 03 хувийг хамруулж өрх суурийн түвшинд эрүүлжүүлж эхэллээ. Одоо аймгийн хэмжээнд малын бруцеллёзын халдварлал 01-04 хувьтай байгаагийн зэрэгцээ сүлийн 2 жил дараалан ям, сүрьеэ өвчин илрээгүй бөгөөд өмнөх 3 жилийн дунджаас өсөөгүй байна. Мал эмнэлгийн ажил үйлчилгээний хөлсөнд улсын төсвөөс 4.7 сая төгрөг орон нутгийн төсвөөс 10.2 сая төгрөгийг олголоо.

Аймгийн хэмжээнд 8 малын эмч ажиллахын зэрэгцээ бүх суманд мал эмнэлгийн нэгж 1-4, түүнд 6 малын их, бага эмч ажиллаж төрийн үйлчилгээ үзүүлж мал эмнэлгийн нэгжийн стандартыг хангаж байна.

“Малын чанар сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд хонийг “Баянцагаан”, “Үзэмчин”, “Барга”,

ямааг “Баяндэлгэр” үүлдэр омгоор сайжруулах ажил үргэлжилж хонины ноосны дундаж гарц, амьдын жин олон жилийн дундажаас нэмэгдэж, ямааны ноолуурын дундаж гарц 320 граммд хүрч малчдын орлогын гол эх үүсвэр болж байна.

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд каракулын “Сүмбэр” үүлдрийн хонийг цэвэрээр нь үржүүлдэг орон нутгийн өмчит “Цөм сүргийн үржлийн төв” ажиллаж зохиомол хээлтүүлэг хийж эхэлсний зэрэгцээ түүний тоо толгойг өсгөх зорилгоор 479 толгой нутгийн монгол хонийг “Сүмбэр” үүлдэрээр эрлийзжүүлэх ажил эхэлсэн. Мөн шинээр хоёр Мал үржлийн нэгж байгуулагдан зөвхөн баталгаажсан хээлтүүлэгчийг үржилд ашиглах, хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо бүрдүүлэх, хээлтүүлэгч бойжуулах, ашиг шимийн хэмжилт хийх ажил нэгэнт эхэлж ажил үйлчилгээний хөлсөө улсын төсвөөс авлаа.

“Ногоон хувьсгал”, “Атрын III аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр, аймгийн “Газар тариаланг сэргээн хөгжүүлэх 2008-2012 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаа.

Газар тариалангийн техникийн шинэчлэлд зориулж Сүмбэр сумын “Сүмбэр-Айраг” хоршооны техник тоног төхөөрмж, ажиллах хүчний чадавхид түшиглэн техникийн засвар, үйлчилгээ хийх цэг шинээр байгуулж 3.5 га талбайд боловсруулалт хийсэн.

18.8 га-д төмс, 6 га-д хүнсний ногоо тариалсан нь өмнөх оныхоос 29 хувиар нэмэгдэж төмс 104.2 тонн, хүнсний ногоо 24.4 тонныг хураан авч хүн амын төмс хүнсний ногооны хэрэгцээний 21 хувийг хангаж байна. Га-ын дундаж ургац 51.8 цн байв. Сүмбэр суманд 5 га талбайд энэ намар уринш хийлээ.

Сумдад бага оврын трактор, 30 тонны хүнсний ногооны зоорь, стандартын хүлэмж бүхий иж бүрэн агропарк байгуулж 17.8 га талбайд боловсруулалт хийсэн.

“Зоорь” уралдааны болзлыг дэмжиж бүх суманд уг ажил өрнөсний дотор Сүмбэр суманд “Сүмбэр-айраг” хоршоо 200 тн-ны хүнсний ногооны зоорь, шинээр байгуулсан, Сүмбэр сумын “Төв агропарк”-ийн 50 тн-ны зоорь засварлаж дууссаны гадна 2-10 тн-ийн жижиг зоорь барьж байгуулсан өрх 10 гаруй байна.

Аймгийн хэмжээгээр 40.4 га-д усалгаатай тариалан эрхлэж үүнээс төмс 10 га-д, хүнсний ногоо 4 га-д тариалж 104.2 тн төмс, хүнсний ногоо 24.4 тн, тэжээлийн ургамал 15 га-д, тариалж 64.3 тн ургац хурааж 20 га-г өнжөөллөө.

Энэ оны тариалалтаар газар тариаланд 37 ажлын байр бий болж өмнөх оныхоос 12-оор нэмэгдлээ.

Шивээ-овоогийн нүүрсний уурхайн шавхалтын усыг түшиглэн 30 га хүртэл талбайд тариалан эрхлэх хайгуулын ажил, услалтын систем байгуулах боломжийг салбырын яамтай хамтран судалж эхэлсэн.

Тус аймагт буй “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын салбар Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран Сүмбэр, Шивээговь сумын нутагт байнгын ажиллгатай сургалтын талбай 2-ыг буй болгож орон нутагт тохиромжтой жимс, жимсгэнийн үр суулгац бэлтгэн иргэдэд нийлүүлж ажилласны гадна газар тариалан эрхлэх сонирхолтой 30 иргэнд арга зүйн зөвлөгөө өгч 200 суулгац тарааж тухайн талбайнууд дээр залуусыг ойн нөхөн сэргээлтийн мэргэжилд сургах ажлыг зохион байгууллаа.

“Тогтвортой амжиргаал” төслийн хүрээнд бүх суманд шинээр 24 малчны бүлэг байгуулагдан 41 га бэлчээр хашиж хамгаалан, 5 гар худаг 7 сая төгрөгийн хөрөнгөөр засварлаж, ус тогтоох 1 хөв байгуулж, 30 тонны 2, 50 тонны 1 тэжээлийн агуулахыг засварлах ажил эхэлсэн.

Аймгийн хэмжээгээр 782 тн хадлан, 210 тн гар тэжээл бэлтгэж 8-10 хоногийн нөөц бүрдүүлж өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг зохион байгууллаа.

Мал сүргийн тогтвортой өсөлтийн үрээр хүн амын махны хэрэгцээг бүрэн, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг улсын дундажийн хэмжээнд, төмс, хүнсний ногооны 21%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна.

Цаг агаарын хүндрэл, бэлчээрийн малын онцлогоос шалтгаалан нийт төллөх эх малын 60 хувь нь зун намрын 6 сарын хугацаанд саалинд хамрагдаж аймаг, сумын төвийн хүн амын хэрэгцээнд хоногт дунджаар 500 л сүү худалдаалж хоногт 1 хүнд 30 гр сүү оногдож байгаагийн зэрэгцээ хурууд, цагаан тос зэрэг цагаан идээний худалдаа тогтмол ажиллаж байна.

Мерси кор төслийн байгууллага сүүн бүтээгдэхүүн боловсруулах аргыг малчны бүлгүүдэд зааж сургаснаар олон нэр төрлийн амт чанар сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх зарим нөхцөл бүрдэж жилд 1-2 удаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж иргэдэд үйлчилж байна.

"Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" хөтөлбөрийн хүрээнд талх боов, хүнсий ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж бүх сум багийн малчны бүлэг хоршоо, нөхөрлөл зэрэг аж ахуйн нэгж, иргэд үзэсгэлэн худалдаанд бүтээгдэхүүнээрээ оролцож борлуулалт хийж 8 нэрээр шалгаруулж Ж.Баточирын "Эзэгий", М.Хишигтогтохын "Сүүн бүтээгдэхүүн", "Сүмбэр айраг" хоршооны "Төмс", "Эмээлийн хишиг хонд" ЗБ Нөхөрлөлийн "Хүнсний ногоо", СТ Бейкри ХХК-ийн "Талх нарийн боов" шилдэг бүтээгдэхүүнээр тус тус шалгарлаа.

Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд хийх лабораторийн шинжилгээний чанар үр дүнг сайжруулж ям, сүрьеэ, бруцеллээ өвчний шинжилгээг аймагт хийж өвчтэй сэжигтэй гарсан ийлдсийг Улсын мал эмнэлг, ариун цэврийн төв лабораторид хүргүүлж баталгаажууллаа.

Аймгийн төвийн хүнсний захад худалдаалж буй бүтээгдэхүүний шинжилгээ хариуцсан Мал эмнэлгийн нэгж ажиллаж МХГ болон мал эмнэлгийн албаны лабораториудтай хамтран эрүүл, аюулгүй байдалд зохих журмын дагуу шинжилгээ хийж тогтмолжлоо. Ингэснээр энэ жил 182.2 тн махны 2143 дээжид, 10.6 тн сүүний 252 дээжид, 3832 арьс, ширний 109 дээжид, 88.7 тн ноос ноолуурын 433 дээжид шинжилгээ хийж баталгаажуулж ажиллаа.


6.ДЭД БҮТЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын болон Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2009 оны үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн 2009 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 156,6 сая төгрөг, орон нутгийн төсөвт өртөгөөр 277,2 сая төгрөг, хувь хүмүүс аж ахуй нэгжийн хөрөнгө оруулалтаар 1.0 тэрбум буюу нийт 1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна.

2009 онд аймгийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж Баянтал суманд 30 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, инженерийн шугам сүлжээнд холбон, сургууль, цэцэрлэг,

цагдаагийн ажилчдыг орууллаа. Мөн Шивээговь суманд 30 айлын орон сууцыг Тамгын газрын ажилчдад зориулан засварлуулж байна.

2004-2009 онд аймгийн хэмжээнд ашиглалтанд орсон орон сууц



Хот орчноо тохижуулах зорилгоор Хонхорт хүүхдийн тоглоомын талбай, аймгийн төв талбайн өргөтгөл, явган хүний зам, гэрэлтүүлгийн ажлуудыг хийлээ.

Хот суурин газрын хөгжлийн өрөнхий төлөвлөлт, тохижилт, инженерийн шугам сүлжээг иж бүрнээр нь шийдвэрлэх чиглэлийг баримтлан Баянтал суманд цэвэр усны худаг, цэвэр усны шугам, уурын зуухны өргөтгөл, цахилгааны эх үүсвэр, гадна дулаан, цэвэр усны шугамын ажлыг хийж ашиглалтад орууллаа. Мөн халуун усны барилга болон “Ноос угаах үйлдвэр” баригдаж байна.

ХААН банкны байрыг сүүлийн үеийн зураг төсвөөр, иж бүрэн тохижилттой хийгдэж ашиглалтад оров.

Аймгийн хэмжээний барилга байгууламжуудыг хувийн хэрэгтэй болгох ажлыг зохион байгуулж эхлүүлсэн ба эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын барилгын даац бат бэх, насжилт, газар хөдлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээг 24 барилгад хийлгэсэн. Аймгийн нутаг дэвсгэрт барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, иргэдээс сар бүр барилга угсралтын ажил, их засвар, материал үйлдвэрлэлийн мэдээг авч судалгаа дүгнэлт хийж байна..

Дулаан, цэвэр ус

“Ус-Ду” ОНӨҮГ нь одоогоор Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төвд хэрэглэгчдэд 24 цагийн турш халаалт, хэрэглээний халуун ус, усан хангамж, бохир ус татан зайлуулах үйлчилгээг 42 албан газар, 716 айл өрхөд 20877,6 Г/кал дулаан үйлдвэрлэн түгээж, 134492.9 мян.м³ цэвэр ус олборлон хангаж, 3261.4 мян.м³ бохир усыг татан зайлуулж, давхардсан тоогоор 700 гаруй айл өрхөд дуудлага засвар үйлчилгээ хийсэн.

Мөн 500м³-ын багтаамжтай 2 бетонон усан сан, төмөргүйжүүлэх төхөөрөмж нь хэвийн ажиллаж байна.

Хэрэглэгчдийг халуун, хүйтэн усны тоолууржуулах ажлын хүрээнд 716 айл өрхийн 462 айл өрх нь хүйтэн усны тоолуур, 303 айл өрх нь халуун усны тоолууртай болсон нь дунджаар нийт айл өрхийн 53.4 хувь нь тоолууржсан. Ингэж тоолууржуулах үйл ажиллагааг идэвхтэй хийснээр усны зарцуулалт бодитоор гарч, усыг үргүй зарцуулах явдал багассан. Нийт борлуулалт 512236.5 сая.төгрөг, нийт зардал 1273345.1 сая.төгрөг, татвар төлөхийн өмнөх ашиг нь 111.9 сая.төгрөг, алдагдал 761096,8 сая.төгрөг байна.

“Илчлэг-Шивээ”ОНӨҮГазар нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын төвд 12 албан газар, аж ахуй нэгж, 150 гаруй айл өрх, 300 айлын орон сууцанд 102197.04м³ дулаан үйлдвэрлэн түгээж, 24048мян.м³ цэвэр ус олборлон хангаж, 19224м³ бохир усыг татан зайлуулж, давхардсан тоогоор 155 гаруй айл өрхөд дуудлага засвар үйлчилгээ хийсэн.

2009 оны жилийн эцсийн балансаар 144.4 сая төгрөгийн борлуулалт хийж 249.4 сая төгрөгийн зардал гарган 105 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэхүү алдагдал нь үндсэн хөрөнгийн дахин байгуулсан элэгдлээс шалтгаалан их хэмжээгээр нэмэгдсэн байна. Байгууллага иргэдээс авах авлага 8.3 сая төгрөг, өглөг 5.9 сая төгрөг тус тус байсан бол жилийн эцсийн балансаар авлага 5.1 сая, өглөг 4.6 сая төгрөг болж буурлаа.

“Талын илч” ОНӨҮГ нь 2008 онд байгуулагдаж орон нутгийн хөрөнгөөр цэвэр усны гүний худаг, халаалтын зуухны цахилгааны эх үүсвэр цахилгаан дамжуулах агаарын шугам, 1.3 км цэвэр усны шугам, гадна дулааны шугам, гадна бохирын шугам зэрэг ИШС иж бүрнээр хийснээр бүх ААН, байгууллагуудад үйлчилж эхлээд байна.

Нийт борлуулалт 85391.2 мянган төгрөг, нийт зардал 82000.0 мянган төгрөг, алдагдал 391.2 мянган төгрөг байна

“Тохижилт сүмбэр ” ОНӨААТҮГ нь 2009-2010 онд ус түгээх байруудаар **5.263.1** тн ус борлуулж **13.157.7** мянган төгрөгийн, Хонхор хотхоны хоёр СӨХ, 21 албан газар, **600** гаруй айл өрхийн хашааны **7726,3 куб/ м** хог хаягдлыг тээвэрлэн зөөж зайлуулж 2952,5 мянган төгрөгийн орлого тус тус олжээ.

Цахилгаан

“БЗӨБ-ЦТС” ТӨХК-ний Чойр салбар Говьсүмбэр аймаг, Дундговь аймгийн 3 сум, Дорноговь аймгийн 7 сум, Хэнтий аймгийн 3 сумыг цахилгаан эрчим хүчээр хангаж, ЦЭХ-ний борлуулалтын үйл ажиллагааг аж ахуйн гэрээний үндсэн дээр явуулж, дэд станцуудын тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үзлэг үйлчилгээ, байнгын бэлэн байдлыг ханган нийт 85 төсөвт газар, 264 ААН, 5668 айл өрхтэй аж ахуйн гэрээ цахилгаан эрчим хүчний борлуулалт хийж ажиллалаа. 2009 онд нийт 89262.9 мян.квт цаг цахилгаан эрчим хүчнийг хүлээн авч, 84399.1 мян.квт цаг цахилгаан эрчим хүчнийг борлуулж,

5079674.3 мянган төгрөгийн зардал гаргаж, 5688467.3 мянган төгрөгийн орлого олж салбарын хэмжээнд нийт 608793.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Уул уурхай

Шивээ–Овоо ХК нь тус аймгийн Шивээговь сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулж байна. Одоо ашиглаж байгаа хэсгийн нийт нөөц нь 646.5 сая.тн бөгөөд жилдээ дунджаар 2 сая тн нүүрс олборлох хүчин чадалтай уурхай юм.

Нийт 350 гаруй ажиллагсадтай бөгөөд 30% нь дээд, тусгай, дунд боловсролтой мэргэжлийн ажиллагсад байна.

2009 онд 1.719.1 мянган м³ хөрс хуулалт хийж, 1418.2 мянган тонн нүүрс борлуулж, 16167.8 сая төгрөгийн орлоготой, 15121.1 сая төгрөгийн зардал гаргаж, 1081.0 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Энэ онд тус компани өмнөх оноос нүүрс гаргалт 47.4 мянган тонн, борлуулалт 58.2 мянган тонноор буурсан нь зах зээлийн эрэлтээс хамааралтай юм.

Улсын төсөвт 1048.5 сая төгрөг, орон нутгийн төсвийн орлогод 250.8 сая төгрөгийн татвар төлж, орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын 97.0 хувийг бүрдүүлж ажиллалаа.

Энэ онд хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд зориулан 2.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

2009 оны байгаль цаг агаарын хүндрэлтэй үед тус компанийнхан аймгийн малчид, ард иргэддээ 190.0 тн нүүрс хандивласан.

Говьгео ХХК нь 2009 онд геологи, хайгуулын салбартаа 9357 га газарт эрэл зураглал, болон уул өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгэн, 1945.7 сая төгрөгийн зарлага гаргаж, 1603.4 сая төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд Улсын төсөвт 281.4 сая төгрөг төвлөрүүлж, аймагт 72.9 сая төгрөгийн татвар төлж ажиллажээ.

Тус аймгийн Шивээговь суманд томоохон үйлдвэрлэл үйлчилгээний төв байгуулж, 20 гаруй ажлын байр шинээр бий болгон, Геологи хайгуулын ажилдаа Зиф 1200, Зиф 650, L 38, Longer 1600, өрмийн машин, Daewoo 220, Daewoo 175, T-170, Ренгру-140 зэрэг хүнд машин механизм болон тоног төхөөмжтэйгээр үйл ажиллагаа явуулж, 50-80 хүний хээрийн төлөвлөлт суурийн анги, засварын цех хоолны газартай бөгөөд өрөмдлөгийн ажилд шаардлагатай зарим материалыг өөрийн механик цехэд үйлдвэрлэн ажиллаж байна.

Тус компанийнхан цас зудын хүндрэлтэй үед Шивээговьчууддаа 5.0 сая төгрөгийн эд бараа, хүнсний тусламж үзүүлдээ.

Холбоо харилцаа

Аймгийн хэмжээнд нийт 4 үүрэн холбооны оператор, МЦХ ХК-ий салбар, Төмөр замын дохиолол холбооны 4 дүгээр ангийн салбар зэрэг байгууллагууд үйл ажиллагаа явуулж, харилцаа холбооны үйлчилгээг үзүүлж байна.

МЦХ ХК-ны тус аймаг дахь салбар нь 2009 онд 137364,4 мянган төгрөгийн орлоготой, 48339,1 мянган төгрөгийн ашигтай ажилласан. Аймгийн төвдөө 2 салбартай, Шивээговь суманд 1 холбооны салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. Телефоны 459 цэгтэй, КаТВ-ийн 1188 хэрэглэгчтэй, ADSL-ийн интернетийн 70 хэрэглэгчтэй байна. КаТВ-ийн гаралтын чанарт анхаарал тавьж нэмэлт хүлээн авагчууд суурилуулан хэрэглэгчдэд Монголын 10 суваг, нийт 24 сувгаар тасралтгүй ханган ажиллаж байна. КаТВ-ийн 1 сувгаар орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын зарыг хүлээн авч нэвтрүүлснээр орон нутагт зар мэдээг нийтэд мэдээлэх ажилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Төмөр замын дохиолол холбооны 4 дүгээр ангийн салбар нь 2009 онд нийт 117.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж, хэрэглэгчиддээ КаТВ, интернет, телефоны үйлчилгээ үзүүлж байна. Телефон утасны 334 цэгтэй, КаТВ-ийн 83 хэрэглэгчтэй, ADSL-ийн интернетийн 42 хэрэглэгчтэй болж, Төмөр замын байгууллага төдийгүй аймгийн төвийн хэмжээнд интернет холболт, засвар угсралтын ажил үйлчилгээ үзүүлж ажиллаж байна.

Үүрэн холбооны 4 оператор үйл ажиллагаагаа явуулж, аймгийн хэмжээнд нийт 12704 хэрэглэгчтэй болоод байгаа нь нийт хүн амын 90 гаруй хувь нь юм. Энэ нь тус аймагт харилцаа холбоо, мэдээллийн технологийг хөгжүүлэх эхлэлийг тавьж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Мобиком корпорацийн салбар нь урьдчилсан төлбөрт үйлчилгээндээ /Be, Мобикарт/ 9422 хэрэглэгчдэд, дараа төлбөрт /үндсэн хэрэглэгч, Zone/ 573 хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж байна. Урьдчилсан төлбөрт картыг дараа төлбөрт үйлчилгээнд шилжүүлэх Мобимикс үйлчилгээг нэвтрүүлж, 2009 онд 693.8 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Мөн байгаль цаг агаар, цас зундын хүндрэлтэй үед малчдад туслах мессеж аяныг өрнүүлж, гар утаснаасаа мессеж бичин хандив өргөх үйлчилгээг үзүүлжээ.

Жи-Мобайл корпорацийн тус аймаг дахь салбар нь 2009 онд урьдчилсан төлбөрт 1943, дараа төлбөрт 335 хэрэглэгчтэй болж 360.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж, урьдчилсан төлбөрт үйлчилгээний Жи-10, Жи-20 үйлчилгээний 1 жилийн эрхтэй дугааруудыг үнэ төлбөргүй олгож, гар утасны лизингийн хүүгүй үйлчилгээг Хас банктай хамтран зохион байгуулж, хэрэглэгчиддээ хямд, чанартай үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Мөн гар утаснаасаа дансаа шалгах, гүйлгээ хийх Мобайл банк, Мессеж банк зэрэг үйлчилгээг Хаан банктай хамтран үзүүлж байна.

Юнител корпорацийн салбар нь урьдчилсан төлбөрт / Happy life, New life. Doping/ 4510 хэрэглэгчдэд, дараа төлбөрт / Dream life, Сонгодог багц 1,2, 3/ үйлчилгээндээ 261 хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж, 2009 онд 145.0 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Скайтел компанийн тус аймаг дахь салбар нь 2009 онд нийт 1680 хэрэглэгчтэй болж, хэрэглэгчиддээ дараа төлбөрт Вип, Бизнес класс, Найс, урьдчилсан төлбөрт D-20, Эконо, Колл плас үйлчилгээнүүдийг үзүүлж, ярианы тарифийн хамгийн хямд үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.

Үүрэн холбооны операторууд мэдээлэл харилцаа холбооны газрын суурь сүлжээг тоон технологиудад шилжүүлж, 3G, 3.5G үелзэлд оруулсан, дэвшилтэт технологиуд, шинэ үйлчилгээг орон нутгийн хэрэглэгчиддээ цаг алдалгүй нэвтрүүлж байгаагаас гадна өндөр хурдны утасгүй интернетийн USB модем ашиглан интернетийг хямд, хурдан шуурхай хэрэглэхэд чиглэсэн үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

Шуудан үйлчилгээ

Говьсүмбэр аймгийн Шуудан үйлчилгэний салбар 2009 онд 44.2 мянган төгрөгийн ном, 453.1 мянган төгрөгийн үнэт цаас, 437.5 мянган төгрөгийн марк, 1050.0 мянган төгрөгийн түрээсийн орлого, хайрцаг, хүргэлт, гардуулалтаас 249.8 мянган төгрөг бичиг захидал, буухиа зэргээс 567.8 мянган төгрөгийн орлого оруулан ажиллаа.

Нийт дөрөв дүгээр улиралд салбарын хэмжээнд нийт 5492.2 мянган төгрөгийн орлого олохоос 5121.0 мянган төгрөгний орлого оруулж ажилласан байна. Ирэх онд алдагдалаа бууруулах ашиг нэмэгдүүлэх талаар ажил зохион байгуулж 2010 онд салбарын хэмжээнд борлуулагдахгүй байгаа үнэт цаасны орлогыг нэмэгдүүлж ажиллах талаар шинэ ажил зохион байгуулахад бэлэн болгоод байна.

Шуудан үйлчилгээний салбар нь шуудангийн үйлчилгээгээр дамждаггүй байсан зарим албан байгууллага аж ахуй нэгжүүдийн албан бичгийг шуудангийн үйлчилгээгээр дамжуулан явуулдаг болголоо.

Зам тээвэр

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 67-р тогтоолын дагуу Тээвэр, авто замын газрыг байгуулан ажиллаж байна. Улаанбаатар-Говьсүмбэр чиглэлийн хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд “Эрдэм транс” ХХк, “Мандах нарны зам” ХХК-ны том оврын 6 автобус үйлчилж байна. Аймгийн төв болон сум хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг зохицуулах үүднээс Засаг даргын захирамж гаргуулж стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл бүхий иргэдийг ажлын байраар хангаж аймгийн төвийн таксины үйлчилгээ эрхлэгчдийг “Сүмбэр хүлэг” ХХКомпани болгон зохион байгуулж 42 такси эрхлэгч, Шивээговь–Сүмбэр сум хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ

эрхлэгчдийг “Бодь зам “ ХХКомпани болгон зохион байгуулж 5 микро автобус үйлчилгээнд явж байна.

Мөн 3 км замыг цэвэрлэж, арчлах үүрэг бүхий 2 хүнийг ажиллуулж байна.

2009 онд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг оношлогоонд 1517 тээврийн хэрэгсэл орж, техникийн хяналтын үзлэг оношлогооны орлого 16.565.000 төгрөг, хот, аймгийн төв, сум хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд 13950 зорчигч үйлчлүүлж 3.926.800 төгрөгийн тээврийн үйлчилгээний зохицуулалтын орлого орж нийт 20.491.800 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг, оношлогоог Авто тээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын үзлэг хийх журам, холбогдох стандартуудын дагуу тээврийн хэрэгслийг явуулын тоног төхөөрөмжөөр оношлож стандарт шаардлага хангасан 1361 тээврийн хэрэгсэлд “2010” гэрчилгээ олгосон байна. 150 гаруй тээврийн хэрэгсэл стандарт шаардлага хангаагүй байна. Нийтийн тээврийн 29 тээврийн хэрэгслийг давтан оношлогоонд хамруулсан байна.

Авто тээврийн хяналт шалгалтыг сайжруулах үүднээс Авто тээврийн хяналтын улсын байцаагчийн ажлын цагийн графикийг Замын цагдаагийн тасгийн байцаагч, зохицуулагч нарын ажиллах цагтай уялдуулан хяналт шалгалтыг тогтмолжуулах арга хэмжээ авч байна.

7. БАЙГАЛЬ ОРЧИН ГАЗРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Ойжуулалтын ажлын талаар:

Сүмбэр сумын Хонхор хотхоны 10 га талбайд унжгар бургас, мөнгөлөг улиас, шар хуайс, хайлаасны нийт 6080 суулгац суулган ойжуулалтын ажлыг хийж, намрын тооллогоор ургалт 76 хувьтай тоологдсон.

Намрын тарилтаар байгаль хамгаалах сангаас 2.5 сая төгрөг зарцуулж 33 унжгар бургас, мөнгөлөг улиас, 4 сарнайн бут нэмж тарьсан.

Ойжуулах, орчноо цэцэрлэгжүүлэх ажлын хүрээнд:

БОАЖСайдын албан даалгаврын дагуу 2009 оны 4 сарын 25-наас 5-р сарын 25-ны өдрүүдэд “Бүх нийтээр мод тарих” сарын аяныг зохион байгуулж, иргэд байгууллагууд 3182 мод тарьсан. Мөн “Чойр эко парк” төслийн хүрээнд 8000 гаруй модыг нөхөн тарилтаар **нэмж** тарив.

Аймгийн хэмжээнд ургаж буй модны тооллого явуулахад Шивээговь сум 4 төрлийн 655 мод, Баянтал сум 3 төрлийн 401 мод, Сүмбэр сум 9 төрлийн 2767, Чойр эко парк төслийн 28224 мод, нийт 32057 мод байна.

БОАЖЯ-ны 4.2 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжих “Мод үржүүлгийн газар байгуулах” төслийг МСҮТ сургалтын төв авч 0.5 га талбайд үр мөчрийн эх цэцэрлэгийн болон тарьц суулгац үржүүлгийн 10000 гаруй тарьц ургуулах бэлтгэл хангагдсан. Үржүүлгийн энэ талбайд олон наст өвсний ботууль, биелэг зэрэг 5 төрлийн үрийг тариалж үр авах боломжийг судалж байна. Шивээговь сумын Хаялага нуурыг түшиглэн 5 га газрыг бойжуулгын талбай болгон сонгон авч хайлаас, буйлс, сухай, жигд, агч зэрэг 2600 мод сөөг тариалсан.

“Хашаанд чинь мод таръя” хөдөлгөөнийг өрнүүлж Шивээговь суманд 150 мод, Сүмбэр суманд 400 модны суулгацыг иргэдэд тараан өгч мэргэжлийн заавар зөвөлгөөгөөр хангав.

Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар:

. “Чойрын Богд” ууланд нутагшсан аргаль хонинд 320 боодол өвс тавьж өгч биотехникийн арга хэмжээ авлаа. Энэ ажилд 1546,0 мянган төгрөг зарцуулсан. БОАЖЯамтай хамтран аргаль хонины тооллого явуулахад 150 гаруй аргаль хонь тоологдож, 2007 оны тооллогоос хойш 80 тоо толгойгоор өссөн дүн гарлаа.

Эргүүл шалгалтын ажлын талаар:

Хулгайн антай тэмцэх зорилгоор аймгийн Засаг даргын 08 дугаар сарын А/264 тоот захирамжаар БОАЖГазар, ОБХэлтэс, ЭМГазар, МХГазар, Цагдаагийн хэлтэс, ХХААЖДҮГГазар, Сумдын ЗДТГазрын хамтарсан баг Шувууны ханиад, тарваган тахал гарч болзошгүй нутгаар эргүүл шалгалтын ажлыг хуваарийн дагуу 8 удаа зохион явуулсан. Аянаас гадна энэ онд эргүүл шалгалтын ажлыг 21 удаа 2692 км явж 356 өрхийн 1756 хүнд төрийн үйлчилгээг хүргэж 268 ширхэг гарын авлага тараасан.

Эргүүл шалгалтаар Шивээговь сумын Урсахын ухаа хэмээх газар гараар чулуужсан мод ухаж байсан иргэдийг илрүүлэн чулуужсан модыг хураан авч, Баянтал сумын Шилийн худаг орчим цагаан зээрийн эргүүл хийх явцад зөрчилтэй байсан Төв аймгийн Баян сумын 5 иргэнийг ачааны машин, мотоциклийн хамт цагдаагийн байгууллагад тус тус хүлээлгэн өгсөн.

Усны тоо бүртгэлийн талаар: Аймгийн хэмжээнд гадаргын усны тоо бүртгэлийг хийж 5 гол, 2 рашаан, 6 булаг, 11 цооног, 7 нуур тойром, 1 баянбүрд, 272 худаг уст цэг тоологдлоо.

Булаг, шандын эх тохижуулах ажлын талаар: Аймгийн Засаг дарга захирамжаар 2 булаг шандын эх хашиж хамгаалах ажлын үнэлгээний хороо байгуулагдан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу сонгон шалгаруулалт явуулж “Чойр оргил” хоршоо шалгарч Сүмбэр сумын Гүн шанд, Өгөөмөрийн голын эхийн 0.35 га талбайг хашиж булгийн эх тус бүрд 15 улиас, хайлаасны суулгац тарьж нутгийн малчин иргэдэд хүлээлгэн өгснийг үнэлгээний хороо хүлээн авсан.

Хог хаягдлыг багасгах ажлын хүрээнд

Нийтийн эдэлбэр 15449 га газрын 11784.5 тонн хог хаягдлыг, барилгын туурь хогтой 2.51 га талбайн 12617 тонн хог хаягдлыг цэвэрлэж орон нутгаас 11.9 сая төгрөг зарцуулаа. Мөн сумдын төвлөрсөн хогийн цэгийг зурагжуулж хашаажуулах төсөл боловсруулаад байна.

Аймгийн Засаг даргын 2009 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/87 тоот захирамжаар “Цэвэр орчинд амьдарцгаая” аяныг 2009 оны 3-р сарын 28-ны өдрөөс 5-р сарын 8-ны өдрүүдэд зохион байгуулан ажилласан. Аяны хүрээнд аж ахуйн нэгж албан байгууллагуудын 923 ажилчдыг оролцуулж, 27 тонн хогийг төвлөрсөн хогийн цэгт хүргэлээ. Хатуу хучилттай замын хажуу карьерийн дагуу 2 га талбайг хамарсан барилгын хог хаягдлыг түрж тэгшлэн эрүүлжүүлэв.

Сүмбэр сумын гэр хорооллын 2000 тн элсийг цэвэрлэж, орон нутгийн төсвөөс 2.4 сая төгрөг зарцуулсан.

Аймгийн ХХҮХ-тэй хамтран нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж 167.9 га газрын 8770 тонн хог хаягдлыг, 4 нурсан барилгын туурийн 7150 гаруй тонн хог хаягдлыг цэвэрлэж давхардсан тоогоор 123 хүнд 5.9 сая төгрөгийн цалин олгов.

Баянтал сумын хэмжээнд хувь хүний ухсан 722 м² нүхийг нөхөн сэргээлт хийлгэн хүлээн авсан. Мөн аймгийн ОБХ-тэй хамтран 3 хоногийн иж бүрэн сургалтад 4 техник, 263 хүнийг хамруулан, их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж 1.4 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн ажил хийв.

Сүмбэр сумын хэмжээнд барилгын туурь хог хаягдалтай талбайг цэвэрлэсэн иргэдэд газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлэх шийдвэр гаргаснаар 2 иргэн 1200м² талбайн хогийг цэвэрлэв.

Нийтийн их цэвэрлэгээг 5 удаа зохион байгуулж 783 га талбайд 1600 гаруй иргэнийг хамруулан 2942 тонн хогийг цэвэрлэлээ.

Шивээговь сумын хэмжээнд хуримтлагдсан хог хаягдалтай талбайг аж ахуйн нэгж байгууллагуудад хуваарилан цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулж 2000 тонн үнс, 576 тонн элс, 3489 м³ талбайн 5467 тн хогийг цэвэрлэсэн.

Нөхөн сэргээлтийн ажлын талаар: “Шивээ-Овоо” ХК-ний 1.5 га талбайд биологийн нөхөн сэргээлтээр тарьсан 700 тоорой, 500 сухай, балгана, хайлаас, хармаг 1000 -ыг тарьсан.

Химийн бодисын тооллогын талаар: Засгийн газрын тогтоолын дагуу химийн бодисын тооллогыг 2 жилд нэг удаа тоолж байхаар заасны дагуу аймгийн хэмжээнд химийн бодисын тоо бүртгэлийг сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион явуулсан. Тооллогонд 3 сумын 15 аж ахуйн нэгж байгууллага хамрагдан давхардсан тоогоор 275 төрлийн бодис тоологдсон.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах талаар

Дотоодын аялалыг хөгжүүлэх бодлогоор “Нутгийн хайрхан”, “Чандмань Эрдэнийн Эрэлд” эко аялал, Эрүүл амралт” дугуйн аялалыг зохион байгуулж 60 гаран хүнийг хамрууллаа.

Улаанбаатар хотноо зохиогдох “Mongolia ITF2009” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгаас 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцож нутгийн брэнд каракуль хонины арьс, түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг дэлгэн тавьж сурталчилсан. Мөн аймгийн аялалын маршрутын гарын авлага, аймгийн танилцуулга ном нийт 1650 ширхэг гарын авлага материалыг иргэдэд тараан үйлчиллээ.

Мөн аймгийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа 9 зочид буудал, 1 аялал жуулчлалын бааз, 6 ресторон, кафены судалгааг гаргалаа.

Аймгийн Музей, МХГ-тай хамтран орон нутгийн булш хиргисүүрийн тооллого явуулж, 18 хэсгийн 100 гаруй булш хиргисүүр байгааг бүртгэж, баримтжуулсан.

8.ГАДААД ХАРИЛЦАА

Гадаад харилцааны талаар төрөөс баримталж буй бодлого, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх, хөрш зэргэлдээ буюу өндөр хөгжилтэй орнуудын муж, районууд, олон улсын байгууллагуудтай найрсаг харилцаа холбоо тогтоож, хүч туслалцааг нь аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэхэд бүтээлчээр ашиглахад үйл ажиллагаагаа чиглүүлж ирэв.

БНХАУ-ын Эрээн хот, Оросын Холбооны улс, Зүүн Хойд Азийн Бүс нутгийн Засаг захиргаадын холбоо, Герман улсын элчин сайдын яам, Оросын Холбооны улсын элчин сайдын яамтай тус тус холбоо харилцаа тогтоон ажиллаж байна.

Зүүн хойд Азийн орнуудын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож аймгийн танилцуулга материал болон зарим онцлог үйл явдлыг нийгэмлэгийн вэб сайтад тавьж аймаг орныг сурталчилж байна.

Хятадын Хэнань мужид зохион байгуулагдсан “Аялал жуулчлалын дэд хороог байгуулах” хуралд 3 хүн , Солонгосын Пухан хотод зохион байгуулагдсан “Эдийн засгийн зөвлөгөөн.”-нд 1, Шинжлэх ухаан технологийн хуралд 1 хүнийг тус тус оролцуулсан нь үр дүнгээ өгч бизнесийн хүрээ тэлж, төрийн албан хаагчийн мэдлэг, дадлага, туршлагыг арвижуулсан чухал арга хэмжээ болсон.

Оросын холбооны элчин сайдын яамтай соёл, Герман улсын элчин сайдын яамтай эрүүл мэнд, боловсролын чиглэлээр харилцаа тогтоож үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Герман улсын элчин сайдын 1 өдрийн айлчлалаар Чойр уулын үзэсгэлэнт газруудыг үзүүлэн, МСҮТ-ийн үйл ажиллагааг танилцуулсан.

Герман улсын ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн дарга холбогдох хүмүүсийн хамт 2 өдрийн айлчлал хийн, Эрүүл мэндийн газрын ажил байдалтай танилцлаа.

Айлчлалын хүрээнд Сансар зусланд амраан, бэсрэг наадам үзүүлж, хөдөөгийн амьдрал ахуйтай танилцуулах ажлыг амжилттай зохион байгуулсан.

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Гадаад харилцааг эдийн засагжуулахад тулгамдсан асуудлууд” сэдэвт үндэсний зөвлөлгөөнд аймгийн төлөөлөгчид оролцож “Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах нь” үндэсний хөтөлбөрт аймгийн нийгэм эдийн засгийг гадаад хамтын ажиллагаагаар хөгжүүлэх 4 саналыг тусгуулаад байна.

Буриад улсын Бичурин районы харилцаа тогтоох саналыг хүлээн авч аймгийн талаарх товч танилцуулга, саналыг хүлээж авсан шийдвэрийн хамт ОХУ-ын элчин сайдын ямаар дамжуулан хүргүүлээд байна.

ОХУ-ын элчин сайдын яам, Монгол Оросын найрамдлын нийгэмлэгтэй тогтоосон харилцаагаа бататган найрамдлын өдрүүдээр уламжлалт арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн байсан хэдий ч А хүрээний Н1N1 вирус гарсантай холбогдуулан хойшлуулж Оросын соёл Шинжлэх ухааны төвд Говьсүмбэр аймгийн “Боржигин чуулга”-ын үйл ажиллагааг сурталчилж, Боданчар сэцэн, Аймшигт анчин Пандухайн паян зэрэг жүжгүүдийг тоглолоо.

Аймгийн эдийн засаг, нийгмийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулан хамтын ажиллагаатай гадаадын орнуудын хотууд, ЭСЯамдууд, ОУБ-дад тавьж Дэлхийн зөн ОУ-ын байгууллага, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Говийн бүсийн эдийн засгийн хөгжлийн санаачлага, Солонгос Монголын туул Ротари, Тогтвортой амьжиргаа II төсөл зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжигдэх “Гэр хороололыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх” төслийг Сүмбэр сумын гэр хороололд хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан 2 иргэнийг ажиллуулж байна. Тус төсөл нь Сүмбэр сумын 1000 өрхийн 4000 гаруй иргэдийн дунд хэрэгжиж иргэдийн өөрсдийн оролцоотой орчныг тохижуулах, хамтран ажиллах сэтгэлгээ төрүүлэх зорилготой юм.

Хүрээ Ротари клубээс “300 эмэгтэйд хавдрын шинжилгээ хийх” ажлыг орон нутагт амжилттай зохион байгуулсан. Цаашид аймгийн төвийн хүн амын ундны усыг цэвэршүүлэх талаар хамтран ажиллахаар хүсэлт тавиад байна.

Дэлхийн Зөн Олон улсын байгууллагын хөрөнгөөр Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн хичээлийн байр, тоног төхөөрөмж, оюутны дотуур байрыг барьж ашиглалтад орууллаа.

Төрийн албан хаагчдыг гадаад сургалт, аялалд хамруулах бодлого барьж ажилласнаар Зүүний хүчний холбооны зардлаар аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 1 эмчийг Энэтхэг улсад англи хэлний 2 сарын сургалтад, Солонгос Хятад улсад 5 албан хаагчийг хамруулав.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛЭН ЗАХИРАГЧААС АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

ЗОРИЛТ: Төсвийн ерөнхийлэн захирагчидтай байгуулсан гэрээг бүрэн биелүүлэх

2009 онд аймгийн Засаг дарга нь Шадар сайд, Эрүүл Мэндийн Яам, Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, Хүнс Хөдөө Аж Ахуй Жижиг Дунд Үйлдвэрийн Яам, Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам, Хууль Зүй Дотоод Хэргийн Яам , Барилга Хот Байгуулалтын Яам , Үйлдвэр Худалдааны Яамны сайд, дарга нартай Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ байгуулан ажилласан.

Батлан хамгаалахын сайдад

Аймгийн Засаг даргаас Батлан Хамгаалахын сайдтай бүтээгдэхүүн нийлүүлэлт ,санхүүжилтийн талаар байгуулсан гэрээ бусад удирдлагын баримт бичгүүдийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаал, удирдамжийн дагуу дайчилгаа, бэлэн байдлыг дээшлүүлэх явдлыг гол зорилгоо болгон ажиллаж батлан хамгаалахын багц хууль, цэргийн шинэчлэлийн бодлогыг аймаг, сум, багийн удирдлагууд болон ард иргэдэд сурталчилан таниулж биелэлтийг хангуулж байна.

Бэлэн байдлын зэргүүдэд шилжих үед ажиллах зааврыг холбогдох албан тушаалтануудад тогтмол танилцуулан зааварчилгаа өгч ажиллаж хуваарийн дагуу дайчилгааны даалгавар, төлөвлөгөөнд тодотгол хийв.

Зэвсэгт хүчний баяр, Халх голын ялалтын 70 жилийн ойн хүрээнд Батлан Хамгаалах хууль сурталчилах зорилгоор цэрэгжүүлсэн байгууллагуудын дунд цэрэг спортын уралдаан тэмцээнийг явуулж орон нутгийн телевизээр сурталчилсан. Зэвсэгт хүчний ойг угтан хоёр сарын ажил зохион ахмад дайчдын гавьяаг алдаршуулан мөнхжүүлэх зорилгоор төрөл бүрийн арга хэмжээ зохион явуулан цэргийн баяраар хүлээн авч хүндэтгэл үзүүлэв

Аймгийн хэмжээнд 2009 онд цэргийн алба хаах иргэдийг сонгон шалгаруулж зэвсэгт хүчний захиалагт тоог 100 хувь биелүүлсэн.

2009 онд цэргийн албаа хааж ирсэн иргэдийг өөрсдийн сонирхсон мэргэжлээр аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд урилгаар оруулан суралцуулж байгаа нь ар гэр хамт олны талархалыг хүлээсэн ажил болсон.

Тус аймгийн дүйцүүлэх албаны шуурхай бэлэн байдлыг шалган сургууль дадлага хийж, болзошгүй гамшиг ослын үед авран хамгаалах, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх дадлага эзэмшүүлэн ажиллаж байна.

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яамны сайдад

Монгол Улсын Төсвийн байгууллагын Удирдлага санхүүжилтийн тухай хууль болон 2009 оны Төсвийн тухай хуулиар Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад заасан чиглэлийн дагуу хоёр талаас байгуулсан гэрээг хэрэгжүүлэхэд **2,230,056,0** тэрбум төгрөгийн төсвийг зарцуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хүлээх үүргийн дагуу 3 бүтээгдэхүүн ангийн 38 бүтээгдэхүүнийг нийлүүлж ажиллалаа.

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлэхийн тулд Боловсролын салбарын удирдах ажилтны болон багшлах боловсон хүчний манлайлах ур чадвар, мэдлэг боловсрол, мэргэшил, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгох төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажилласан. Тухайлбал Сургуулийн өмнөх боловсролын хувьд 487,6 сая төгрөгийн санхүүжилт авахаас 454,2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 93,1 хувь, энгийн цэцэрлэгийн хувьд 471,8 сая төгрөгийн санхүүжилт авахаас 439,6 санхүүжилт авч 93,7 хувь, Ерөнхий боловсролын хувьд 1,417,7 сая төгрөгийн санхүүжилт авахаас 1,383,4 сая төгрөгийн санхүүжилт авч бүтээгдэхүүнийг нийлүүлээ.

2009 оны 5-р сард Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын бодлого хариуцсан мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөн туслах багийг Боловсролын байгууллагуудад ажиллуулж, гарсан саналын дагуу Боловсрол Соёлын Газрын төсвийн зарцуулалтанд хяналт- шинжилгээ үнэлгээ хийлгэж, төсвийн төлөвлөлтөнд гарсан алдааг засуулж, зарцуулалтыг оновчтой болгох ажлыг зохион байгууллаа.

2008-2009 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд Сургуулийн өмнөх боловсрол- хамран сургалт 75 хувь, бага боловсролын хамран сургалт 100 хувь, суурь боловсролын хамран сургалт 98 хувьтай, Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт өмнөх оныхоос 10,8 хувиар ахисан байна.

Ерөнхий боловсролын хичээлийн стандарт хангалтын түвшин 80 хувь, өмнөх оноос 0,3 хувиар ахисан байна.

Энэ хичээлийн жилд Баянтал сумын цэцэрлэг, сургуулийн дотуур байрыг шинэ байртай болгож, аймгийн хэмжээнд дотуур байранд хамрагдвал зохих хүүхдийг 100 хувь хамрууллаа

Хууль зүй, дотоод хэргийн сайдад

Уг гэрээнд стратегийн 8 зорилт дэвшүүлж, нийлүүлбэл зохих нийт бүтээгдэхүүн 4 үндсэн бүтээгдэхүүний ангийн хүрээнд 26 бүтээгдэхүүн, тусгай захиалгат 5 бүтээгдэхүүн, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд 2 бүтээгдэхүүн нийлүүлэхээр, санхүүжилтын хуваарийг хавсаргасан. Бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтын гэрээний биелэлт 98,6 хувь байна.

Цагдаагийн байгууллагыг нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 08 тоот албан даалгавар, Засгийн газрын 2005 оны “Хөтөлбөр батлах тухай” 234, “Үйл ажиллагааны чиглэл батлах тухай” 266-р тогтоолууд, ЦЕГ-ын даргын 2006 оны 09, 2007 оны 02 тоот албан даалгаврууд, 2009 оны Цагдаа, Дотоодын цэргийн төв орон нутгийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн дээр ХЗДХ-ийн сайд Ц.Нямдоржийн өгсөн үүргийн дагуу ажиллалаа. Цагдаагийн алба хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч, ЦЕГ-ын Тамгын газраас ирүүлсэн биелэлт үр дүнг тооцох албан баримт бичгийн жагсаалтын дагуу дээд байгууллагын тушаал шийдвэр, хөтөлбөрүүдийн биелэлтийг тооцож холбогдох журмын дагуу үнэлгээ, шинжилгээ хийж хугацаанд нь биелэлтийг нь тооцон хүргүүлж байлаа. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой шинээр батлагдсан, тушаал, шийдвэрүүд, зөвлөмж, бусад холбогдох эрх зүйн актуудыг тухай бүрт нь албаны сургалтаар алба хаагчдад судлуулж ажиллав.

Аймаг орон нутгийн захиргааны байгууллагаас Шивээговь сумын Цагдаагийн тасгийн автомашины сэлбэгэнд 1600000 төгрөг, автозамын сангийн хөрөнгөөр замын цагдаагийн 24

цагийн байнгын постны тохижилтонд 5.8 сая төгрөгийг зарцуулж байгууллага, алба хаагчдын ажиллах хэвийн нөхцлийг бүрдүүллээ. Аймаг орон нутгаас хэсгийн төлөөлөгчдийг компьютер, мотоцикльтой болгосон.

Баянтал сумын хэсгийн төлөөлөгчийн ажиллах нөхцлийг бүрдүүлж кобоны зориулалтаар 1 орцыг 45,0 сая төгрөгөөр засварлаж ашиглалтанд өгөв.

Цагдаагийн хэлтсийн нийт 9 албан хаагчид 13 сургалтанд хамрагдсан.

Малын хулгайн гэмт хэрэг энэ онд 9 гарч илрүүлэлт 100 хувь, хэргийн шийдвэрлэлт 66, хувьтай бөгөөд урьд оны түвшинд байна.

Иргэдээс ирүүлсэн 1367 өргөдөл, гомдол мэдээллүүдийг хуулийн анхны хугацаанд шалган шийдвэрлэх, иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчлэхийг гол зорилтоо болгон ажилласнаар өргөдөл мэдээллийнхээ 64,3 хувийг 5 хоногт буюу хуулийн анхны хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд энэ нь өнгөрсөн оноос 7,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөрдөн байцаагч нарт өргөдөл, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлүүлэх зорилгоор хяналтын талоныг шинээр санаачлан гаргаж ажилладаг болсон нь зохих үр дүнгээ өгч байна.

Нийтийн эргүүл давхардсан тоогоор нийт 93 байгууллагаас 678 хүн 186 өдөр, 680 цаг гарч үүрэг гүйцэтгэсэн.

2008 оны жилийн эцсийн тайлан баланс Аудитын газраас зөрчилгүй гэсэн дүгнэлт гарсан. Тус хэлтсийн 2009 оны батлагдсан төсөв 442378,0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 442378,0 мянган төгрөг буюу 100%, өөрийн орлого 1129,5 мянган төгрөг, нэмж ЦЕГ-аас 1714,9 мянган төгрөг нийт орлого 445222,4 мянган төгрөг, зарлага 445222,4 мянган төгрөг, өр авлага байхгүй, касс харилцах үлдэгдэл 0 байна. Батлагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж оновчтой хувиарлаж, хяналт тавьж ажилласнаар эхний 12 сарын байдлаар 442378,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 442378,0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдад

Нийгмийн хамгаалал,Хөдөлмөрийн салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчтай аймгийн Засаг даргын 2009 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр гарган нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд явуулж дүгнүүлсэн болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хүлээх үүргийн дагуу Тусгай захиалгат бүтээгдэхүүний 1.2-р анги,Ерөнхий бүтээгдэхүүний 1-6-р анги,нийт 30 бүтээгдэхүүн нийлүүлж ажиллалаа

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланг хугацанд явуулсан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэцийг 5 байгууллага өөрийн хөрөнгөөр бий болгосон.Эрэгтэй эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг,хариуцлага тэгш байдлын талаар сургалтыг гэрээгээр хүлээсэн 175 хүний дунд амжилттай зохион байгуулж мэдээллээр бүрэн хангасан.Орон гэргүй тэнэмэл,бичиг баримтгүй 40 иргэнийг бичиг баримтжуулж холбогдох үйлчилгээнд хамруулсан.

Нийгмийн даатгалын тэгэвэр тэтгэмж авагчдад хөнгөн шуурхай хуулийн хүрээнд үйлчилж шинээр нэрийн данс нээх үйлчилгээнд 163 хүнийг хамруулан шимтгэлийн орлогоор оруулах хөрөнгийг 100.6 хувь,сайн дураар даатгуулагчдын оруулсан шимтгэлийн орлогыг 107.1 хувиар тус тус давуулан биелүүлсэн.

ХААН,ХАС,Монгол Шуудан банкаар дамжуулан ХЭДС-ийн зээл,Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зээл,жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зээл болон улсын төсөв,хувь хүний хөрөнгөөр 383 ажлын байр шинээр бий болсон. Үүний 293 нь байнгын ажлын байр байна.Шинэ ажлын байр бий болгоход 747413.0 мянган төгрөгийн зээл олгогдсон байна.Үүнд:-ХЭДС-ийн зээлээр байнгын 57 ажлын байр,хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зээлээр 34,жижиг зээлээр 52 иргэн зээл авч үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байна.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээгээр улирлын чанартай 90 ажлын байр,аж ахуй нэгж байгууллага хувь хүмүүсийн хөрөнгөөр шинэ байнгын ажлын байр 150 тус тус бий болсон байна.33 удаагийн нийтийг хамарсан ажлыг 3 сумын ЗДТГ,ХХҮХ,НДХ,Цагдаагийн хэлтэс,Холбооны газар,Ус-ду,Тохижилт Сүмбэр,СӨХ,цээрлэг,сургуулиудтай гэрээ хийж зохион байгуулан 716 иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласан.

Нийгмийн халамжийн багц хуулийн дагуу олгогдох тэтгэмжүүдийг цаг хугацаанд олгосон болно.

Нийгмийн халамжийн багц хуулийн дагуу олгогдох тэтгэмжүүдийг цаг хугацаанд олгосон болно.НХХЯ-ны ХШҮ-ний газрын үнэлгээ 100.0

Орон нутгийн ахмадын байгууллага нь гэрээний дагуу 8122.0 мянган төгрөгийн санхүүжилт авч ажилласан.Тус аймагт нийтдээ 999 ахмад настан байна.Ахмадын байгууллагаас зохион байгуулсан үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 98 хувьтай байна.

2009 оны Нийгмийн хамгаалал Хөдөлмөрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний **Ерөнхий үнэлгээ 86.8.Оноо 4.338** байна.

Эрүүл мэндийн сайдад

Эрүүл мэндийн салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчтай аймгийн Засаг даргын 2009 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээний биелэлтийг улиралаар гарган Эрүүл мэндийн яаманд явуулж дүгнүүлж байсан болно.

Тухайн жилд гүйцэтгэлээр улсын төсвөөс 714.6 сая төгрөгийн, ЭМД-ын сангаас 371.7 сая төгрөгийн санхүүжилт авч үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 11.6 сая төгрөг олсон байна. Нийт 197.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн барилга 79.7 сая төгрөг буюу 40.3 хувь, орон нутгийн болон бусад эх үүсвэрээр санхүүжсэн тоног төхөөрөмж 84.7 сая төгрөг буюу 42.8 хувийг эзэлж байна.

Монгол улсын Засгийн газрын болон аймгийн засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан ажилласан. Ялангуяа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өвөрмөц хэрэгцээнд нийцэхүйц эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн тасаг нэгжийг бэхжүүлэх, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх чиглэлээр өргөн хүрээтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй 10 хөтөлбөрүүд, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгаврын хэрэгжилтийн тайланг гарган хугацаанд нь явуулж хэвшсэн.

Эхийн эндэгдлийг бууруулах стратеги төлөвлөгөө гарган ажилласанаар сүүлийн гурван жил эхийн эндэгдэл гаргалгүй ажилласан. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх оноос 1 тохиолдлоор буурч 8 тохиолдол бүртгэгдсэн. 2008 онд нялхсын эндэглийн түвшин 1000 амьд төрөлтөнд 29.6 байсан бол тухайн жилд 22.2 болж буурсан ч улсын болон аймгийн дунджаас өндөр байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 27.8 байгаа нь улсын дунджаас өндөр байна. Бүртгэгдсэн бүх халдварт өвчин өмнөх оноос 130 тохиолдлоор буурч 149 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд ноогдох халдварт өвчин 117.6 байгаа нь улс болон аймгийн дунджаас бага байна.

Засгийн газрын 2008 оны 143 тоот тогтоолын дагуу байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган ажилласан.

Гэрээний дагуу 4 ангийн 10 бүтээгдэхүүн нийлүүлж ажилласан.

Эрүүл мэндийн яамнаас өгсөн **ерөнхий үнэлгээ 78.8 хувь, оноо 3.9**

Байгаль орчны сайдад

Сайдын гэрээнд тусгагдсан 4 ангийн 4 бүтээгдэхүүнийг 87349,3 мянган төгрөгийн санхүүжилттэйгээр 86,3 хувьтай нийлүүллээ.

Орон нутгийн ойжуулалт ойн аж ахуйн арга хэмжээний бүтээгдэхүүнийг гэрээнд заасан 1,5 сая төгрөгийн өртөгтэйгээр Сүмбэр сумын Хонхор хотхонд 10 га талбайд унжгар бургас, мөнгөлөг улиас, шар хуайс, хайлаасны нийт 6080 ширхэг суулгац тариалж энэ ажилд орон нутгийн байгаль хамгаалах сангаас 2,5 сая төгрөг нэмж зарцуулав.

Байгаль орчны салбарын хэмжээнд 2009 оныг байгаль хамгаалагчдыг чадавхижуулах” жил болгон зарлаж Засаг даргын 2009 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/25 тоот захирамжаар

жилийн ажил зохион байгуулж төлөвлөгөө гарган ажиллаа. Хог хаягдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил болгож 15449 га нийтийн эдэлбэр газрын 11784,5 тн хог хаягдлыг, 2,51 га барилгын туурь хогтой талбайн 12617 тн хог хаягдлыг цэвэрлэж орон нутгаас 11,9 сая төгрөг зарцуулж мөн 13 га талбайд 4,0 сая төгрөгөөр 9262 мод бут тарьж ургуулав.

Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний бүтээгдэхүүний ангид 3,0 сая төгрөгийн өртөгтэйгээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу **сонгон** шалгаруулалт явуулж “Чойр оргил хоршоог шалгаруулан ажлыг гүйцэтгүүлж Сүмбэр сумын Гүн шанд, Өгөөмөрийн голын эхийн 0,35 га талбайг хашив.

2009 оны аймгуудын ажлыг дүгнэхэд тус аймаг 112 оноогоор 19 дүгээр байр эзэлж төсвийн ерөнхийлөн захирагчтай ерөнхий менежерийн байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан 3 ангийн 44 бүтээгдэхүүнийг 81,03 хувьтай нийлүүлсэн.

ХХААХҮЯ-ны сайдад

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр хүлээсэн 5 ангийн 16 бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс 109.5 сая төгрөгийн санхүүжилт авч бүтээгдэхүүнийг бүрэн нийлүүллээ.

“Малын эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд малаас хүнд халдварладаг адууны ям, үхрийн сүрьеэ, малын бруцеллёз өвчнийг өрх суурийн түвшинд эрүүлжүүлж эхэллээ. Мал амьтны халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 197.2 мян мал буюу нийт мал 1 удаа, паразиттах өвчнөөс хамгаалах эмчилгээнд нийт мал 1.5 дахин хамрагдаж шинээр өвчлөл гараагүй. Мал амьтны 23 нэрийн халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтанд 118.2 мян мал, гоц халдварт цэцэг өвчний вакциныг бүх хонинд/69 мян тун/, адууны томуугийн вакциныг 3000 адуунд хийж дархлаажуулснаар шинээр мал амьтны өвчлөл гараагүй тайван байна.

“Малын чанар сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд шинээр хоёр мал үржлийн нэгж байгуулагдан ажиллаж байгаагийн гадна “Сүмбэр” үүлдрийн хонины тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор 2 аж ахуйн нэгж бүгд 470 толгой нутгийн монгол эм хонь худалдан авч эрлийзжүүлж эхэллээ.

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” болон “Малын тэжээл” хөтөлбөрийн оны зорилтыг хэрэгжүүлж Сүмбэр сумын “Сүмбэр-айраг” хоршоо 15 га-д малын тэжээл тариалж 62.1тн ургац хурааж, 200тн-н хүнсний зорь байгуулж дуусган эрчимжсэн МАА-ГТ-ийн загвар аж ахуйн суурийг тавилаа.

“Атрын III аян” тариалангийн хөгжлийн дэд хөтөлбөр, “Ногоон хувьсгалII”, “Хүнсний баталгаат байдал”, “Экологийн цэвэр бүтээгдэхүүн” зэрэг хүнсний хөтөлбөрийн оны зорилтуудыг хэрэгжүүлж хүн амын хүнсний хэрэгцээний 1100 тн махыг бүрэн хангаж байгааг бататгалаа. Мөн усалгаатай талбайн хэмжээг 31 га-д хүргэж нийт 24.8 га-с 128.8 тн төмс, хүнсний ногоо хураан авч жилийн хэрэгцээний 21 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангалаа.

“Нэг суурин-нэг бүтээгдэхүүн бренд” болон дээрхи хүнсний хөтөлбөрүүдийн хүрээнд “Шилмэл мал, Шилдэг бүтээгдэхүүн-2009” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж аймгийн бренд

бүтээгдэхүүнээр “Сүмбэр хонь”, Шивээ-овоо ХХК-ны хүрэн нүүрс болон бүх сумын шилмэл мал бүтээгдэхүүнийг шалгаруулж баталгаажууллаа.

Мөн “Жижиг дунд үйлдвэр” дэд хөтөлбөрийн оны зорилтыг хэрэгжүүлж ЖДҮ-ийг дэмжих санд 782.5 сая төгрөг 64 төсөлд 737.65сая төгрөгийн зээл олголоо.

“Хоршоо II” хөтөлбөрийн хүрээнд “Тогтвортой амжиргаа II” төслийн нэгжтэй хамтран малчдыг **албан бус малчны бүлгийн** зохион байгуулалтанд хамруулан бэлчээр хашиж хамгаалах, нөхөн сэргээх, тэжээлийн ургамал тариалах, гар худаг гаргах, тэжээлийн агуулах засварлах зэрэгээр нийт 24 бүлгийг бүгд 60 сая төгрөгийн төслийн дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулаа.

-Аймаг, сумын мал эмнэлэг, ариун цэврийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын лабораториуд хүнсний зах, дэлгүүт худалдаалж буй мах, сүү, будаа, гурилан зэрэг хүнсний бүтээгдэхүүн мөн ноос, арьс шир зэрэг түүхий эд, бүтээгдэхүүний дээжийн шинжилгээг зохих түвшинд хийж хүн амыг эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах зарим нөхцлийг бүрдүүлж ажиллаа.

Аймгийн ХХААЖДҮГ нь яамны хэмжээнд ажил дүгнүүлэхэд 15-р байранд орж “Хангалттай гэсэн үнэлгээ авлаа.

3.2. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРТЭЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

ЗОРИЛТ: Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг сайжруулах, биелэлтийг бодитой дүгнэж, хэвших зорилт тавин ажиллаж байна.

Төсвийн ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ нь байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй нягт уялдсан Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн юм.

2009 онд ерөнхий менежерүүдийн үр дүнгийн гэрээг дүгнэж журмыг шинэчилэн баталсан

Аймгийн Засаг дарга эрхлэх хүрээнийхээ 16 агентлагтай үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан. Ерөнхий менежерүүдийн үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяа хэлтсүүдээр дамжуулж Хяналт шинжилгээ үнэлгээний тасаг ажлын үзүүлэлт бүрийг урьд онтой харьцуулж, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, цаг үеийн ажлын оролцоо зэргийг нэг бүрчлэн тооцож Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан дүгнэлээ.

2009 оны үр дүнгийн үнэлгээгээр “А” үнэлгээ авсан аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Статистикийн хэлтсийн ерөнхий менежерүүдийг журмын дагуу албан тушаалын нэг сарын цалингаар, “В” үнэлгээ авсан байгууллагын ерөнхий менежерүүдийг албан тушаалын сарын цалингийн 60 хувиар шагнаж урамшуулсан .

2009 ОНЫ ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРҮҮДИЙН ГЭРЭЭНИЙ ДҮН

Харъяалах хэлтэс	Агентлагууд	НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	ТУСГАЙ БҮТЭЭГДЭХҮҮН	ӨМЧЛӨГЧИЙН ЭРХИЙГ ХЭВЭГЖҮҮЛЭХ	НИЙТ ДҮН	ҮНЭЛГЭЭ
ТЗУХ	Аймгийн Засаг даргын Тамгын газар	36	27	28	91.0	A
	<i>Онцгой байдлын хэлтэс</i>	33.9	27.2	29.3	90.4	A
Хууль зүйн хэлтэст	<i>Цагдаагийн хэлтэс</i>	31.1	25	24.2	80.2	B
	<i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба</i>	25.5	20	28	73.5	C
	<i>Мэргэжлийн хяналтын газар</i>	33.74	29	24.6	87.34	B
Хөгжлийн бодлогын хэлтэс	ХХААЖДҮГ	32.44	25	26	83.44	B
	БОАЖГ	28.43	23.3	29.3	81.03	B
	<i>Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар</i>	33.5	26.6	25	85.1	B
Санхүү, төрийн сангийн хэлтэс	<i>Татварын хэлтэс</i>	33.8	26	26.6	86.4	B
	<i>Статистикийн хэлтэс</i>	39.5	21	30	90.5	A
	<i>Нийгмийн даатгалын хэлтэс</i>	26.2	28.5	30	84.7	B
Нийгмийн хөгжлийн хэлтэс	<i>Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс</i>	36.13	28.7	26	90.83	A
	<i>Эрүүл мэндийн газар</i>	34.62	23.1	25.1	82.82	B
	<i>Биеийн тамир спортын газар</i>	34.98	26	26	86.98	B
	<i>Боловсрол соёлын газар</i>	35.9	26	22.4	83.8	B
	<i>Хүүхдийн төлөө хэлтэс</i>	36	26.8	26	88.8	B

Мөн аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний явцын тайланг улирал тутам гаргуулан авч, сумдын үйл ажиллагааг Засгийн газрын 51-р тогтоолыг үндэслэн боловсруулсан “Сумдын Засаг даргын Тамгын газрын ажлыг дүгнэх” журмын дагуу хагас жилээр, бүтэн жилээр Хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж дүгнэлээ.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Сүмбэр		Шивээговь		Баянтал		
			Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээний оноо	Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээний оноо	Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээний оноо	
I. Сайд, засаг дарга нарын бодлогын зорилтын хэрэгжилтийн үнэлгээ									
1	Засгийн газрын Бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн	хувь	40,5	2,0	41	2,1	62	3,1
		Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүн	хувь	71,1	3,6	83	4,2		0,0
		Засаг даргаас аймгийн Засаг даргатай байгуулсан батламжийн биелэлт	хувь	74	3,7	75	3,8	62	3,1
	Аймаг, сумын Бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн	хувь	38,3	1,9	42,2	2,1	38,1	1,9
		Сумын Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	хувь	71,5	3,6	76,6	3,8	70,2	3,5
		Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	хувь	49,2	2,5	36,5	1,8	0	0,0
2	Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүн	Аймгийн ИТХ-ийн тогтоол шийдвэрийн биелэлт	хувь		0,0		0,0		0,0
		Засгийн газрын тогтоолын биелэлт	хувь	78,3	3,9	84,4	4,2	72,7	3,6
		Аймгийн Засаг даргын захирамжийн биелэлт	хувь	85	4,3	71,6	3,6	57,3	2,9
		Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргын хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан гэрээний биелэлт	хувь	71	3,6	70	3,5	67	3,4
3	Төсвийн зардлын гүйцэтгэл	Сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн зарцуулалт	хувь	70	3,5	70	3,5	70	3,5
		Орон нутгийн орлогын төлөвлөгөөний бүрдүүлэлт	Хувь	100	5,0	100	5,0	90	4,5
II. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ									
					0,0		0,0		0,0

4	Сумдын төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт		хувь		0,0		0,0		0,0
5	хяналт-шинжилгээ	Хяналт шалгалтын үнэлгээ	оноо	40	2,0	60	3,0	40	2,0
		Хяналт-шинжилгээ үнэлгээ	оноо	54,3	2,7	63	3,2	53	2,7
6	Байгууллагын нээлттэй байдал	Санал, өргөдөл гомдлын барагдуулалтын мэдээ тайлангийн үнэлгээ	оноо	85	4,3	92,5	4,6	80	4,0
		Хугацаанд нь шийдвэрлэсэн санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	хувь	100	5,0	100	5,0	100	5,0
		Засаг даргын захирамж, бусад шийдвэрийн төсөлд иргэдийн саналыг тусгасан байдал	хувь		0,0		0,0		0,0
7	Мэдээ тайлангийн гаргалт, чанар		оноо	95,1	4,8	93,1	4,7	97,5	4,9
8	Цаг үеийн ажлын үнэлгээ		оноо	76,8	3,8	81	4,1	61,1	3,1
	Ерөнхий үнэлгээ		оноо	76,6	3,8	80	4,0	65,7	3,3

Дөрөв БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод, байдлын үнэлгээ:

4.1 Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал:

2009 онд төрийн албан хаагчдын иргэдэд үйлчлэх сэтгэлгээнд өөрчлөлт оруулах, Төрийн үйлчилгээг шуурхай хүнд сурталгүй болгоход илүү анхаарч ажиллалаа.

Ажлын ачаалал давхардлыг шат бүрээр судалж хэлтсүүдийн ажил үүргийг ил тод болгосон. Нийтээр дагаж мөрдөхөөр гарах шийдвэрийн төслийг эрх ашиг нь хөндөгдөх талд танилцуулж, тэдний санал бодлыг авч хэвшсэн.

Төрийн байгууллагууд иргэдэд нээлттэй байж шуурхай үйлчилдэг болгох зорилгоор албан хаагч бүрээр төрийн үйлчилгээний чиглэл, танилцуулга, иргэдэд үзүүлэх үйлчилгээний журмыг товч бичиж ил тод тавьж иргэдийн санал гомдлыг хүлээн авах, зөвөлгөө өгөх байр, санал хүсэлтийн хайрцаг, утас ажиллуулж байна.

Аймгийн ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, албад сар бүр нэг суманд *иргэдтэй ажиллах нээлттэй өдөрлөг*-ийг зохион байгуулж, удирдлагууд иргэдийг хүлээн авч санаа бодлыг нь сонсож, тэдний тавьсан асуудлыг хэрхэн шийдвэрлэснээ эргэн мэдээлж хэвшлээ.

Иргэдтэй ажиллах нээлттэй өдөрлөгийг сумдад 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 6641 иргэнд үйлчилгээ үзүүлж, 193 санал авч шийдвэрлэн, 4352 гарын авлага материал тарааж, 1900 иргэнээс санал асуулга авсан байна

“Нэг цонхны үйлчилгээ”-г нээн 9 төрлийн үйлчилгээг ажлын 5 өдөрт 10,00-16,00 цагт үйлчилгээ үзүүлж байна. Байгууллагууд иргэдэд үзүүлдэг үйлчилгээгээ, ажлын чиг үүргийг иргэдэд харагдахуйц байрлуулан хэвийн үйл ажиллагаагаа явуулж хэвшээд байна. “Нэг цонхны үйлчилгээ” нээгдэж иргэд төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой болсноор иргэд сэтгэл ханамжтай байна.

Энэ хугацаанд “Нэг цонхны үйлчилгээ”-ээр сард дунджаар 3921 иргэн, нийт 42089 иргэн үйлчлүүлээ.

Нэг цонхны үйлчилгээний талаар 5 асуултаар 60 гаруй иргэнээс санал асуулга авч нэгтгэн үйл ажиллагаандаа дүгнэлт хийн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нар тогтсон хуваарийн хуваарийн дагуу иргэдийг хүлээн авах байранд санал хүсэлтийг хүлээн авч, журмын дагуу шийдвэрлүүлж, хэрхэн шийдсэн тухайгаа эргэн мэдээлдэг болсон. Тайлант хугацаанд 33 иргэн ирж санал хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байна.

Төрийн болон үйлчилгээний байгууллагууд хуваарийн дагуу Пүрэв гариг бүр FM радиогийн ярилцлагад орж иргэдийн санаа бодлыг сонсож, тавьсан хүсэлтийг судалж зохих арга хэмжээ авч хэвшлээ. Энэ жилд нийт FM ярилцлагад 20 байгууллага оролцож, 68 иргэн холбогдож, өөрсдийн сонирхсон асуултанд хариултаа авсан байна

Сумдад ажиллах нээлттэй өдөрлөгөөр гэр, бусад эд материалын тусламж олгосон болон сумдын санал тавьсан айл өрхөөр орж амьдрал ахуйтай нь танилцдаг ажил хэвшил болж сард 14-20 өрхөөр нийт 91 өрхөөр орсон байна.

Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлт: Аймгийн хэмжээнд 11350 санал, өргөдөл, гомдол ирснээс 11197 буюу 98.7 хувь өргөдөл, хүсэлт, 153 буюу 1.3 хувийг гомдол эзэлж байна.

Нийт ирсэн өргөдөл гомдлын 11118 буюу 97.9 хувийг өөрсдөө шийдвэрлэж, 189 буюу 1.9 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлсэн байна.

Нийт өргөдөл, гомдлын 113-ыг амаар, 1-ыг цахим сүлжээгээр 11100-г бичгээр хүлээн авсан байна.

Агентлагуудад дээд газраас буюу аймгийн Засаг даргаас шилжүүлсэн 74 өргөдөл байгаагийн 65-ыг нь хугацаанд нь шийдвэрлэгдэж, хугацаа болоогүй 9 өргөдөл, хүсэлт байна.

2009 онд ажилд орох, мөнгөн тусламж хүссэн 446 буюу 3.9 хувь, иргэний гэр бүл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 1188 буюу 10.5 хувь, оршин суух, газар, орон сууц хүссэн өргөдөл 136 буюу 1.9 хувь, газар олгож өгөхийг хүссэн 384 өргөдөл буюу 3.4 хувийг эзэлж байна.

Иргэдийн санал хүсэлтийг байгууллагууд бичгээр, утсаар, веб хаягаар, “Иргэдтэй ажиллах Нээлттэй өдөрлөг”, “Нэг цонхны үйлчилгээ”, FM радиогоор авч, хугацаанд нь шийдвэрлэж хэвшээд байна.

Сумд багийн өдөрлөгийг тогтмолжуулж төрийн байгууллагууд ээлжээр ажлаа танилцуулж тавигдсан санал хүсэлтийн барагдуулалтыг дараагийн өдөрлөг дээр тайлагнаж хэвшсэн. Хөдөөгийн багуудын Засаг дарга нарыг унаатай болголоо.

4.2 Хүний нөөцийн ил тод байдал:

Нутгийн захиргааны байгууллагын туслах, гүйцэтгэх албан тушаалтнуудын сул орон тоог журмын дагуу нийтэд зарлаж, мэргэшлийн шалгалтаар, удирдах албан тушаалтнуудыг сонгон шалгаруулалтад оруулж, томилох эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлж, санал болгосны дагуу төрийн албанд томилох ажлыг журмын дагуу зохион байгуулж байна.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой төрийн жинхэнэ албанд түр хугацаагаар томилогдон ажиллаж байсан 42 албан хаагчийг ажлаас нь чөлөөлүүлэв. Төрийн захиргааны албан хаагчийн хэрэгцээ шаардлага, сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг байгууллагуудаас авч нийтэд зарлан 2009 онд төрийн жинхэнэ албан тушаалд орох мэргэшлийн шалгалтыг 2 удаа зохион байгуулж 68 ажлын байранд 150 иргэн шалгалтад орж 73 иргэн тэнцэж нөөцөд бүртгэгдсэн онооны дарааллаараа журмын дагуу зохих албан тушаалуудад томилогдон ажиллаж байна.

Мөн хугацаанд Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 10 ажлын байр, төсвийн байгууллагын Ерөнхий менежерийн 5 ажлын байранд сонгон шалгаруулалт явуулж томилох эрх бүхий этгээдэд хамгийн өндөр оноо авсныг нь санал болгож журмын дагуу томилуулав.

Манай аймагт мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалттай холбоотой маргаан, зөрчил гараагүй. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орсноос хойш, мэргэшлийн шалгалтад орж нөөцөд бүртгэгдээгүй иргэн төрийн захиргааны албанд түр томилогдоогүй.

Төрийн албан хаагчид болон туршилтаар ажиллаж байгаа албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулж, бодитой дүгнэж ажил хариуцах, хариуцлага хүлээх чадварыг сайжруулж, ажлын үр дүнд тавих хяналтыг тодорхой болгоход анхаарч ажиллаж байна.

Төрийн байгууллага бүр сургалтын хөтөлбөртэй болж нутгийн захиргааны албан хаагчдыг Удирдлагын академи дээр урт, богино хугацааны төлөвлөгөөт сургалтанд хуваарийн дагуу хамруулахын зэрэгцээ ажлын байран дээрх сургалтыг үр өгөөжтэй болгоход анхаарч ажиллаж байна. Ажлын байран дээрх зорилтот сургалтаас гадна байгууллага бүр багаар ажиллах, өдөр тутмын уулзалт, шавилан суралцах зэрэг хэлбэрүүдэд суралцаж байна.

Хөтөлбөр төслийн багтай хамтарч *Төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу*, *Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэл* зэрэг 4 сургалтыг зохион байгууллаа.

4.3 Төсвийн ил тод байдал:

Орон нутгийн төсвийн нийт зарлагын 92.3 хувьтай тэнцэх хэмжээний татварын орлогыг орон нутгийн өөрийн орлогоор бүрдүүлж байна. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл болон холбогдох мэдээллийг "Иргэдтэй ажиллах - Нээлттэй өдөрлөг", орон нутгийн сонин хэвлэл болон АЗДТГ-ын самбарт тавьж иргэд

байгууллагын танилцах боломжийг бүрдүүлж, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, оролцоог нэмэгдүүлж байна.

Иргэд байгууллагуудад хууль, эрх зүйн актын дагуу төлбөр, хураамжийг ногдуулж, газрын төлбөр, татвар, хураамжийн талаарх гарын авлага, материал, албаны сэтгүүл зэргийг ашиглан иргэдийг мэдээллээр ханган, үйлчилгээ үзүүлж байна.

Сумдын ЗДТГ азар сар бүр төсвийн гүйцэтгэлийг албан хаагчидадаа мэдээлдэг болсон.

Аймгийн төр захиргаа, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид Бага нуур дүүрэгт хэрэгжиж буй “Шилэн түрүүвч” хөтөлбөртэй танилцаж, туршлага судлан ажилдаа нэвтрүүлж байна.

“Мерси кор” ОУ-ын байгууллагатай хамтран төсвийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, бизнесийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, төсвийн зарцуулалтанд иргэний нийгмийн байгууллагаас хяналт тавих боломжийг бүрдүүлэх талаар нэг өдрийн сургалт зохион байгуулж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бизнэсийн байгууллагын төлөөлөгч, иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагын 3 талт гэрээ байгуулсан.

Орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор энэ онд хөрөнгө оруулалтын ажлуудыг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдээр гүйцэтгүүлж ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангасан.

4.4 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал:

Сангийн сайдын 2009 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 9-11/1101 тоот албан бичиг, Аймгийн Засаг даргын 2009 оны А/315 дугаар захирамжийн дагуу 2009 оны хөрөнгө оруулалтын бодлогыг орон нутгийн үйлдвэрлэгчдэд давуу эрх олгон, тэдний үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн ажилласны үр дүнд “Сүмбэр гүн” ХХК, “Лаки-дент” ХХК “Боржигин хүч” ХХК, Говь гоё хийц ХХК, МСҮТ, “Илчлэг-шивээ” ОНӨҮГ, “Талын илч” ОНӨҮГ, УБТЗ-ын эрчим хүчний орон нутаг дахь салбар тендерт шалгарч хөрөнгө оруулалтын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.

Босго үнэ батлах тухай МУЗГ-ын 2007 оны тогтоолын дагуу 100.0 сая төгрөгнөөс дээш өртөг бүхий ажлын тендерийг www.e-procurement.mn цахим хуудсанд байршуулахаар тогтсон бөгөөд энэ онд 100.0 сая төгрөгнөөс дээш өртөг бүхий ажил хийгдээгүй болно.

Сангийн сайдын 2008 оны 2-р сарын 12-ны өдрийн 58 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу хөрөнгө оруулалтын мэдээг сар бүрийн 3-ны дотор гэрээ байгуулсан Төсвийн ерөнхийлэн захирагчид болон Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газарт хугацаанд нь хүргүүлээ.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр 2 удаа сургалт явуулж нийт 46 албан хаагчдыг мэргэшүүлсэн.

2008 оны худалдан авах ажиллагаанд аудит хийлгэн дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн тавигдсан зөрчил, доголдлуудыг тухай бүр арилган хариуг мэдэгдсэн.

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

/2009 оны үйл ажиллагааны үр дүн /

	Үзүүлэлт	үр дүнгийн үнэлгээ		
		Хувь	оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	4. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт /2009 онд хүрэх түвшин 40 хувь/	41.7	5.0
		5. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /2009 онд хүрэх түвшин 40 хувь/	48.05	5.0
		6. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	77.8	3.89
Үнэлгээний дундаж оноо 4.6				
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	5. Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	81.25	4.1
		6. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	82.8	4.1
		7. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	94.4	4.7
		8. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /2009 онд хүрэх түвшин 50 хувь/	43.7	4.3
Үнэлгээний дундаж оноо 4.3				
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	3. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	85.0	4.2
		4. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	85.42	4.3
Үнэлгээний дундаж оноо 4.0				
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	5. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал	88.57	4.4
		6. Хүний нөөцийн ил тод байдал	85.0	4.3
		7. Төсөв санхүүгийн ил тод байдал	75.7	3.8
		8. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	86.0	4.3
Үнэлгээний дундаж оноо 4.2				
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	3. Эдийн засгийн нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	87.3	4.4
		4. Хэрэглэгчийн үнэлгээ	80.0	4.0
Үнэлгээний дундаж оноо 4.0				
Ерөнхий үнэлгээ		86.0	4.0	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.ТӨВСАНАА